


# Төлбөр тооцооны системийн хороо



## Төлбөр тооцооны системд хэрэглэгддэг нэр томъёоны тайлбар ТОЛЬ

2003 он 3 дугаар сар  
(Орчуулсан: 2010 оны 12 дугаар сар)



ОЛОН УЛСЫН ТӨЛБӨР ТООЦООНЫ БАНК

Энэхүү тайлбар толийг зөвхөн ОУТТБ-ны вэб сайт дээрээс авч болно. ([www.bis.org](http://www.bis.org)).

Анхны хэвлэл нь 2001 оны 1 дүгээр сард гарсан.

Шинэчлэгдсэн хэвлэл нь 2001 оны 6 дугаар сар болон 2003 оны 3 дугаар сард гарсан.

© Олон улсын төлбөр тооцооны банк 2003. Бүх эрх хамгаалагдсан. Эх сурвалжийг дурдсан нөхцөлд товч ишлэлийг хуулбарлаж, эсвэл орчуулж болно.

ISBN 92-9197-133-2 (online)

## Өмнөх үг

Төлбөр, тооцооны системийн хороо (ТТСХ) нь энэхүү дэлгэрэнгүй тайлбар толийг төлбөр, тооцооны системтэй холбоотой хэрэглэгддэг стандарт нэр томъёоны лавлагаа баримт бичиг байдлаар хэвлэн гаргадаг. Энэхүү тайлбар толийг ТТСХ болон Европын төв банк (ЕТБ)-ны урьд өмнөх тайлангуудад хавсарган гаргаж байсан төрөл бүрийн тайлбар толиудаас эмхэтгэн гаргасан болно.

Төлбөрийн систем нь эрх зүйн зохицуулалт, технологийн болон үйл ажиллагааны асуудлууд, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц болон мөнгөний бодлоготой холбогдож байдаг. Төлбөрийн системд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, эрсдэлийн менежмент, төлбөр тооцооны системийн хяналт зэрэг төв банкны үйл ажиллагаа болон бодлого боловсруулалтын үндэс болсон олон ойлголтуудын практик хэрэглээг авч үздэг. Төлбөрийн системийн бодлогыг төлөвлөхдөө өргөн хүрээ бүхий асуудлын олон талын хандлагыг тооцон, нарийвчилсан байдлаар зайлшгүй судалж үзэх шаардлагатай байдаг. Иймээс төлбөрийн системийн нэр томъёоллыг сайтар ойлгох нь системтэй холбоотой өдөр тутмын үйл ажиллагаа явуулдаг хүмүүс төдийгүй холбогдох бодлого боловсруулагч, санхүүгийн байгууллага, эрдэм шинжилгээний ажилтнуудад ч нэн чухал шаардлагатай юм. Төлбөр тооцооны системд холбогдох бүхий л нэр томъёо, ойлголтыг нэгтгэснээрээ, энэхүү тайлбар толь нь төлбөрийн системийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн стандарт нэр томъёоны лавлагаа байдлаар уншигчдад нэг утгатайгаар ойлгох боломж олгож, хэрэглэхэд хялбар эх баримт болгохыг зорьсон болно.

Уншигчид энэхүү тайлбар толийг ашигласнаар Хороо болон бусад санхүүгийн байгууллагаас хэвлэн гаргасан материал болон төлбөр тооцооны системийн талаарх ойлголтыг батжуулахад ихээхэн тус дөхөм болно гэдэгт зохиогчийн зүгээс найдаж байна.

ОУТТБ-ны вэб хуудас ([www.bis.org](http://www.bis.org)) дээр байршуулсан цахим хувилбар нь ТТСХ-ноос цаашид гаргах материалуудад ашигласан шинэ нэр, томъёогоор байнга шинэчлэгдэж байх болно.

Томасо Падоа-Шиоппа, Тэргүүлэгч  
Төлбөр Тооцооны Системийн Хороо

## Удиртгал

Сүүлийн жилүүдэд төлбөр тооцооны дэд бүтцийн хөгжил болон төлбөрийн боловсруулалтын нарийн төвөгтэй байдлын талаарх бидний мэдлэг нэмэгдэхийн хэрээр төлбөрийн системд хамаарах нэр томьёо нь тасралтгүй сайжирч, боловсронгуй болсоор ирсэн. Технологийн хөгжил нь биднийг техникийн мэргэжилтэн байх эсэхээс үл хамааран зайлшгүй ашиглагдаж байгаа шинэ нэр томьёог зохистой хэрэглэхийн чухлыг илүү тодоор харуулж байна. Тухайлбал, бодит цагийн боловсруулалт гэсэн ойлголт нь орчин үеийн төлбөрийн системийн ажиллагааг ойлгох чухал хэсэг болдог бөгөөд хэрэглэгч болон мэргэжилтний хоорондын харилцаанд байнга гарч ирж байдаг. Ихэнх тохиолдолд, төлбөрийн нэр томьёо нь шинэ ойлголт, ухагдахууныг гарган ирж байдаг судалгаа шинжилгээгээр баяжигдаж байдаг.

Иймд Төлбөр Тооцооны Системийн Хороо (ТТСХ) нь Европын Валютын Байгууллага (ЕВБ), Европын Төв Банк (ЕТБ) болон өөрийн тайлангуудад ашигласан нийт стандарт нэр томьёо болон тэдгээрийн тодорхойлолтуудыг нэгтгэн, тайлбар толь байдлаар хэвлэн гаргахаар шийдсэн. Энэхүү тайлбар толийн анхны хэвлэл нь 1992 онд гарсан *Үнэт цаасны төлбөр тооцооны систем дэх төлбөрийн эсрэг нийлүүлэлт* хэмээх тайлангаас оруулснаар хэвлэгдсэн. Төлбөрийн системийн нэр томьёонд өргөнөөр ашиглагддаг тодорхойлолтуудын стандартыг бүрдүүлэх зорилгоор “Улаан ном” эмхэтгэлийг 1993 онд анх гаргасан. Үүнээс хойш ТТСХ-оос шинээр тайлан гарах бүрт илүү олон нэр томьёог тасралтгүй нэмсээр байсан билээ. ЕВБ нь 1996 онд гарсан *Европын холбооны төлбөрийн системүүд* хэмээх “Цэнхэр ном”-ын тайлбар толийг гаргаснаараа дээрх эмхэтгэлийг арвижуулсан. Энэхүү нэр томьёог стандартчилах идэвх чармайлтыг ЕТБ төлбөрийн системийн талаарх тайлангуудаараа үргэлжлүүлсэн юм. Шинээр бэлтгэн гаргасан тайлан, материал бүрээр төлбөрийн системийн нэр томьёолол нэмэгдсээр байна.

Өнөөг хүртэл ТТСХ болон ЕТБ/ЕВБ-аас гаргасан нийт тайлбар толиудад ашигласан нэр томьёог энэхүү тайлбар тольд багтааж чадсан. Зарим тохиолдолд, нэг ижил нэр томьёог хэрэглэх хүрээнээс нь хамааран ялгаатай ойлголтыг тайлбарлахад ашигласан байгаа. Жишээлбэл, “зах зээлийн үнээр дахин үнэлэх” гэсэн нэр томьёо нь төлбөрийн системд деривативын хэлцлийн хүрээнд ойлгож байгаагаас ялгаатайгаар тодорхойлогддог. Иймэрхүү тохиолдол бүрт тухайн нэр томьёоны ялгаатай тодорхойлолтыг багтааж өгсөн. Ялгаатай тодорхойлолтуудын эх сурвалжийн лавлагааг сүүлийн багана дээр оруулж, тухайн томьёолол ямар төрлийн тайланд ашиглагдсаныг харуулснаараа уншигчдад шаардлагатай үед эргэж лавлах боломжийг олгосон билээ.

ОУТТБ-ны вэб сайт ([www.bis.org](http://www.bis.org)) дээр байршуулсан энэхүү хэвлэл нь шинээр хэвлэгдсэн тайлангуудад хэрэглэсэн нэр томьёог багтаахын тулд үргэлжлэн шинэчлэгдэх болно. Энэхүү баримт бичгийг хэрэглэгчдэд илүү ойр байлгаах үүднээс тайлбар тольтой холбоотой ямарваа санал, зөвлөгөөг уншигчдаас Төлбөр Тооцооны Системийн Хороонд ирүүлэхийг хүсэж байна.

Committee on Payment and Settlement Systems, Bank for International Settlements, CH-4002 Basel, fax: +41 61 280 9100; e-mail: [cps@bis.org](mailto:cps@bis.org) (subject line: Glossary).

Товчлол болон нэр томъёоны жагсаалт  
(2003 оны 1 дүгээр сар)

Тайлбар	Товчлол	Анх хэвлэгдсэн
Үнэт цаасны төлбөр тооцооны систем дэх төлбөрийн эсрэг нийлүүлэлт	DVP	1992 оны 9 сар
Жи-10 улсын төлбөрийн системүүд	Red Book	1993 оны 12 сар
Хил дамнасан үнэт цаасны төлбөр тооцоо	x-border	1995 оны 3 сар
Валют арилжааны гүйлгээн дэх төлбөр тооцооны эрсдэл	FX	1996 оны 3 сар
Европын холбооны төлбөрийн систем (Цэнхэр ном)	Blue Book	1996 оны 4 сар
Цахим мөнгөний нууцлал	EM-Sec	1996 оны 8 сар
Цахим мөнгийг хөгжүүлэхэд төв банкны оролцоо	EM-CPSS	1996 оны 10 сар
Үнэт цаасны төлбөр тооцооны системийн ил тод байдал	SDF	1997 оны 2 сар
Арилжаа-солилцооны деривативын клирингийн зохицуулалт	ETDC	1997 оны 3 сар
Цахим мөнгөний тайлан	EM-ECB	1998 оны 8 сар
Биржийн бус деривативийн тайлан: төлбөр тооцооны ажиллагаа болон оролцогч талын эрсдэлийн менежмент	OTC	1998 оны 9 сар
Үнэт цаас зээлдүүлэх гүйлгээ: зах зээлийн хөгжил болон оролцоо	SLT	1999 оны 7 сар
Европын холбооны гишүүнээр элсэх хүсэлт гаргасан улсуудын төлбөрийн системүүд	Blue Book	1999 оны 8 сар
Сонгогдсон улсууд дахь бага дүнтэй төлбөрийн системүүд	Retail	1999 оны 9 сар
Системийн хувьд нэн чухал төлбөр системүүдийн суурь зарчмууд	Core Principles	2001 оны 1 сар
Үнэт цаасны төлбөр тооцооны системд зориулсан зөвлөмж	SSS	2001 оны 11 сар

### Эх сурвалжийн талаарх тэмдэглэгээ

Эх сурвалж заасан багананд тухайн нэр томъёог тодорхойлсон бүх тайлангийн товчлолыг жагсаасан. Дараах томъёолсон тэмдэглэгээг ашигласан болно.

- Тод буюу **bold** үсгээр тэмдэглэсэн эх сурвалж: тухайн тодорхойлолтын үндсэн эх сурвалж болохыг голчлон заана. Өөрөөр хэлбэл, ихэвчлэн тухайн нэр томъёог анх тодорхойлсон тайланг заана.
- Ташуу буюу *italic* үсгээр тэмдэглэгдсэн эх сурвалж: тайлбар нь тухайн тайланд тодорхойлогдсон үндсэн утга санааг өөрчлөөгүй боловч бага зэргийн ялгаатай утгаар тайлбарлагдсан байж болохыг заана. Зарим тохиолдолд, холбогдох тайланд тодорхойлогдсон утгыг илүү дэлгэрэнгүй, нарийвчилсан утгын тайлбарыг харуулна.

## Тайлбар толь

Нэр томьёо	Тодорхойлолт	Эх сурвалж
<b>төлбөр тооцоонд хүлээн зөвшөөрөх (acceptance for settlement)</b>	системийн дүрэм, журмын дагуу төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтой, бүхий л эрсдэлийн удирдлагын болон бусад сорилыг давж чадсан төлбөрийг боловсруулах үе шат	<b>Core Principles</b>
<b>төлбөр хүлээн авагч (acceptor)</b>	цахим мөнгөний хэрэгслээр дамжуулан бараа/үйлчилгээний төлбөрийг өөрийн нэрээр эсвэл өөрийн сүлжээний нэрээр хүлээж авах аливаа нэгэн худалдааны/үйлчилгээний байгууллага	<b>EM-ECB</b>
<b>хандалт (access)</b>	харилцагчийн эсвэл өөрийн дансаар төлбөр тооцоог гүйцэтгэхийн тулд тодорхой төлбөрийн системийн үйлчилгээг ашиглах байгууллагын эрх буюу боломж. Шууд оролцогч, шууд оролцогч/гишүүн, шууд бус оролцогч/гишүүн, оролцогч/гишүүн -г мөн харна уу.	<b>Core Principles</b>
<b>хандалтын хэрэгсэл (access products)</b>	харилцагчдад өөрийн харилцах/хадгаламжийн данс руу хандалт хийх, дансандаа шилжүүлэг хийх боломжийг олгодог төлбөрийн хэрэгсэл. ПОС болон гэрээс банкны үйлчилгээ авах төхөөрөмжүүд дээрх цахим хөрөнгийн шилжүүлгүүдийг жишээг нэрлэж болно.	<b>EM-ECB</b> <i>EM-CPSS</i>
<b>тайлагнах боломж (accountability)</b>	цахим мөнгөний гүйлгээний бүртгэл хөтлөх	<b>EM-ECB</b>
<b>АКТ (ACH)</b>	автоматжуулсан клирингийн төв-г харах	<b>EM-ECB</b>
<b>эквайрер (acquirer)</b>	картаар үйлчлэгч байгууллагын (КҮБ)-ийн харилцах дансыг өөр дээрээ байршуулж, КҮБ-аас гүйлгээтэй холбоотой мэдээг хүлээн авах байгууллага. Эквайрер нь гүйлгээний мэдээллийг цуглуулах, КҮБ-тэй төлбөр тооцоо хийх үүрэгтэй.	<b>EM-ECB</b>
<b>эквайрингийн техникийн оператор (acquiring technical operator)</b>	гүйлгээ нэг бүртэй холбоотой мэдээллийг хүлээн авахад зориулж эквайрингийн үйлчилгээ үзүүлдэг байгууллага бүрийг техник тоног төхөөрөмжөөр хангаж буй этгээд.	<b>EM-ECB</b>
<b>урьдчилсан үр дүнгийн тооцоо (advisory netting)</b>	позицийн үр дүнгийн тооцоог харна уу	<b>Red Book</b> <b>Blue Book</b>

<b>агентын харилцаа (agency relationship)</b>	гэрээний нэг тал болох агент нь нөгөө тал болох үндсэн этгээдийг төлөөлөхөөр гэрээний дагуу хүлээсэн харилцаа. Агент нь үндсэн этгээдийн өмнөөс арилжаа хийж болох боловч үндсэн этгээдийн өмнөөс үр дүнг хариуцдаггүй.	<b>ETDC</b>
<b>агент (agent)</b>	үнэт цаасны зээлийг хариуцаж, эзэмшигч-харилцагчийн өмнөөс зээлдэгчтэй нөхцөлүүдийн талаар хэлэлцэн тохиролцдог хөрөнгийн менежер эсвэл кастодиан зэрэг байгууллага.	<b>SLT</b>
<b>БТС (APS)</b>	баталгаажсан төлбөрийн систем-г харна уу.	
<b>арбитраж (arbitrage)</b>	хоёр буюу түүнээс олон зах зээл дээр арилжаалагдаж байгаа ижил төрлийн үнэт цаас, валют эсвэл бараа таваарын үнийн зөрүүнээс ашиг олох ажиллагаа.	<b>SLT</b>
<b>баталгаажсан төлбөрийн систем (assured payment system)</b>	гуравдагч этгээдийн (ерөнхийдөө банк, банкны синдикат буюу клирингийн төв) үл буцаагдах болон нөхцөлт бус амлалтын дагуу төлбөрийн даалгаврын төлбөр тооцоог цаг тухайд нь гүйцэтгэх талаарх хөрөнгийн дүнгээр солилцох систем дэх зохицуулалт	<b>DVP Red Book Blue Book</b>
<b>асимметрик криптограф (asymmetric cryptography)</b>	мэдээллийг инкриптлэх болон дикриптлэхэд ашиглагдах ялгаатай хоёр түлхүүр (нууц болон нээлттэй) бүхий криптографийн аргачлалын иж бүрдэл. Нээлттэй түлхүүр нь мэдээлэл дамжуулах байгууллагуудад чөлөөтэй ашиглагдахаар байдаг бол нууц түлхүүр нь зөвхөн тухайн түлхүүр эзэмшигчид хадгалагддаг. Үүнийг мөн нээлттэй түлхүүрт криптограф гэж нэрлэх нь бий.	<b>EM-Sec</b>
<b>АТМ (ATM)</b>	автомат теллер машин-г харна уу.	
<b>аудит хийгдэх боломж (auditability)</b>	систем зохистой ажиллаж байгаа эсэх болон цаашид ч зохистой ажиллах эсэхийг тогтоох боломж гэсэн утгатайгаар ойлгогддог. Аудит хийгдэх боломжийн нэг тал нь зохих баримтжуулалтын тусламжтайгаар систем, түүний бүтэц, функц, хяналт зэргийн талаарх хангалттай мэдлэгээр хангах явдал. Нөгөө чухал тал нь систем болон түүний өгөгдлийн цогц байдалд холбоотой бүхий л өөрчлөлтүүдийг ил болгох явдал байдаг. Өгөгдлийн өөрчлөлтийн хөтлөлт (logging data) нь "хэн?", "юу?", "хэзээ?" гэсэн асуултад хариулах боломжтой байх ёстой.	<b>EM-ESB</b>

<b>аудитын үл мөр (audit trail)</b>	системд тохиолдсон үйл явцуудын дэс дараалсан бичлэг.	<b>EM-Sec</b>
<b>жинхэнэ эсэхийг тогтоох (authentication)</b>	мэдээний үүслийг баталгаажуулах эсвэл системд холбогдож буй оролцогчийн мөн эсэхийг шалгах болон дамжуулалтын явцад мэдээнд өөрчлөлт ороогүй, солигдоогүй гэдгийг батлахад ашиглагдаж буй аргууд.	<b>EM-CPSS</b> Core Principles
<b>автоматжуулсан клирингийн төв (automated clearing house)</b>	төлбөрийн даалгавруудыг санхүүгийн байгууллагуудын хооронд гол төлөв соронзон мэдээллийн хэрэгсэл эсвэл цахилгаан холбооны сүлжээгээр солилцож, өгөгдөл боловсруулах төвд боловсруулдаг цахим клирингийн систем. clearing/clearance-г харна уу.	<b>Red Book</b> Blue Book
<b>автомат теллер машин (automated teller mashine)</b>	машинаар уншигдах боломжтой пластик карт ашиглан данснаасаа бэлэн мөнгө авах эсвэл дансны үлдэгдэл шалгах, мөнгө шилжүүлэх буюу орлого хийх зэрэг бусад үйлчилгээг авах боломжийг эрх бүхий хэрэглэгчдэд олгож буй цахилгаан-механик төхөөрөмж. АТМ нь эрх баталгаажуулалтын өгөгдлийн сантай бодит цагийн хандалт бүхий онлайн эсвэл офлайн горимд ажилладаг байж болно.	<b>Red Book</b> Blue Book <i>Retail</i>
<b>бэлэн байдал (availability)</b>	шаардлагатай үедээ хэрэглэгч үйлчилгээ болон мэдээллийг олж авах боломж	<b>EM-Sec</b>
<b>арын алба (back office)</b>	арилжаа биелэгдсэнээс хойших ажиллагааг хариуцдаг байгууллагын нэгж. Байгууллагын зохион байгуулалтын бүтцээс хамааран арын алба нь нэг газар эсвэл хэд хэдэн нэгж (жишээ нь, баримт бичиг боловсруулалтын, эрсдэлийн удирдлагын, нягтлан бодох бүртгэлийн болон төлбөр тооцооны)-ээс бүрдэж болдог. Зарим байгууллага эдгээр үүргүүдээс ихэнхдээ арын албанд харъяалагдах, ялангуяа эрсдэлийн удирлагатай холбоотой хэсгийг дундын албаны үүрэгт оруулан зохион байгуулдаг. арилжааны алба-г харна уу.	<b>OTC</b>



<p><b>ар араасаа хийгдэх арилжаа (back-to-back trades)</b></p>	<p>оролцогч тал нь ямар нэгэн үнэт цаасыг хүлээн аваад тухайн өдөртөө ижил төрлийн үнэт цаасыг буцаан шилжүүлэх хос гүйлгээ. Ийм гүйлгээнүүд нь газар дээр нь хийх худалдан авалт болон худалдаа эсвэл барьцааны гүйлгээтэй (репо гэрээ буюу үнэт цаасны зээл) холбоотой байж болно. Жишээлбэл, үнэт цаасны дилер нэг ижил үнэт цаасыг тухайн өдөрт нь харилцагчдын зах зээлийн үйл ажиллагаанд зориулан худалдаж, худалдан авах эсвэл бүртгэлд зориулж үнэт цаас худалдан авах мөн репо хэлцлийн позицийг санхүүжүүлж болно.</p>	<p><b>x-border</b></p>
<p><b>ар араасаа хийгдэх гүйлгээ (back-to-back transactions)</b></p>	<p>гурав буюу түүнээс дээш оролцогч талуудын хооронд нэг үнэт цаасыг төлбөр тооцооны нэг өдөрт худалдах, худалдан авахтай холбоотой үнэт цаасны цуваа гүйлгээ. Хамгийн энгийн ар араасаа хийгдэх гүйлгээ бол эхний түнш хоёрдогч түншээс үнэт цаасыг худалдан авч, дараа нь түүнийгээ гуравдагч түншид худалдах гүйлгээ юм.</p>	<p><b>Blue Book SLT</b></p>
<p><b>ар араасаа хийгдэх гүйлгээ (back-to-back transactions)</b></p>	<p>оролцогч тал нэг үнэт цаасыг хүлээн аваад тухайн өдөртөө ижил төрлийн үнэт цаасыг буцаан шилжүүлэх хос гүйлгээ. Ийм гүйлгээнүүд нь газар дээр нь хийх худалдан авалт болон худалдаа эсвэл барьцааны гүйлгээтэй (репо гэрээ буюу үнэт цаасны хэлбэртэй зээл) холбоотой байж болно. Жишээлбэл, үнэт цаасны дилер нэг ижил үнэт цаасыг тухайн өдөрт нь харилцагчдын зах зээлийн үйл ажиллагаанд зориулан худалдаж, худалдан авах эсвэл бүртгэлд зориулж үнэт цаас худалдан авах мөн репо хэлцлийн дагуу позицийг санхүүжүүлж болно.</p>	<p><b>SSS</b></p>
<p><b>балансын систем (balance-based system)</b></p>	<p>тоон бүртгэл бүхий төхөөрөмжид цахим хөрөнгүүд нь хадгалагддаг, гүйлгээнүүд нь балансад дебит эсвэл кредитээр хийгдэх цахим мөнгөний систем.</p>	<p><b>Blue Book EM-Sec</b></p>

<b>банкны вексель (bank draft)</b>	Европт энэхүү нэр томьёо нь ихэвчлэн аливаа нэгэн вексель гаргасан банкны өөрийнх нь вексельд хамаардаг. Энэ векселийг төлбөр төлөгч худалдан авч, төлбөр авагчид илгээдэг ба төлбөр авагч үүнийг өөрийн банкиндаа төлбөрт өгдөг. Уг банк үүнийг төлбөр төлөгчийн банкинд өгч солиулж авдаг. АНУ-д энэ нэр томьёог тухайн банкны өөрийн эсвэл өөр банкны байршуулсан хөрөнгөд гаргасан вексель болон чекэд хамааруулж ойлгодог. Банк өөрийн нэр дээр бичсэн чек (cashier's cheque)-ийн хувьд банк нь төлбөр нэхэмжлэгч болон төлбөр хариуцагч аль аль нь болдог. Теллерийн чекийн хувьд нэг банк нь төлбөр нэхэмжлэгч, нөгөө банк нь төлбөр хариуцагч болдог. Банкны векселийг банкны өөрийн зорилгоор бичих эсвэл харилцагч худалдсанаар бичиж болох ба төлбөрийн үүргээ гүйцэтгэхийн тулд төлбөр хүлээн авагчид шилжүүлдэг. вексель-г харна уу.	<b>Red Book</b>
<b>банкны нөөц (bank reserves)</b>	төв банкинд байршуулсан банкуудын харилцах, хадгаламж	<b>EM-CPSS</b>
<b>суурийн эрсдэл (basis risk)</b>	суурь дахь өөрчлөлтийн эрсдэл, өөрөөр хэлбэл, фьючерс буюу форвард хэлцлийн үнэ болон үндсэн активын үнийн хоорондын зөрүү.	<b>ETDC</b>
<b>багц (batch)</b>	хугацааны тодорхой интервалд багцлагдсан бүлэг төлбөрийн даалгаврууд болон/эсвэл үнэт цаасны шилжүүлгийн даалгавруудын боловсруулалт буюу дамжуулалт.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>ашиг хүртэх эзэмшил/ сонирхол (beneficial ownership/ interest)</b>	үнэт цаас буюу санхүүгийн бусад хэрэгслийг (жишээ нь орлого, саналын эрх, шилжүүлгийн эрх) эзэмшсэнээр зарим нэг эсвэл бүх ашиг орлогыг хүртэх эрх. Ашиг хүртэх эзэмшил нь ихэвчлэн үнэт цаас буюу санхүүгийн хэрэгслийн "хууль ёсны эзэмшил"-ээс ялгаатай байдаг. Хууль ёсны эзэмшил-г харна уу.	<b>DVP Red Book Blue Book SLT</b>
<b>хоёр талын зээлийн хязгаар (bilateral credit limit)</b>	зээлийн хязгаар-г харна уу.	<b>Core Principles</b>
<b>хоёр талын эрсдэлийн дүн (bilateral exposure)</b>	нэг тал нь нөгөө талаа өртүүлж байгаа эрсдэлийн дүн	<b>Core Principles</b>

<b>хоёр талын үр дүнгийн төлбөр тооцооны систем (bilateral net settlement system)</b>	оролцогчдын хоёр талын харилцан суутгах үр дүнгийн төлбөр тооцооны позици нь оролцогчдын хоёр талын хослол бүрийн хооронд тооцоологддог төлбөр тооцооны систем.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>хоёр талын үр дүнгийн тооцоо (bilateral netting)</b>	хоёр талын өр төлбөрийг харилцан суутгах хоёр талын хоорондын зохицуулалт. Энэхүү өр төлбөр нь санхүүгийн хэлцэл, шилжүүлэг эсвэл хоёулангаас нь бий болох зохицуулалтыг агуулна. Олон талын үр дүнгийн тооцоо, үр дүнгийн тооцоо, үр дүнгийн тооцоо –г мөн харна уу.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>шилжих вексель (bill of exchange)</b>	тодорхой хэмжээний мөнгөн хөрөнгийг шаардсан үед эсвэл тогтоосон хугацаанд вексель бичигч эсвэл вексель бичигчийн тодорхойлсон гуравдагч этгээдэд төлөхийг тохиролцсоноор нэг тал (вексель бичигч)-аас нөгөө тал (төлбөр хариуцагч)-д бичсэн даалгавар.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>биометр (biometric)</b>	хурууны хээг тулгах, дуу хоолойгоор таних, нүдний торлог бүрхэвчээр шинжих зэрэг эзэмшигчийн бие махбодийн давтагдашгүй шинжийг жишин үзэх замаар төхөөрөмжийн эзэмшигчийг тодорхойлох аргатай холбоотой.	<b>EM-Sec</b>
<b>бит (bit)</b>	өгөгдөл дүрслэх үндсэн элемент: нэг бол 0 эсвэл 1 байх хоёртын тэмдэгт.	<b>EM-Sec</b>
<b>цахим бүртгэлийн систем (book-entry system)</b>	цаасан баримт буюу сертификатын биет шилжүүлэг хийлгүй нэхэмжлэлийн дагуу шилжүүлэг хийхийг (жишээ нь, үнэт цаасны цахим шилжүүлэг) зөвшөөрдөг бүртгэлийн систем. Биет бус хэлбэрт шилжүүлэх, эргэлтэд оруулахгүй байхыг мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>DVP</b> <b>x-border</b> <b>SLT</b>
<b>гүүр (bridge)</b>	"гүүр" гэдэг нь нэг ОУТХТ (олон улсын төвлөрсөн хадгаламжийн төв)-ийн оролцогч болон өөр ОУТХТ-ийн оролцогчийн хооронд хийгдэж байгаа арилжааны систем-дамнасан төлбөр тооцоог хийдэг, Euroclear ба Clearstream-ийн хооронд нь холбоход зориулан хэрэглэдэг ерөнхий нэр.	<b>x-border</b>
<b>брокер (broker)</b>	боломжит үндсэн оролцогчдод эрэлт нийлүүлэлтийн түвшний талаар мэдээлж, агентын хувьд шимтгэл авахын тулд арилжааг зохион байгуулж байгаа, уг арилжааны оролцогч биш байгууллага.	<b>OTC</b>

<b>брокер-дилер (broker-dealer)</b>	үнэт цаасны гүйлгээнд заримдаа брокерын үүрэг гүйцэтгэж, заримдаа үндсэн зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг хувь хүн буюу байгууллага. Брокер гэж боломжит үндсэн оролцогчдод эрэлт нийлүүлэлтийн түвшний талаар мэдээлж, агентын хувьд шимтгэл авахын тулд арилжааг зохион байгуулж байгаа, уг арилжааны оролцогч биш байгууллага.	<b>SLT</b>
<b>ихэнх хөрөнгийн шилжүүлгийн систем (bulk funds transfer system)</b>	бага дүнтэй төлбөрийн систем-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>тасралтгүй байдал (business continuity)</b>	хэрвээ системийн нэг буюу түүнээс олон бүрэлдэхүүн хэсэг гэмтэхэд эсвэл гадны, хэвийн бус үйл явдал нөлөөлөхөд үйлчилгээний байвал зохих төвшнийг хангахыг баталгаажуулахад чиглэсэн төлбөрийн системийн зохицуулалт. Энэ нь болзошгүй нөхцөлийг шийдэх шийдвэр болон урьдчилан сэргийлэх арга хэмжээг хоёуланг нь багтаасан байна.	<b>Core Principles</b>
<b>худалдан авалт (buy-in)</b>	арилжааны нөхцөл (жишээ нь, төлбөр тооцоо хийгдэх огноо)-ийн дагуу зээлдэгч нь зээлдүүлэгчид үнэт цаасыг шилжүүлэх боломжгүй болсон үед зээлдүүлэгчийн нээлттэй зах зээл дээрээс үнэт цаас худалдан авах үйл ажиллагаа. Ийм тохиолдолд зээлдэгч бүх зардлыг хариуцдаг.	<b>SLT</b>
<b>байт (byte)</b>	8 битийн дараалал.	<b>EM-Sec</b>
<b>эргэн дуудагдах зээл (call money)</b>	хэрвээ зээлдүүлэгч эсвэл зээлдэгч нь богино хугацааны дотор хөрөнгийг буцаагдах тухай мэдэгдээгүй тохиолдолд өдөр бүр автоматаар хугацаа нь сунгагдаж байдаг зээлийн гэрээ.	<b>Red Book Blue Book</b>
<b>хөрөнгийн эрсдэл (capital risk)</b>	үндсэн дүнгийн эрсдэл-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>хязгаар (caps)</b>	системийн бие даасан оролцогч бүрийн хөрөнгийн шилжүүлгийн ажиллагаанд тавигдсан тоон хязгаарлалт. Энэ хязгаарлалтыг оролцогч бүрээр тогтоох эсвэл системийг зохицуулж буй этгээд нь тогтоож болно. Түүнчлэн энэ хязгаарыг системийн оролцогчийн цэвэр дебит эсвэл цэвэр кредит позици дээр тавьж болно.	<b>DVP</b>

<b>карт (card)</b>	бэлэн мөнгөний карт, чекээр баталгаажсан карт, чип карт, кредит карт, дебит карт, хойшлуулах дебит карт, карт, урьдчилсан төлбөрт карт, жижиглэнгийн худалдааны карт, аялал жуулчлал болон энтертайнментийн карт-г харна уу.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>картад суурилсан бүтээгдэхүүн (card-based products)</b>	харилцагчид зөөврийн, тусгай зориулалтын компьютерын төхөөрөмж буюу ерөнхийдөө бичил процессорын чип агуулсан нэгдсэн схем бүхий картаар үзүүлж буй цахим мөнгөний бүтээгдэхүүн.	<b>EM-ECB</b>
<b>жишгээр шийтгэх хууль эрх зүй (case law)</b>	шүүхийн хэргийн ирээдүйн байр суурь эсвэл хууль эрх зүйн ирээдүйн тайлбарт нөлөөлж болох өмнө шийдсэн шүүхийн практикт үндэслэсэн үлгэрчлэх жишээ.	<b>Core Principles</b>
<b>бэлэн мөнгөний карт (cash card)</b>	зөвхөн АТМ буюу бэлэн мөнгө олгогч төхөөрөмжид ашиглахад зориулагдсан карт (бусад картууд нь ихэвчлэн эзэмшигч бэлэн мөнгө авах боломж бүхий бэлэн мөнгөний функцтэй байдаг).	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>бэлэн мөнгөний клиринг (cash clearing)</b>	позицийг нь зах зээлийн үнээр тодорхой хугацаагаар дахин үнэлдэг бөгөөд үүсэх үүргүүдийг бэлэн төлбөрөөр барагдуулдаг, хэлбэлзлийн маржин гэж нэрлэгдэх, фьючерс гэрээн дээр хэрэглэгддэг клирингийн арга.	<b>ETDC</b>
<b>төлбөрийн корреспондент (cash correspondents)</b>	ҮЦТТС-ийн төлбөр хийх эсвэл хүлээн авахдаа ашиглаж буй банк (буюу ижил төстэй байгууллагууд).	<b>SDF</b>
<b>бэлэн мөнгө хадгалуулах эрсдэл (cash deposit risk)</b>	үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоог хийх зорилгоор зуучлагчид бэлэн мөнгө байршуулахтай холбоотой үүсэх зээлийн эрсдэл.	<b>x-border SLT</b>
<b>бэлэн мөнгө олгох төхөөрөмж (cash dispenser)</b>	ихэвчлэн карт-уншигч машинд уншдаг пластик карт ашиглан мөнгөн тэмдэгт (валют) түүнчлэн зарим тохиолдолд зоосон мөнгө авах боломжийг хэрэглэгчдэд олгодог цахилгаан-механик төхөөрөмж. Автомат теллер машин-г мөн харна уу.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>бэлэн мөнгөнд суурилсан үнэт цаасны зээлийн гүйлгээ (cash-driven securities lending transactions)</b>	үнэт цаасны репо (эсвэл зээл)-оор дамжуулан мөнгөн хөрөнгийг зээлэх/хөрөнгө оруулах хүсэлттэй холбоотой хийгдэх гүйлгээ.	<b>SLT</b>
<b>банк өөрийн нэр дээр бичсэн чек (cashier's cheque)</b>	банкны вексель-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>

<b>бэлэн мөнгөний меморандумын тооцоо (cash memorandum accounts)</b>	оролцогчдын үнэт цаасны төлбөр тооцоотой холбоотойгоор тэдгээрийн төлж байгаа болон хүлээн авч байгаа хөрөнгийн ҮЦТТС-д хадгалагдаж байгаа бичилт. Энэхүү бичилт нь ҮЦТТС болон түүний оролцогчдын хоорондын хууль зүйн нэхэмжлэл буюу өр төлбөрийг илэрхийлэхгүй бөгөөд зөвхөн мэдээллийн зорилготой юм.	<b>SDF</b>
<b>бэлэн мөнгөний төлбөр тооцооны агент (cash settlement agent)</b>	ҮЦТХТ (CSD)-д хийгдэж буй үнэт цаасны шилжүүлгээс үүссэн эцсийн төлбөрийн үүргийг гүйцэтгэхэд хөрөнгөө ашиглуулж буй байгууллага. Бэлэн мөнгөний төлбөр тооцооны агентын дансыг төлбөр тооцооны банкинд байршуулдаг бөгөөд энэхүү банк нь тухайн агентын үйл ажиллагаанаас гадна нь төлбөр тооцооны агентын дансгүй оролцогчдоод төлбөрийн үйлчилгээг санал болгох боломжтой юм. Төлбөр тооцооны агент-г мөн харна уу.	<b>SSS</b>
<b>төв банкны үнэт цаас (central bank bills)</b>	зах зээлд түргэн борлогдох чадвартай буюу хөрвөх чадвар сайтай, төв банкнаас гаргасан богино хугацааны үнэт цаас.	<b>EM-CPSS</b>
<b>төв банкны (төлбөр түргэн гүйцэтгэх чадварын) зээл (central bank credit (liquidity) facility)</b>	төв банкинд тодорхой данс эзэмшигчдийн (тухайлбал, банкууд) ашиглаж болох байнгын зээлийн хэрэгсэл. Энэ зээлийг зарим тохиолдолд данс эзэмшигчийн хүсэлтээр автоматаар ашигладаг ч бусад тохиолдолд төв банк дураараа тогтоож болдог. Энэхүү зээлийг нь ихэвчлэн нэг бол үнэт цаас барьцаалан (Европын зарим орнуудад ломбардын зээл гэдэг) данс эзэмшигчийн харилцах дансанд зээллэг буюу овердрафт хэлбэртэйгээр эсвэл векселийг дахин бүртгэх уламжлалт хэлбэрээр авч болно.	<b>Red Book Blue Book DVP</b>
<b>үнэт цаасны зуучлагч (central counterparty)</b>	тодорхой бирж эсвэл биржүүд дээр хийгдэж байгаа хэлцэл гэх мэтийн тусгайлан байгуулсан гэрээний үндсэн дээр бүх худалдагчийн хувьд худалдан авагч, бүх худалдан авагчийн хувьд худалдагч болдог байгууллага.	<b>ETDC SSS</b>
<b>төв тооцоолох хэсэг (central processing unit)</b>	компьютерын систем дээрх тооцооллыг гүйцэтгэдэг (болон интеграл схемт картуудын) хэсэг.	<b>EM-Sec</b>

<b>үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв (central securities depository)</b>	үнэт цаасны гүйлгээг биет шилжүүлэг хийлгүйгээр бүртгэн боловсруулах боломжтой болгож, үнэт цаасыг хадгалж буй байгууллага. Биет үнэт цаасыг хадгаламжийн төв нь эргэлтэд оруулалгүй байлгах буюу эсвэл үнэт цаасыг материаллаг бус (өөрөөр хэлбэл, үнэт цаас нь зөвхөн цахим бичилтийн үндсэн дээр байхаар) хэлбэртэй болгох боломжтой юм. Хадгалах үүргээс гадна ҮЦТХТ нь хэлцэл биелсэн эсэхийг мэдээлэх, клиринг, төлбөр тооцоо хийх үүргийг гүйцэтгэж болно.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <i>DVP</i> <i>x-border</i> <i>SLT</i>
<b>сертификат/өрийн бичиг (certificate)</b>	гаргагчийн өр төлбөр буюу төлөгдөөгүй бусад санхүүгийн үүргийн талаар эзэмшигчийн нэхэмжлэлийн эрхийг гэрчилж буй биет баримт.	<b>Red Book</b>
<b>сертификат/өрийн бичиг (certificate)</b>	үнэт цаас буюу санхүүгийн хэрэгслийг гаргагчийн үүрэг амлалтыг гэрчилж буй цаас.	<b>DVP</b>
<b>сертификат олгогч (certification authority)</b>	нээлттэй түлхүүрийн сертификатыг үүсгэж, олгох эрх бүхий байгууллага	<b>EM-Sec</b>
<b>ЗНГ (CFD)</b>	зөрүүтэй нөхцөлийн гэрээ-г харна уу.	
<b>цуваанд оруулах (chaining)</b>	тодорхой шилжүүлгийн системд (ихэвчлэн үнэт цаасны хувьд) төлбөрийн даалгаврын боловсруулалт хийхдээ хэрэглэдэг арга. Энэ нь шилжүүлгийн дүн буюу тоо ширхгийг өсгөхийн тулд бэлэн байгаа мөнгөн хөрөнгө болон/эсвэл үнэт цаасны үлдэгдэл (эсвэл бэлэн байгаа зээлийн буюу үнэт цаасны зээлийн шугам)-д тохируулан төлбөр тооцоог гүйцэтгэх боломжтойгоор төлбөрийн даалгавруудыг боловсруулж байгаа дарааллын арга юм.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>асуулт-хариулт (challenge-response)</b>	нэг төхөөрөмж нь нөгөө төхөөрөмжийн асуултад өмнө тодорхойлогдсон байдлаар хариу өгснөөр жинхэнэ эсэхийг шалган тогтоох арга. Ингэснээр жинхэнэ эсэхийг баталгаажуулдаг.	<b>EM-Sec</b>
<b>цэнэглэгдэх карт (charge card)</b>	аялал жуулчлалын болон энтертайментийн карт-г харна уу.	<b>Retail</b>

<b>чек (cheque)</b>	чек эзэмшигчээс чек олгогч буюу түүний тодорхойлсон гуравдагч этгээдэд шаардсан үед нь тодорхой мөнгийг төлөхийг үүрэг болгон нэг тал (чек олгогч)-аас нөгөө тал (чек эзэмшигч ихэнх тохиолдолд банк)-даа бичгээр гаргасан даалгавар. Чекийг өр төлбөр төлөх болон банкнаас мөнгө авахад ашиглаж болно. Шилжих вексель-г харна уу.	<b>Red Book</b> <i>Blue Book</i> EM-CPSS Retail
<b>чекээр баталгаажсан карт (cheque guarantee card)</b>	чекээр баталгаажсан системийн нэг хэсэг болгон гаргасан карт. Энэ функц нь бэлэн мөнгөний карт болон дебит карт зэрэг ижил төрлийн картуудын бусад функцийг нэгтгэсэн байж болно. Чек баталгаажуулах систем-г мөн харна уу.	<b>Red Book</b> Blue Book Retail
<b>чек баталгаажуулах систем (cheque guarantee system)</b>	ихэвчлэн нэг бол чек бичигчид зориулан гаргасан картын үндсэн дээр эсвэл КҮБ-ын хандаж болох төв мэдээллийн баазаар дамжуулан КҮБ-ын хүчинтэйд үзсэн, тодорхой мөнгөн дүн хүртэлх чекийг баталгаажуулах систем. Хүчинтэй чекийг баталгаажсан картыг гаргагч, хүлээн авагчийн банк эсвэл системийн оператор баталгаажуулна.	<b>Red Book</b> Blue Book Retail
<b>чип карт (chip card)</b>	нэгдсэн схемт карт буюу IC карт гэдгээр хүн бүхний мэдэх карт. Энэ карт нь таньж тогтоох, мэдээллийг агуулах эсвэл хувийн таних дугаар (ПИН)-ийг баталгаажуулахад ашиглагддаг тусгай зорилго бүхий боловсруулалт хийх, худалдан авалтын зөвшөөрөл олгох, дансны үлдэгдэл баталгаажуулах болон хувийн бичлэгийг хадгалахад зориулагдсан нэг буюу түүнээс олон компьютерын бичил процессор эсвэл нэгдсэн схемийг багтаадаг. Зарим тохиолдолд картын санах ой нь картыг ашиглах бүрт (жишээ нь, дансны үлдэгдэл шинэтгэгдэх) шинэчлэгдэж байдаг.	<b>Red Book</b> Blue Book EM-CPSS Retail
<b>хуулийн сонголт (choice of law)</b>	үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоонд оролцогч талуудын хоорондын харилцааг зохицуулах хамгийн тохиромжтой хуулийг тодорхойлох байдал.	<b>EM-Sec</b>
<b>хуулийн сонголт (choice of law)</b>	хоорондын гэрээ буюу харилцааг зохицуулахаар оролцогч талуудын сонгосон хуульд нийцсэн гэрээний нөхцөл. Хуулийн сонголт нь хуулийн маргааны үед ямар хуулиар зохицуулах ёстой вэ гэдэг асуултыг тодорхойлж өгдөг. Хуулийн маргаан-г харна уу.	<b>SSS</b>
<b>шифрлэгдсэн текст (ciphertext)</b>	өгөгдлийн кодолсон хэлбэр	<b>EM-Sec</b>



<p><b>клирэнс (clearance)</b></p>	<p>үнэт цаасны зах зээлд "клирэнс" гэдэг нэр томъёо нь хоёр утга агуулдаг. Энэ нь зах зээлд оролцогчдын үнэт цаас болон мөнгөн хөрөнгө солилцоход зориулж, гол төлөв харилцан суутган тооцсоны үндсэн дээр хоёр талын үүргийг тооцоолох үйл явц гэсэн утгыг агуулж болно. Мөн энэ нь төлбөр тооцоо хийгдэх өдөрт үнэт цаасыг шилжүүлэх үйл явцыг илэрхийлэх ба энэ утгаараа зарим тохиолдолд "клирингийн систем" гэдэг нэр томъёо нь үнэт цаасны төлбөр тооцооны системд хэрэглэгддэг.</p>	<p><b>SSS</b> <i>DVP</i> <i>SLT</i></p>
<p><b>клирингийн болон төлбөр тооцооны байгууллага (clearing and settling institution)</b></p>	<p>төлбөрийн системийн сүлжээгээр мэдээлэл болон хөрөнгийг дамжуулж буй байгууллага. Агент эсвэл удирдах байгууллага (principal) байж болдог.</p>	<p><b>EM-ECB</b></p>
<p><b>клиринг/клирэнс (clearing/clearance)</b></p>	<p>төлбөрийн даалгавар буюу үнэт цаасны шилжүүлгийн даалгаврыг дамжуулах, хуваарилах болон зарим тохиолдолд төлбөр тооцоо хийгдэхийн өмнөх баталгаажуулах үйл явц. Энэ үйл явцад төлбөрийн даалгаврын үр дүнг тооцоолох болон төлбөр тооцооны хаалтын позицийг тодорхойлох ажиллагаа багтаж болно. Зарим үед (онончтой бус хэрэглээнд) энэ нэр томъёонд төлбөр тооцоо гэдгийг багтаан хэрэглэдэг.</p>	<p><b>Red Book</b> Blue Book EM-ECB</p>
<p><b>клирингийн төв (clearing house)</b></p>	<p>санхүүгийн байгууллагуудын төлбөрийн даалгавар эсвэл бусад санхүүгийн үүргээ (жишээ нь, үнэт цаас) солилцохоор тохиролцсон төв байршил буюу боловсруулах төв механизм. Байгууллагууд нь клирингийн төвөөс гаргасан дүрэм, журмын дагуу тодорхой цагт солилцож буй төлбөрийн даалгавруудын төлбөр тооцоог хийдэг. Зарим тохиолдолд клирингийн төв нь клирингийн системийн чухал оролцогч тал болж, клирингийн систем дэх санхүүгийн эсвэл эрсдэлийн удирдлагын үүргийг хүлээдэг. (Клиринг/клиранс, клирингийн системийг мөн харна уу.)</p>	<p><b>Red Book</b> Blue Book EM-ECB</p>

<b>клирингийн төвийн хөрөнгө (clearing house funds)</b>	АНУ-ын тодорхой зах зээлүүд дээр ерөнхийдөө хүлээж авсан өдөрт түр зуурын, дараагийн өдөрт нь эцсийн байх мөнгөн хөрөнгөд хамааруулан хамгийн түгээмэл хэрэглэгддэг нэр томьёо. Нэн ялангуяа, энэ нэр томьёог тодорхой клирингийн төвийн зохицуулалтын дагуу оролцогчдын солилцож буй, клирингийн процессын үр дүнд үүссэн үүргүүдийн төлбөр тооцоог эцсийн болгохтой холбоотойгоор дараагийн өдрийн мөнгөний нэхэмжлэлд хамааруулж хэрэглэдэг. Ийм нэхэмжлэлийг нь гол төлөв чек, вексель буюу бусад ижил төстэй төлбөрүүдээр хийдэг.	<b>Red Book</b>
<b>клирингийн холбоос (clearing link)</b>	хоёр клирингийн төвд харьяалагдах бирж дээр ижил төрлийн хэлцлүүдийг арилжаалдаг боловч нийт позицийг нь өдөр тутам тэдгээрийг хугацаа дуусах эсвэл тооцоолох хүртэл хариуцаж буй нэг клирингийн төвд шилжүүлэх зохицуулалт. Хоёр талын тооцооллын систем-г харна уу.	<b>ETDC</b>
<b>клирингийн гишүүн (clearing member)</b>	клирингийн төвийн гишүүн. Бүх арилжааны төлбөр тооцоо клирингийн гишүүнээр дамжин хийгддэг. Клирингийн шууд гишүүн нь зөвхөн өөрийн үүргүүдийн төлбөр тооцоог хийх эрхтэй. Клирингийн ерөнхий гишүүн нь өөрийн төдийгүй харилцагчдынхаа өр төлбөрийн тооцоог хийх эрхтэй байдаг. Энэ хоёр төрлийн клирингийн гишүүнээс өөр төрөл байх боломжтой юм.	<b>ETDC</b>
<b>клирингийн систем (clearing system)</b>	тухайн нэг байршил (клирингийн төв) дээр бусад санхүүгийн байгууллагуудад хөрөнгө эсвэл үнэт цаас шилжүүлэхтэй холбоотой мэдээ болон/эсвэл баримтыг солилцох, дамжуулах ажиллагааны иж бүрдэл. Ийм ажиллагаанууд нь харилцан суутгах тооцоолол болон цэвэр үр дүнгийн тооцооллын үндсэн дээр оролцогчдын хүлээх үүргийн төлбөр тооцоог хялбарчлах үүднээс оролцогчдын харилцан буюу/эсвэл олон талын үр дүнгийн позицийг тооцоолох механизмыг агуулсан байдаг. Үр дүнгийн тооцоолол-г мөн харна уу.	<b>Red Book Blue Book EM-CPSS</b>
<b>түнш (client)</b>	төлбөр тооцоогоо клирингийн гишүүнээр дамжуулан хийдэг, клирингийн гишүүн бус этгээд. Харилцагч гэдгээр нь нийтээрээ мэддэг.	<b>ETDC</b>
<b>хаалттай сүлжээ (closed network)</b>	төлбөрийн систем гэх мэтийн тусгай зорилгоор ашиглагддаг, аливаа хандалтуудад хаалттай харилцаа холбооны сүлжээ.	<b>Retail</b>

<b>нөхөн төлөх (closeout)</b>	одоо байгаа хэлцлүүдийг тооцоолох ажиллагаа. Үүргээ биелүүлээгүй байгууллагын хариуцах позициос шалтгаалан цаашид үүсч болох алдагдлаас сэргийлэхийн тулд нөхөн төлөлтийг клирингийн төв хийж болно.	<b>ETDC</b>
<b>нөхөн төлөлтийн үеийн үр дүнгийн тооцоолол (closeout netting)</b>	үүргээ биелүүлэх чадваргүй болох гэх мэтийн зарим урьдчилан тодорхойлсон үйл явдлын улмаас учирч болох үр дүнгийн тооцооллын онцгой хэлбэр. Нөхөн төлөлтийн үеийн үр дүнгийн тооцоолол нь хэрвээ нэг талд төлбөр тооцоо хийгдэх хугацаанаас өмнө (мөн үүргээ үл биелүүлэх үеийн үр дүнгийн тооцоолол, нээлттэй хэлцлийн үр дүнгийн тооцоолол эсвэл орлуулах хэлцлийн үр дүнгийн тооцоолол) гэрээнд тусгайлан заасан тодорхой нөхцөл тохиолдоход (тухайлбал, дампуурлын ажиллагааны хүрээнд) нээлттэй хэлцлийн үед үүсэх эрсдэлийн хэмжээг бууруулахад зориулагддаг.	<b>Blue Book</b>
<b>хэлцлийн хаалтын (эсвэл арын) алхам (closing (or back) leg)</b>	тухайн нэг үнэт цаасны хос гүйлгээний сүүлийнх нь. Өөрөөр хэлбэл үнэт цаасны зээллэгийн гүйлгээний эхнийх нь хэлцлийн өдрийн ойролцоо хийгдэж байхад нөгөө нь ирээдүйд хийгдэх хэлцлийн өдрийнхөөр хийгдэнэ. Нээлтийн (эсвэл эхний) алхам-г мөн харна уу.	<b>SLT</b>
<b>барьцаа (collateral)</b>	хүлээсэн үүргийн баталгаа болгон барьцаалагчид барьцаалуулагчаас шилжүүлж буй хөрөнгө. Барьцааны зохицуулалт нь ялгаатай хуулийн хэлбэрүүдтэй ашиглаж болно; Барьцааг нэр шилжүүлэх эсвэл дэнчингийн арга ашиглан авч болдог.	<b>OTC</b>
<b>барьцаа (collateral)</b>	барьцаалуулагчийн хүлээсэн үүргийн баталгаа болгож барьцаалагчийн хүлээн зөвшөөрсөн хөрөнгө эсвэл гуравдагч этгээдийн амлалт.	<b>SSS</b>
<b>барьцааны менежментийн үйлчилгээ (collateral management service)</b>	барьцаатай холбоотой төрөл бүрийн үүргүүдийг зохицуулах боломжтой түнш байгууллагад зориулагдсан төвлөрсөн үйлчилгээ. Энэ үйлчилгээ нь барьцааг үнэлэх, оролцогч талуудын үнэлгээг баталгаажуулах, барьцааны ашиглалтыг оновчтой болгох болон барьцааг шилжүүлэх зэргийг багтаадаг байна.	<b>OTC</b>
<b>барьцааны сан (collateral pool)</b>	системийн дүрэмд онцгойлон заасан нөхцөлд хөрөнгийг олж авах боломж олгох барьцаа болгохоор системд хамтран хуримтлуулсан, төлбөрийн системийн гишүүдийн эзэмшлийн хөрөнгө.	<b>Core Principles</b>

<p><b>худалдах болон худалдан авах опшинтой шууд арилжааны хослол (combination of an outright sale with put and call option)</b></p>	<p>үнэт цаас зээлүүлэх гүйлгээтэй нэгэн адил эдийн засгийн үр нөлөө бүхий дериватив санхүүгийн хэлцэл. Энэ зохицуулалтад, дилер нь нэгэн зэрэг (1) зах зээлийн үнээр аваад бэлэн мөнгөний хөрөнгө оруулагч талд хувьцааг шууд худалддаг (2) хувьцааг тодорхой хугацааны дараа дилер нь анхны үнээр эргэн худалдан авах эрхтэйгээр бэлэн мөнгөний хөрөнгө оруулагчаас биржийн бус арилжааны мөнгөнд нь тохирсон худалдан авах (call) опшинг авдаг (3) тогтоосон өдөрт мөнгөн хөрөнгийн хөрөнгө оруулагч анхны үнээр тухайн хувьцааг худалдах эрхтэйгээр бэлэн мөнгөний хөрөнгө оруулагч талд биржийн бус арилжааны мөнгөнд нь тохирсон худалдах (put) опшинг худалдаалдаг. Эдгээрийн үр дүнд дилерт хувьцааны хиймэл урт позиц бий болж, тухайн хувьцааны ашиг, алдагдлыг хэвээр хадгалдаг бол мөнгөн хөрөнгийн хөрөнгө оруулагч нь хувьцааны үнийн алдагдлаас хамгаалагдах ба харин олж болох ямар нэгэн ашгийг дилерт төлөх болдог. Хугацаа дуусахад энэхүү опшин бэлэн мөнгөөр төлбөр хийгддэг. Опшингийн үнийн загвар нь урьдчилан тодорхойлогдсон зардлыг санхүүжүүлж худалдан авах болон худалдах опшины урамшууллыг бий болгодог.</p>	<p><b>SLT</b></p>
<p><b>баталгаатай санхүүгийн эх үүсвэр (committed facilities)</b></p>	<p>тодорхой нөхцөлд мөнгө зээлдүүлэх гэрээний дагуу нийлүүлэгчээс олгогдох санхүүжилтийн эх үүсвэр (жишээ нь, зээлийн шугам эсвэл репо санхүүжилт). Буцаан худалдан авах гэрээ-г харна уу.</p>	<p><b>Core Principles</b></p>
<p><b>харьцуулалт (comparison)</b></p>	<p>тулган шалгах-г харна уу.</p>	<p><b>Red Book</b></p>
<p><b>найдвартай байдал (confidentiality)</b></p>	<p>зөвшөөрөлгүйгээр ил тод болохоос хамгаалж байгаа чанар.</p>	<p><b>EM-Sec EM-ECB</b></p>
<p><b>баталгаажилт (confirmation)</b></p>	<p>энэхүү өргөн хэрэглэгддэг нэр томъёо нь зах зээлийн оролцогч нь оролцогч талууд эсвэл харилцагчдадаа арилжааны талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгч, тэдэнд арилжааны талаар асуулт тавих буюу зөвшөөрөх хугацаа олгох процесс гэсэн тодорхой утгыг илэрхийлдэг.</p>	<p><b>Red Book Blue Book</b></p>

<b>баталгаажилт (confirmation)</b>	нэг бол зах зээлийн оролцогч шууд баталгаажуулах эсвэл зарим төвлөрсөн байгууллага (ихэвчлэн зах зээлийн байгууламж) баталгаажуулдаг арилжааны нөхцөл дэх үйл явц. Шууд оролцогч зах зээлийн шууд бус оролцогчийн өмнөөс арилжааг гүйцэтгэсэн бол арилжааг баталгаажуулах дараах хоёр тусдаа чиглэл гарч ирдэг: шууд оролцогчдын хоорондын арилжааны нөхцөлийн баталгаажилт (ерөнхийдөө баталгаажилтыг илэрхийлдэг) эсвэл шууд оролцогч болон шууд оролцогчоор арилжааг гүйцэтгүүлж байгаа шууд бус оролцогчийн хооронд тодорхойлогдсон нөхцөлийн баталгаажилт (зарим тохиолдолд нотолгоог илэрхийлдэг).	<b>SSS</b>
<b>баталгаажуулах үйл явц (confirmation process)</b>	оролцогч талтай арилжааны дэлгэрэнгүйг баталгаажуулах горим. Энэ нь ерөнхийдөө арилжааны дэлгэрэнгүйг тодорхойлсон баримт буюу зохицуулах хууль ёсны баримт бичгийг шуудан эсвэл факсаар солилцох (өөрөөр хэлбэл, баталгаажуулалт), мөн түүнчлэн оролцогчдод өгч байгаа мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулах (өөрөөр хэлбэл, тулгах) замаар хийгддэг байна.	<b>OTC SLT</b>
<b>хуулийн маргаан (conflict of laws)</b>	тодорхой ажил гүйлгээнд зохих ёсоор хамтдаа хэрэглэгдэх хоёр буюу түүнээс олон эрх зүйн хэм хэмжээний үед ялгаатай үр дүнд хүргэх нөхцөл байдал.	<b>x-border</b>
<b>хуулийн маргаан (conflict of laws)</b>	гүйлгээтэй холбоотой хэргийг шүүн шийдэх эрх зүйн зөрчилдөөн буюу үл нийцэл. Шүүх эрх зүйн хуулийн маргаан бүр тухайн тохиолдолд хэрэглэх хуулийг тодорхойлсон шалгуурыг тусгайлан заадаг.	<b>SSS</b>
<b>хүрч уншигдах карт (contact cards)</b>	карт болон карт уншигч эсвэл терминал төхөөрөмжийн хооронд цахилгаан холболтын гадаргууны тусламжтайгаар биет байдлаар хүрч уншуулахыг шаарддаг карт.	<b>EM-Sec</b>
<b>зайнаас уншигдах карт (contactless cards)</b>	карт болон карт уншигч эсвэл терминал төхөөрөмжийн хооронд биет байдлаар хүрч уншуулах шаардлагагүй карт.	<b>EM-Sec</b>

<b>зөрүүтэй нөхцөлийн гэрээ</b> <b>(contract for difference)</b>	<p>хөрөнгийн тохиролцсон тогтмол үнэ болон түүний зонхилох зах зээл үнийн хоорондын зөрүү нь оролцогч талд мөнгөн хэлбэрээр үе үе кредитлэгдэхтэй холбоотой санхүүгийн хэлцэл. Үндсэн дүнгээр шилжүүлэг хийгдэхгүй байгаа учраас ЗНГ нь хеджинг эсвэл эрсдэл ихтэй хэрэгцээг зохицуулж байдаг.</p>	<b>SLT</b>
<b>гэрээний эрх зүй</b> <b>(contract law)</b>	<p>хэлэлцээрийн гүйцэтгэлийг хангах болон байгуулахтай холбоотой хууль зүйн хэм хэмжээний цогц.</p>	<b>Core Principles</b>
<b>гэрээний үндсэн дээр хийгдэх орлогын хуримтлал</b> <b>(contractual income collection)</b>	<p>кастодиан төлбөрийг үнэхээр хүлээж авсан эсэхээс үл хамааран төлбөрийн хуваарь хийгдсэн өдөр хүү, ногдол ашиг эсвэл татварын буцаалтын төлбөрүүдээр харилцагчийн мөнгөн хөрөнгийн дансанд кредит бичилт хийх кастодианы гэрээгээр хүлээсэн амлалт. Ихэвчлэн ийм төрлийн кредит бичилтүүд нь нөхцөлт байх ба хэрэв кастодианы тогтоосон хугацааны интервал дотор кастодиан төлбөрийг хүлээж аваагүй бол буцаагддаг.</p>	<b>x-border</b>
<b>гэрээний үндсэн дээр төлбөр тооцоо хийгдэх өдрийн бүртгэл</b> <b>(contractual settlement date accounting)</b>	<p>төлбөр тооцоо үнэхээр хийгдсэн эсэхээс үл хамааран үйлчлүүлэгчийн оролцогч талдаа төлбөр тооцоо үзүүлэх өдрөөр (гэрээнд заасан төлбөр тооцоо хийгдэх өдөр) харилцагчийн мөнгөн хөрөнгийн болон үнэт цаасны дансанд кредит болон дебит бичилт хийхээр кастодианы гэрээгээр хүлээсэн амлалт. Ихэвчлэн энэхүү кредит болон дебит бичилтүүд болзолт байх ба хэрвээ кастодианы тогтоосон хугацааны интервал дотор төлбөр тооцоо хийгдэхгүй бол буцаагддаг.</p>	<b>x-border</b>
<b>корреспондент банк</b> <b>(correspondent banking)</b>	<p>нэг банк (корреспондент) нь өөр банкуудын (респондент) мэдлийн татан төвлөрүүлсэн хөрөнгийг байршуулан, тэдгээрт төлбөрийн болон бусад үйлчилгээ үзүүлэх тохиролцоо. Энэхүү тохиролцоог зарим үед дотоодын нөхцөлд агентын харилцаа гэдэг. Гадаадын банкуудын хувьд респондент банкны дансны үлдэгдлийг гадаад валютын арилжааны гүйлгээг хийхэд ашиглаж болдог. Харилцан корреспондент банкуудын харилцаа нь гадаад валютын арилжааны төлбөр тооцоог хийхэд ностро болон востро гэж нэрлэгдэх дансуудыг ашиглахтай холбоотой байж болно.</p>	<b>Red Book Retail</b>
<b>оролцогч тал/нөгөө тал</b> <b>(counterparty)</b>	<p>үнэт цаасны арилжаа эсвэл своп хэлцэл зэрэг санхүүгийн гүйлгээнд оролцож буй эсрэг тал.</p>	<b>Red Book Blue Book Retail</b>

<b>оролцогч талын зээлийн хязгаар (counterparty credit limits)</b>	ялгаатай оролцогч талуудад нөлөөлөх зээлийн их хэмжээний алдагдлыг хязгаарлах үүднээс арилжаанд оролцогч талуудад тогтоосон хязгаар.	<b>SLT</b>
<b>ТТХ (CPU)</b>	төв тооцоолох хэсэг-г харна уу.	
<b>зээлийн хязгаар (credit caps)</b>	хязгаар-г харна уу.	<b>Red Book</b> Blue Book
<b>зээлийн карт (credit card)</b>	карт эзэмшигчид зээлийн шугам олгогдсоныг илэрхийлдэг карт. Энэ нь эзэмшигчид худалдан авалт хийх болон/эсвэл урьдчилан тохиролцсон хязгаарт багтаан бэлэн мөнгө авах боломжийг олгох; олгогдсон зээл нь тогтоосон хугацааны эцэст бүтэн дүнгээр төлөгдөж чадах эсвэл зээлийг сунгаснаар тооцоологдсон үлдэгдлийг хагаслан төлж чадахаар байна.	<b>Red Book</b> Blue Book EM-CPSS <i>Retail</i>
<b>зээлийн картны компани (credit card company)</b>	тодорхой зээлийн картын худалдааны тэмдгийг эзэмшдэг, картын үйлчилгээг ашиглан өөрийн гишүүддээ маркетингийн, боловсруулалтын буюу бусад олон тооны үйлчилгээг үзүүлж чадах компани.	<b>Red Book</b> Blue Book Retail
<b>зээлийн байгууллага (credit institution)</b>	Европын Холбоонд үүнийг "банк" гэж тодорхойлсон байдаг. Анхны ЕС-ийн банкуудын удирдамжид үүнийг өөрийн дансандаа олон нийтээс хөрөнгийг татан төвлөрүүлж эсвэл эргэн төлөгдөх хөрөнгийн хэлбэрээр олж авч, зээл олгодог бизнесийн байгууллага гэж тодорхойлжээ.	<b>EM-CPSS</b> EM-ECB
<b>зээлийн хязгаар (credit limit)</b>	хараахан төлбөр тооцоо нь хийгдээгүй ч хүлээж авсан төлбөрөөс шалтгаалан нөгөө оролцогч (хоёр талын зээлийн хязгаар) эсвэл бусад бүх оролцогч (олон талын зээлийн хязгаар) талуудын хувьд төлбөрийн системийн оролцогчид учрах зээлийн эрсдэлд өртөх дүн дээр тавигдсан хязгаар.	<b>Core Principles</b>
<b>зээлийн эрсдэл/зээлийн эрсдэлд өртөх дүн (credit risk/exposure)</b>	төлбөр тооцооны системд оролцогч тал тухайн үед эсвэл ирээдүйд төлбөрийн үүргээ бүтэн дүнгээр биелүүлэх боломжгүй болохтой холбогдон гарах эрсдэл. Хөрөнгийн дүнгээр солилцох системүүд (exchange-for-value systems)-ийн хувьд энэхүү эрсдэл нь солилцох зардлын эрсдэл болон үндсэн дүнгийн эрсдэлийг багтаадаг.	<b>DVP</b> Blue Book

<b>кредит шилжүүлэг (credit transfer)</b>	хүлээн авагчид очих хөрөнгийг хуваарилах зорилгоор хийгдэж байгаа төлбөрийн хүсэлтүүдийн боломжит дараалал буюу төлбөрийн хүсэлт. Төлбөр төлөгч буюу шилжүүлэг эхлүүлэгчийн банкнаас хүлээн авагчийн банк рүү шилжүүлэхийг тодорхойлон заасан хөрөнгө болон төлбөрийн даалгаврын аль аль нь зуучлагч хэд хэдэн банкаар дамжих буюу/эсвэл нэгээс олон кредит шилжүүлгийн системээр дамжиж болно.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> EM-CPSS EM-ECB Retail
<b>кредит шилжүүлгийн систем (credit transfer system)</b>	шилжүүлгийн мэдээг үүсгэгч буюу төлбөр шилжүүлэгчээс (төлөгчийн банк) төлбөр хүлээн авагч (хүлээн авагчийн банк) буюу мэдээ хүлээн авагчид төлбөрийн даалгаврыг дамжуулах хөрөнгийн шилжүүлгийн систем.	<b>DVP</b> <i>Red Book</i>
<b>хил дамнасан үр дүнгийн тооцооллын схем (cross-border netting scheme)</b>	нэгээс дээш улс орон эсвэл шүүх эрхэд харьяалагдах талуудын хоорондын эсвэл дундын үүрэг буюу позицийг тооцоолох зохицуулалт. Үр дүнгийн тооцоолол-г мөн харна уу.	<b>Core Principles</b>
<b>хил дамнасан төлбөр тооцоо (cross-border settlement)</b>	арилжааны оролцогч талын аль нэгний нь эсвэл хоёулангийнх нь байрлаж буй орноос өөр оронд хийгдэх төлбөр тооцоо.	<b>x-border SDF</b>
<b>хил дамнасан арилжаа (cross-border trade)</b>	өөр өөр улс орнуудад байгаа оролцогч талуудын хоорондын арилжаа.	<b>x-border</b>
<b>хил дамнасан арилжаа (cross-border trade)</b>	хил дамнасан төлбөр тооцоог шаарддаг арилжаа.	<b>SSS</b>
<b>кросс-валютын төлбөр тооцооны эрсдэл (cross-currency settlement risk)</b>	үндсэн дүнгийн алдагдлын эрсдэл-г харна уу.	<b>Red Book</b>



<p><b>хил дамнасан зээлийн гэрээ</b> (<b>cross-margining agreement</b>)</p>	<p>байгууллагуудын хоёулангийнх нь гишүүн болж байгаа оролцогчдодоо зориулсан багц болохынх нь хувьд тэдгээр байгууллагуудын тус тусын позици болон барьж байгаа барьцааг тооцох тухай үнэт цаасны зуучлагчдын хоорондын хэлэлцээр. Хил дамнасан зээлийн дансанд байгаа позици нь хамгийн бага барьцааны шаардлагыг барьж байдаг. Учир нь нэг үнэт цаасны зуучлагчид байгаа позици нь өөр нэг үнэт цаасны зуучлагчийн холбогдох позицийн эрсдэлд өртөх хэсгийн барьцаа болдог. Хил дамнасан зээлийн данстай оролцогч үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд, үнэт цаасны нэг зуучлагч позицийг ашиглаж болох ба бусад үнэт цаасны зуучлагч дахь хил дамнасан зээлийн дансны барьцаагаар алдагдлыг хаана.</p>	<p><b>SSS</b></p>
<p><b>систем дамнасан төлбөр тооцоо</b> (<b>cross-system settlement</b>)</p>	<p>үнэт цаасны шилжүүлгийн хоёр салангид системийг хооронд нь холбосноор хийгдэх арилжааны төлбөр тооцоо.</p>	<p><b>x-border SSS</b></p>
<p><b>криптанализ</b> (<b>cryptanalysis</b>)</p>	<p>криптографийн түлхүүргүйгээр шифрлэгдсэн бичвэрийг задлах аргачлалыг судлах болон хөгжүүлэх чиглэлээр дагнасан криптографийн бүлэг.</p>	<p><b>EM-Sec</b></p>
<p><b>криптографийн алгоритм</b> (<b>cryptographic algorithm</b>)</p>	<p>өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал болон жинхэнэ эсэхийг нягтлахад хэрэглэгдэх түлхүүрүүдийн хослолд ашиглагддаг математикийн функц. Мөн шифрлэлт гэж нэрлэгддэг.</p>	<p><b>EM-Sec</b></p>
<p><b>криптограф</b> (<b>cryptography</b>)</p>	<p>өгөгдлийн нууцлал, бүрэн бүтэн байдал болон жинхэнэ эсэхийг нягтлах зорилгоор хэрэглэгддэг аргачлал болон алгоритмыг хөгжүүлэх математикийн онолын хэрэглээ.</p>	<p><b>EM-Sec</b> <b>EM-CPSS</b> <b>EM-ECB</b></p>
<p><b>ҮЦТХТ</b> (<b>CSD</b>)</p>	<p>үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв-г харна уу.</p>	
<p><b>эрсдэлд өртөх өнөөгийн дүн</b> (<b>current exposure</b>)</p>	<p>оролцогч тал өөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд нэг буюу хэд хэдэн гэрээний улмаас өнөөдөр хүлээж болох алдагдал. Түүнчлэн хэрвээ оролцогч тал өнөөдөр үүргээ биелүүлж чадахгүй болбол байгуулсан гэрээний дагуу юугаар нөхөж болох вэ гэдгийг орлуулах зардал болон эрсдэлд өртөх өнөөдрийн дүнгээр мэдэж болно. Ирээдүйн боломжит эрсдэлд өртөмтгий дүн-г мөн харна уу</p>	<p><b>ОТС</b></p>

<b>кастодиан (custodian)</b>	харилцагчдынхаа үнэт цаасыг хадгалан, удирддаг түүнчлэн клирингийн, төлбөр тооцооны, мөнгөн хөрөнгийн удирдлагын, гадаад валютын болон үнэт цаасны зээлдүүлгийн зэрэг бусад үйлчилгээг үзүүлдэг байгууллагууд. Энэ байгууллагууд нь ихэвчлэн банкууд байдаг.	<b>x-border</b> SDF SLT
<b>кастоди (custody)</b>	бусад этгээдийн нэрийн өмнөөс үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийг нь хадгалах болон удирдах ажиллагаа.	<b>DVP</b> Red Book x-border Blue Book
<b>зөвхөн кастоди холболт (custody-only link)</b>	худалдагч болон худалдан авагч нь хоёулаа ҮЦТТС2 дээр байгаа нөхцөлд, ҮЦТТС2 (ҮЦТТС1-ээс ялгаатай)-ийг ашиглан ҮЦТТС1 дээр байгаа үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоог хийх боломжтой хоёр ҮЦТТС-ийн хоорондын холбоос. Зөвхөн кастоди холбоос нь ҮЦТТС1 болон ҮЦТТС2-ийн хооронд мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийхгүй бөгөөд ҮЦТТС1-ийн оролцогч болон ҮЦТТС2-ийн оролцогчдын хоорондын гүйлгээний төлбөр тооцоог хийхэд ашиглагдахгүй.	<b>SDF</b>
<b>кастодийн эрсдэл (custody risk)</b>	кастодиан эсвэл дэд кастодианы төлбөрийн чадваргүй болсноос, залилан мэхлэх эсвэл хайхрамжгүй ажиллагаанаас үүдэн кастодид буй үнэт цаас алдагдаж болох эрсдэл.	<b>x-border</b> ETDC OTC SLT SSS
<b>харилцагч (customer)</b>	төлбөрийн системд шууд оролцдоггүй үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийн худалдан авагч, худалдагч эсвэл эзэмшигч. Систем дэх оролцогчдын хөрөнгө гэдэгт үр ашгийг хүртэгчийн үнэт цаасны болон санхүүгийн хэрэгслийг багтааж байдаг ба үр ашиг хүртэгч гэдэг нь системийн оролцогчдын үйлчлүүлэгч юм.	<b>DVP</b> SDF
<b>харилцагчаас харилцагчид шилжүүлэг (customer-to-customer transfer)</b>	шилжүүлэх чадвар-г харна уу.	<b>EM-ECB</b>
<b>өдрийн боловсруулалт (daily processing)</b>	өдөр эхлүүлэх горимоос өгөгдөл нөөцлөлтийг оруулаад өдөр дуусах горим хүртэлх ердийн ажлын өдөрт хийгдэх ёстой боловсруулалтын бүрэн цикл.	<b>Core Principles</b>
<b>өдрийн төлбөр тооцоо (daily settlement)</b>	төлбөр тооцоонд хүлээн зөвшөөрөгдсөн бүх төлбөрүүдийн дүнгийн тухайн өдрийн төлбөр тооцооны гүйцэтгэл.	<b>Core Principles</b>

<b>өгөгдлийн инкрипшний стандарт (data encryption standard)</b>	ялангуяа санхүүгийн салбарт өргөн хэрэглэгддэг тэгш хэмт криптографийн алгоритм (ANSI стандарт). Гурвалсан ӨИС нь давхар урттай ӨИС-ийн түлхүүрийг ашигласнаар өгөгдлийн бүрдэл дээрх гурван ажиллагаанаас (инкрипшн-дикрипшн-инкрипшн) бүрддэг.	<b>EM-Sec</b>
<b>өдрийн зээл (daylight credit)</b>	нэг ажлын өдрөөс ч бага хугацаанд олгогдох зээл. Өдрийн эцэст сүүлчийн төлбөр тооцоог хийдэг кредит шилжүүлгийн системд өдрийн зээл нь хэрвээ ажлын өдрийн эцэс хүртэл сүүлчийн мөнгөн хөрөнгийг хүлээн авч чадахгүй байхаар байсан ч төлбөрийн даалгаврыг хүлээн авч, гүйцэтгэж байгаа л бол автоматаар сунгагддаг. Үүнээс гадна өдрийн овердрафт (daylight overdraft), өдрийн нээлттэй позици (daylight exposure), өдөр дундын зээл (intraday credit) гэж нэрлэдэг.	<b>DVP</b> Red Book Blue Book <i>SDF</i>
<b>гүйлгээний өдөр (day of value)</b>	төлбөрийн системийн төлбөр хүлээн авч буй оролцогчийн дансанд төлбөрийн дүнгээр кредит бичилт хийгдэх өдөр. Тодорхой зохицуулалт эсвэл дотоодын жишгээс хамааран төлбөр хүлээн авч буй оролцогчийн харилцагчийн (энэ нь төлбөр хүлээн авагч-оролцогчийн харилцагчийнхаа дансанд кредит бичилт хийх өдөр) гүйлгээний өдөр нь төлбөр хүлээн авч буй оролцогчийн гүйлгээний өдрөөс өөр байж болно.	<b>Core Principles</b>
<b>ӨШ (DBV)</b>	өртгөөр шилжүүлэх-г харна уу.	
<b>дилер (dealer)</b>	нэг эсвэл олон бүтээгдэхүүний зах зээлийн хоёр талын аль алины оролцогч тал болсноор арилжаанд оролцож байгаа фирм. Биржийн бус арилжааны зах зээлийн деривативуудын дилерүүд нь ихэвчлэн арилжааны банк, зарим үнэт цаасны фирм болоод даатгалын компаниуд зэрэг үндсэндээ олон улсын томоохон байгууллагууд түүнчлэн санхүүгийн бус байгууллагуудын цөөн тооны охин компани байдаг. Мөн эцсийн хэрэглэгч-г харна уу.	<b>OTC</b>
<b>дебит баланс (debit balance)</b>	цэвэр кредит (эсвэл дебит) позици-г харна уу.	<b>SDF</b>
<b>дебит хязгаар (debit caps)</b>	хязгаар-г харна уу.	<b>Red Book</b> Blue Book

<b>дебит карт (debit card)</b>	депозит авч буй байгууллагад байгаа өөрийн дансандаа мөнгөн хөрөнгө байршуулсны үр дүнд, түүгээрээ худалдан авалтын төлбөрөө шууд хийх боломжийг карт эзэмшигчид олгодог карт (зарим тохиолдолд, мөнгөний карт буюу чек баталгаажуулах карт зэрэг бусад үүрэгтэй хосолсон байж болдог).	<b>Red Book</b> Blue Book EM-CPSS Retail
<b>дебит шилжүүлгийн систем (debit transfer system)</b>	төлөгчийн бичиж өгсөн буюу түүний зөвшөөрсөн дебит инкассын даалгаврууд төлбөр хүлээн авагч (банк)-аас төлбөр төлөгч (банк)-д шилжиж, ингэснээр төлбөр төлөгчийн данснаас төлбөр хийгддэг (дебитэлдэг) хөрөнгийн шилжүүлгийн систем. Тухайлбал, чекийн систем нь дебит шилжүүлгийн систем юм. Дебит инкассын систем гэж мөн нэрлэдэг.	<b>DVP</b> Red Book Blue Book SLT
<b>өрийн үнэт цаасны цахим бүртгэлийн систем (debt book-entry system)</b>	цахим бүртгэлийн хэлбэрээр өрийн үнэт цаасыг гаргах болон бүртгэхэд зориулагдсан, компьютерын тусламжтайгаар боловсруулалт хийх систем. Цахим бүртгэлийн систем, дундын цахим бүртгэлийн систем-г мөн харна уу.	<b>Blue Book</b>
<b>үүргээ биелүүлэх чадваргүй болох (default)</b>	түр зуурын эсвэл техникийн бус шалтгааны улмаас хөрөнгө болон үнэт цаасны шилжүүлэг нь хийгдэхгүй байх саатал. Ихэвчлэн дампуурлын улмаас үүдсэн байдаг. Үл биелэлт нь ерөнхийдөө “саатсан гүйлгээ” гэдгээс ялгаатай байдаг.	<b>Red Book</b> Blue Book SDF SLT
<b>үүргээ биелүүлээгүй талын төлбөр (defaulter pays)</b>	бусад оролцогчдод зориулан, аливаа нэгэн эрсдэлд өртөж болзошгүй дүнг барьцаатай байлгахыг оролцогч бүрээс шаарддаг, алдагдал хуваах тохиролцоо. Ингэснээр ямар нэгэн оролцогчийн үүргээ биелүүлэх чадваргүй болсны улмаас үүсэх алдагдлыг үүргээ биелүүлээгүй тал барагдуулна.	<b>Core Principles</b>
<b>тодорхой цагийн үр дүнгийн тооцооны систем (deferred net settlement system)</b>	оролцогч талуудын хооронд хийгдэх шилжүүлэг буюу үүргийн төлбөр тооцоог харилцан суутгах тооцооны үндсэн дээр дараа нь тодорхой нэгэн цагт гүйцэтгэх систем.	<b>ETDC</b>
<b>хойшлуулсан төлбөрт дебит карт (delayed debit card)</b>	карт эзэмшигч нь зөвшөөрсөн хязгаарт багтаан данснаасаа зарцуулалт хийж болохыг нотлон банкны гаргасан карт. Энэ нь эзэмшигчид худалдан авалт хийх боломж олгох боловч урт хугацааны зээлээр хангадаггүй, хүлээсэн өрийн нийт дүнг тогтоосон хугацааны эцэст гүйцэтгэх ёстой байдаг. Карт эзэмшигч нь ерөнхийдөө жилийн хураамж төлдөг.	<b>Red Book</b> Blue Book

<b>хасалт (deletion)</b>	үүргээ биелүүлээгүй оролцогчийн хүлээн авах болон гаргах нийт буюу зарим гүйлгээнүүдийг төлбөр тооцооны боловсруулалтаас гаргах аргачлал. Үр дүнгийн төлбөр тооцооны схемд бусад оролцогчдын хоёр талын болон олон талын үр дүнгийн позицийг дахин тооцоолдог. Үлдэгдлийн хаалт –г мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>нийлүүлэлт (delivery)</b>	үнэт цаасны эсвэл санхүүгийн хэрэгслийн эцсийн шилжүүлэг.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>x-border</b> <b>Blue Book</b> <b>SDF</b>
<b>өртгөөр шилжүүлэх (delivery by value)</b>	төлбөрийн системд барьцаа байршуулсан нөхцөлд аль нэг оролцогч нөгөө оролцогчид мөнгө зээлдүүлэх эсвэл мөнгө зээлэхэд туслах зорилго бүхий төлбөр тооцооны зарим системүүд дэх зохицуулалт. Тус систем нь холбогдох талд үнэт цаасыг сонгон, шилжүүлж (авч байгаа болон өгч буй талуудын шаардсан нөхцөлүүдийг тохируулсны үндсэн дээр), тухайн үнэт цаастай дүйх үнэт цаасыг дараагийн ажлын өдөрт буцаан авахаар тохиролцдог.	<b>SLT</b>
<b>нийлүүлэлтийн эсрэг нийлүүлэлт (delivery versus delivery)</b>	зөвхөн нийлүүлэлт хийгдсэн нөхцөлд л нөгөө нийлүүлэлт хийгдэхийг баталгаажуулах, хоёр үнэт цаасны шилжүүлгийн (төлбөр тооцооны) системийн хоорондын холбоос.	<b>SLT</b>
<b>төлбөрийн эсрэг нийлүүлэлт (delivery versus payment)</b>	зөвхөн төлбөр хийгдсэн нөхцөлд л нийлүүлэлт хийгдэхийг баталгаажуулдаг, үнэт цаасны систем болон мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн системийн хоорондын холбоос.	<b>DVP</b> <b>x-border</b> <b>SDF</b> <b>ETDC</b>
<b>төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн систем (delivery-versus payment system)</b>	зөвхөн аль нэг актив(ууд)-ын эцсийн шилжүүлэг хийгдсэн нөхцөлд нөгөө активын эцсийн шилжүүлэг хийгдэхийг баталгаажуулах, өртгөөр солилцох төлбөр тооцооны систем дэх зохицуулалт. Активт мөнгөн хөрөнгө (тухайлбал, гадаад валют), үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслүүд орно. Өртгөөр солилцох төлбөр тооцооны систем, эцсийн шилжүүлэг-г мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>биет бус болгох (dematerialisation)</b>	үнэт цаасны эзэмшлийг төлөөлж буй эрхийн бичиг болох биет гэрчилгээ буюу баримтыг халж, ингэснээр үнэт цаас зөвхөн бүртгэлийн бичилтийн үндсэн дээр байхаар зохицуулах үйл ажиллагаа.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b>

<b>хадгалагч/депозитор (depository)</b>	үнэт цаасны биет болон цахим бичилтийг хийх, эдгээр үнэт цаасны эзэмшлийн бичилтийг хадгалах үндсэн үүрэг бүхий агент.	<b>Blue Book</b>
<b>хадгаламжийн байгууллага (depository institution)</b>	АНУ-ын хувьд "банк"-д өгөгдсөн тодорхойлолт. Депозиторын зохицуулалтын болон Мөнгөний бодлогын хяналтын хуулийн дагуу арилжааны банкууд, хадгаламж, зээлийн холбоод, хувь нийлүүлсэн хадгаламжийн банкууд болон зээлийн холбоо зэргийг оролцуулаад бүх хадгаламжийн байгууллагууд нь хувь хүн болон ашгийн бус байгууллагуудад хугацаатай болон хугацаагүй депозит нээх бүрэн эрхтэй байдаг.	<b>EM-CPSS</b>
<b>хадгаламжийн бичиг (depository receipt)</b>	өөр нэг улс орны кастодид байршиж байгаа үнэт цаасны эрхийг тогтоон нэг улс орны гаргасан баримт бичиг.	<b>x-border SDF</b>
<b>дериватив (derivative)</b>	нэг болон түүнээс олон суурь активын үнэ, хүү эсвэл индексээс үнэ нь хамаардаг санхүүгийн хэлцэл. Судалгааны зорилгоор бүх деривативын хэлцлийг дараах үндсэн төрөлд хуваана: форвард хэлцэл, опшон эсвэл эдгээрийн хослол.	<b>OTC</b>
<b>үүсгэгдсэн түлхүүр (derived key)</b>	мастер түлхүүр болон картын серийн дугаар гэх мэтийн цорын ганц таних хэмжигдэхүүнтэй хослуулж арифметик функцыг ашигласнаар бий болгох криптографийн түлхүүр.	<b>EM-Sec</b>
<b>ӨИС (DES)</b>	өгөгдлийн инкрипшний стандарт-г харна уу.	
<b>цахим гарын үсэг (digital signature)</b>	илгээгч тал хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд хүлээн авагчийг хамгаалах, мөн тухайн баримтын жинхэнэ эсэхийг нягтлах зорилгоор мэдээнд хавсаргагдсан, криптографийн аргаар үүсгэгдсэн өгөгдлийн цуваа.	<b>EM-Sec</b>
<b>шууд дебит (direct debit)</b>	төлбөр хүлээн авагчийн эхлүүлснээр төлөгчийн банкин дахь дансанд хийгдэх урьдчилан зөвшөөрөл авсан дебит.	<b>Red Book Blue Book</b>

**шууд эзэмшигчийн  
бүртгэлийн систем  
(direct holding system)**

(i) гаргагчийн албан ёсны бүртгэл дээр хууль ёсны эзэмшигчээр тусгагдсан байгаа (мөн хэрвээ үнэт цаасыг сертификатжуулсан байх шаардлагатай нөхцөлд үнэт цаас нь эзэмшигчийн нэр дээр бичигдсэн) эсвэл (ii) мэдүүлэгчийн нэр дээр гаргасан үнэт цаасыг эзэмшиж байгаа үнэт цааснаас ашиг хүртэгчийн үнэт цаасны эзэмшлийг бүртгэх систем. Үнэт цаас гаргагч, ҮЦТХТ, ҮЦТХТ-ийн оролцогч болон гуравдагч этгээд нэхэмжлэгчид нь үнэт цаасны бүртгэлийн бичилт эсвэл эзэмшигчийн эзэмшлийн үндсэн дээр эзэмшигчийн эрх болон ашиг сонирхлыг мэдэх шаардлагатай байдаг.

**SSS**

**арилжаанд шууд  
оролцогч  
(direct market participant)**

захиалгыг шууд гүйцэтгэдэг, биржийн гишүүн эсвэл брокер-дилер.

**SSS**

**шууд оролцогч  
(direct participant)**

төлбөр тооцоог нь төлөөлөн гүйцэтгэдэг өөрийн харилцагч болох шууд бус оролцогчдынхоо болон өөрийн төлбөрүүдийн төлбөр тооцоог төлбөр тооцооны агентын өмнө (буюу бусад бүх шууд оролцогчийн өмнө) хариуцдаг, банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем (БХХШС)-ийн оролцогч.

**Blue Book**

**шууд оролцогч/гишүүн  
(direct participant/  
member)**

энэхүү нэр томъёо нь ерөнхийдөө тухайн системийн бусад оролцогчидтой төлбөрийн даалгавруудыг шууд солилцдог, хөрөнгийн буюу үнэт цаасны системийн оролцогчдыг заадаг. Зарим системд шууд оролцогчид нь шууд бус оролцогчдыг төлөөлөн төлбөрийн даалгавар солилцдог. Системээсээ хамааран шууд оролцогчид нь төлбөр тооцооны оролцогч байж ч болно биш ч байх боломжтой. Европын Холбооны хувьд энэ нэр томъёо дараах тодорхой утгыг агуулдаг байна: энэ нь төлбөр тооцоог нь төлөөлөн гүйцэтгэдэг өөрийн харилцагч болох шууд бус оролцогчдынхоо болон өөрийн төлбөрийн тооцоог төлбөр тооцооны байгууллагын өмнө (буюу бусад бүх оролцогчдын өмнө) хариуцдаг, шилжүүлгийн системийн оролцогчид хамаарна. Шууд бус оролцогч/гишүүн, оролцогч/гишүүн, төлбөр тооцооны оролцогч/гишүүн-г мөн харна уу.

**Red Book**

**төлбөрөөс чөлөөлөх  
(discharge)**

хууль болон гэрээгээр ноогдуулсан хууль зүйн үүргээс чөлөөлөх.

**DVP**

**Red Book  
Blue Book**

<b>мэдээллийг ил тод болгох (disclosure)</b>	мэдээллийг олон нийтэд ил тод болгох-г харна уу.	<b>Core Principles</b>
<b>хуваарилах байгууллага (distributing institution)</b>	харилцагчид цахим мөнгийг түгээх (агентын хувиар) буюу худалдах (гаргагч буюу андеррайтерын хувиар) байгууллага.	<b>EM-ECB</b>
<b>дотоодын төлбөр тооцоо (domestic settlement)</b>	арилжаанд оролцогч талууд хоёулаа оршиж буй улс оронд хийгдэж буй төлбөр тооцоо.	<b>x-border SDF</b>
<b>дотоодын арилжаа (domestic trade)</b>	нэг улс оронд байрлаж буй оролцогч талуудын хоорондын арилжаа.	<b>x-border SDF</b>
<b>вексель (draft)</b>	даалгавар дээр тодорхойлогдсон тал (төлбөр хүлээн авагч) буюу мэдүүлэгчид тодорхой мөнгөн дүнг шаардсан үед нь (хугацаагүй вексель) эсвэл заасан хугацаанд (хугацаатай вексель) төлөхийг тохирон нэг тал (вексель бичигч)-аас нөгөө тал (төлбөр хариуцагч)-д бичсэн даалгавар.	<b>Red Book Blue Book</b>
<b>НЭН (DVD)</b>	нийлүүлэлтийн эсрэг нийлүүлэлтийг харна уу.	
<b>G10-ын тодорхойлсон ТЭН схем (DVP schemes as defined by the G10)</b>	загвар 1-д, үнэт цаас худалдагчаас худалдан авагчид шилжүүлэх үнэт цаасны эцсийн шилжүүлэг (нийлүүлэлт) нь худалдан авагчаас худалдагч талд шилжүүлэх мөнгөн хөрөнгийн эцсийн шилжүүлэгтэй (төлбөр) нэг зэрэг хийгдсэнээр үнэт цаасны болон хөрөнгийн шилжүүлгийн даалгаврын аль алины төлбөр тооцоо арилжаа нэг бүрээр гүйцэтгэгдэнэ. Загвар 2-г, худалдагчаас худалдан авагчид шилжүүлэх үнэт цаасны эцсийн шилжүүлэг (нийлүүлэлт) боловсруулалтын хугацааны турш хийгдсэнээр үнэт цаасны шилжүүлгийн төлбөр тооцоо нэг бүрчлэн хийгдэх боловч худалдан авагчаас худалдагчид шилжүүлэх мөнгөн хөрөнгийн эцсийн шилжүүлэг (төлбөр) боловсруулалтын хугацааны эцэст хийгдсэнээр мөнгөн хөрөнгийн шилжүүлгийн даалгаврын төлбөр тооцоо харилцан суутгах тооцооны үндсэн дээр гүйцэтгэгдэнэ. Загвар 3-г, үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн эцсийн шилжүүлэг боловсруулалтын хугацааны эцэст хийгдсэнээр үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн хоёулангийнх нь шилжүүлгийн даалгаврын төлбөр тооцоо харилцан суутгах тооцооны үндсэн дээр гүйцэтгэгдэнэ.	<b>Blue Book</b>



<b>эрт дуусгавар болгох нөхцөл (early termination option)</b>	зарим тохиолдолд шимтгэлийн төлбөрөөс шалтгаалан дуусах хугацаанаас нь өмнө гэрээг дуусгавар болгох нөхцөлийн талаар аливаа нэгэн оролцогч этгээдэд тавигдаж байгаа гэрээний заалт.	<b>OTS</b>
<b>ЦМС (EDI)</b>	цахим мэдээний солилцоо-г харна уу.	
<b>АПРОМ (EEPROM)</b>	арчигдаж, програмчлагдаж болохуйц зөвхөн унших санах ой: өгөгдөл хадгалахад ашиглагддаг IC чипийн талбар. АПРОМ дахь мэдээллийг үйлдлийн системийн хяналтын дагуу арчиж мөн дахин бичиж болно.	<b>EM-Sec</b>
<b>ПОС (EFTPOS)</b>	худалдан авалтын цэг (ПОС)-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>цахим мэдээний солилцоо (electronic data interchange)</b>	арилжааны байгууллагуудын (зарим тохиолдолд мөн төрийн захиргааны байгууллага) хооронд хийгдэж байгаа төлбөрийн даалгавар, нэхэмжлэх, гаалийн баримт, мөнгөний шилжүүлгийн авизо, төлбөрүүд зэрэг мэдээний төрлүүдийн дугаартай хамаарал бүхий, стандартчлагдсан форматтай өгөгдлүүдийн цахим солилцоо. ЦМС-ны мессежүүд банкны системийн суваг болон олон нийтийн мэдээ дамжуулах сүлжээгээр дамжин илгээгддэг. ЦМС-оор үүсгэгдсэн мөнгөн хөрөнгийн бүхий л хөдөлгөөн нь банкны системээр дамжих төлбөрийн даалгаврын урсгал байдлаар илэрдэг. Нэгдсэн Үндэстний Байгууллагын нэгж болох EDIFACT-аас цахим мэдээний солилцооны стандартыг тогтоосон.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>цахим мөнгө (electronic money)</b>	чип карт эсвэл персонал компьютерын хард драйвер гэх мэт төхөөрөмжид цахим байдлаар хадгалагдсан дүн.	<b>Retail</b>
<b>цахим хэтэвч (electronic purse)</b>	зоосны оронд эсвэл бага хэмжээний төлбөрт хэрэглэгддэг, дахин цэнэглэж, төрөл бүрийн зорилгоор ашиглах боломжтой, урьдчилсан төлбөрт карт. Төрөл бүрийн зорилгоор ашиглаж болох урьдчилсан төлбөрт карт-г харна уу.	<b>Blue Book EM-CPSS EM-ECB</b>
<b>цахим түрийвч (electronic wallet)</b>	IC картыг багтаасан эсвэл IC картыг оруулснаар IC картаас илүү олон функц гүйцэтгэх боломжтойгоор зарим цахим мөнгөний системд ашиглагдаж буй компьютерын төхөөрөмж.	<b>EM-Sec</b>
<b>шигтгэх (embedding)</b>	IC карт үйлдвэрлэл дэх пластик зөөгч (карт)-ид чип модулийг суурилуулах процесс.	<b>EM-Sec</b>

<b>инкрипшн (encryption)</b>	зөвшөөрөгдөөгүй хандалтаас сэргийлэх зорилгоор энгийн текст өгөгдлийг шифрлэх криптографийн алгоритмын хэрэглээ.	<b>EM-Sec</b> EM-CPSS EM-ECB
<b>өдрийн эцэст тооцоо нь хийгдэх нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем (end-of-day gross settlement systems)</b>	ажлын өдрийн туршид төлбөр тооцооны агент гүйлгээ нэг бүрээр хүлээж авах боловч эцсийн төлбөр тооцоо тухайн өдрийн эцэст нэг нэгээр эсвэл нийтээр нэг бүрчлэн хийгддэг, хөрөнгийн шилжүүлгийн систем. Мөн энэ тодорхойлолтыг төлбөрүүд бодит цагийн горимд хийгддэг боловч тухайн өдрийн эцэс хүртэл төлбөрийг буцааж болдог, нэг бүрчилсэн төлбөр тооцооны системд хэрэглэдэг.	<b>Blue Book</b>
<b>дотооддоо үүргээ биелүүлж чадахгүй болох (endogenous default)</b>	гадаад эх үүсвэрээс бий болох алдагдлыг оруулан тооцохгүйгээр тухайн клирингийн төвийн гишүүний мэдэлд байгаа клирингийн төвийн болон үйлчлүүлэгчийн хөрөнгийг алдагдалд оруулж, клирингийн гишүүний үүргээ биелүүлж чадахгүй болох байдал.	<b>ETDC</b>
<b>эцсийн хэрэглэгч (end user)</b>	хөрөнгө оруулалт эсвэл хамгаалалтын зорилгоор деривативаар позици авч буй нэгж. Эцсийн хэрэглэгч нь үргэлж арилжааны зөвхөн нэг талд үйл ажиллагаа явуулдаг. Эцсийн хэрэглэгч гэдэгт банкууд, даатгалын компаниуд, тэтгэврийн сангууд, бусад санхүүгийн байгууллагууд, засгийн газар, үндэстнүүдийн холбооны дээд байгууллагууд (жишээ нь, Дэлхийн Банк) өндөр үнэ цэнэтэй хөрөнгө бүхий хувь хүн орно.	<b>OTC</b>
<b>ЕПРОМ (EPROM)</b>	програмчлагдах боломжтой зөвхөн унших санах ой: өгөгдөл хадгалахад ашиглагддаг IC чипийн талбар. ЕПРОМ дахь мэдээлэл зөвхөн ганц удаа бичигдэх ба сонгож арилгах боломжгүй.	<b>EM-Sec</b>
<b>хувьцааны своп (equity swap)</b>	хүлээн зөвшөөрөгдсөн хувьцааны индекс буюу тогтмол эсвэл хөвөгч хүүтэй тодорхой хувьцаануудын тогтоосон сагсны өгөөжийн арилжаанд хамаарах своп.	<b>OTC</b> SLT
<b>үүргээ биелүүлж чадахгүй болох тохиолдол (event of default)</b>	үүргээ биелүүлж чадахгүй болсныг тогтоохоор гэрээнд тодорхойлогдсон тохиолдол. Ерөнхийдөө үүргээ биелүүлэх чадваргүй болох тохиолдол гэдэгт хугацаанд нь нийлүүлэлтээ эсвэл төлбөрөө хийх чадваргүй болох, гэрээгээ зөрчих, төлбөрийн чадваргүй болох зэрэг нь хамаарна.	<b>OTC</b> SLT

<b>хөрөнгийн дүнгээр солилцох төлбөр тооцооны систем (exchange-for-value settlement system)</b>	төлбөр тооцооны үүргийг барагдуулах зорилгоор мөнгө, гадаад валют, үнэт цаас, санхүүгийн бусад хэрэгсэл зэрэг активуудыг солилцохтой холбоотой систем. Эдгээр системүүд нь үүссэн төлбөрийн үүргийг хангуулахын тулд нэг болон түүнээс дээш хөрөнгийн шилжүүлгийн системийг ашиглаж болдог. Актив болон төлбөрийн системийн солилцооны хоорондын холбоос нь гар ажиллагаатай эсвэл цахим байж болно. Төлбөрийн эсрэг нийлүүлэлтийн систем-г мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>хөрөнгийн биржийн гишүүн (exchange member)</b>	арилжааны тодорхой эрхийг эзэмшиж байгаа, биржийн гишүүн. Биржийн гишүүн нь заавал биржийн клирингийн төвийн гишүүн байх шаардлагагүй.	<b>ETDC</b>
<b>бирж дээр арилжаалагдаж байгаа дериватив (exchange traded derivative)</b>	зохион байгуулалттай зах зээл дээр бүртгэлтэй буюу арилжаалагдаж байгаа дериватив. Деривативын бирж ерөнхийдөө стандарт хангасан гэрээ байгуулж, оролцогчдод төвлөрсөн клирингийн үйлчилгээг үзүүлдэг.	<b>OTC</b>
<b>гарах шалгуур (exit criteria)</b>	төлбөрийн системд одоо байгаа оролцогчийн оролцоогоо дуусгах шалгуур.	<b>Core Principles</b>
<b>"нүүр тулж" хийх төлбөр (face-to-face payment)</b>	яг нэг газар (байршил)-т төлбөр төлөгч болон төлбөр хүлээн авагчийн хоорондын төлбөрийн хэрэгслүүдийн солилцоог хийх замаар гүйцэтгэж байгаа төлбөр.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-CPSS</b> <b>EM-ECB</b> <b>Retail</b>
<b>саатал (fail)</b>	ихэвчлэн техникийн буюу түр зуурын хүндрэлийн улмаас гэрээнд заасан төлбөр тооцоо хийгдэх ёстой өдөрт үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоог хийгдэж чадахгүй байх тохиолдол. Саатал нь "үүргээ биелүүлж чадахгүй болох"-оос ялгаатай. Мөн саатсан гүйлгээ гэж нэрлэдэг.	<b>SLT</b>
<b>саатсан гүйлгээ (failed transaction)</b>	техникийн буюу түр зуурын шалтгааны улмаас тохиролцсон ёсоор төлбөр тооцоо хийгдэх өдөр үнэт цаас болон мөнгөн хөрөнгийг солилцож чадахгүй болсон үеийн үнэт цаасны гүйлгээ.	<b>DVP</b> <b>SDF</b>
<b>саатсан гүйлгээ (failed transaction)</b>	гэрээгээр хүлээсэн төлбөр тооцооны хугацаандаа хийгдээгүй үнэт цаасны гүйлгээ.	<b>SSS</b>
<b>эцэслэлт (final (finality))</b>	үл буцаагдах болон нөхцөлт бус байдал.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>эцэслэлтийн эрсдэл (finality risk)</b>	хөрөнгийн буюу үнэт цаасны болзолт шилжүүлэг цуцлагдаж болох үеийн эрсдэл.	<b>SDF</b>

<b>эцсийн төлбөр тооцоо (final settlement)</b>	үл буцаагдах болон нөхцөлт бус төлбөр тооцоо.	<b>Red Book</b> Blue Book
<b>эцсийн төлбөр тооцоо (final settlement)</b>	үл буцаагдах болон нөхцөлт бус болсон хөрөнгө шилжүүлэх болон үнэт цаас шилжүүлэх үүргийн гүйцэтгэл.	<b>SSS</b>
<b>эцсийн шилжүүлэг (final transfer)</b>	шилжүүлэг хийх үүргээ гүйцэтгэхэд нөлөөлж байгаа үл буцаагдах болон нөхцөлт бус шилжүүлэг. "нийлүүлэлт" болон "төлбөр" гэсэн нэр томъёоны аль аль нь эцсийн шилжүүлгээр тодорхойлогдоно. Болзолт шилжүүлэг-г харна уу.	<b>DVP</b> Red Book Blue Book x-border SDF Retail
<b>санхүүгийн эрсдэл (financial risk)</b>	энэ нь санхүүгийн гүйлгээнд учирч болох эрсдэлийн хүрээг хамарсан нэр томъёо бөгөөд төлбөр түргэн гүйцэтгэх чадвар болон зээлийн эрсдэл хоёулаа багтдаг. Зээлийн эрсдэл/эрсдэлд өртөх дүн, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл – ийг харна уу.	<b>Core Principles</b>
<b>галт хана (firewall)</b>	хүлээн авч байгаа болон илгээж байгаа мэдээллийг хянан шүүх зорилготой, интернэт болон компьютерын системийн хооронд интерфэйсээр ашиглагдаж буй компьютерын техник хангамжид суурилсан болон/эсвэл програм хангамжид суурилсан систем.	<b>EM-Sec</b>
<b>"цэвэр" (fleckless)</b>	Германы толбогүй гэсэн утгай бүхий "fleckelos" гэдэг үгнээс гаралтай. Хөндлөнгөөс оролдоогүй гэдгийн нотолж чадсанаар төхөөрөмж (карт) буюу системийг цэвэр гэж хэлдэг.	<b>EM-Sec</b>
<b>албадлагын төлбөр тооцоо (forced settlement)</b>	гуравдагч этгээдийн үйлдлээр тулгагдан эсвэл бүрэн эрхээр нь хийсэн үнэт цаасны буюу хөрөнгийн төлбөр тооцоо.	<b>SDF</b>
<b>валютын арилжааны төлбөр тооцооны эрсдэл (foreign exchange settlement risk)</b>	гадаад валютын арилжааны гүйлгээний нэг тал нь худалдаж буй валютын төлбөрөө төлсөн боловч худалдан авч буй валютаа хүлээн авч чадахгүй үед үүсэх эрсдэл. Үүнийг мөн кросс-валютын эрсдэл эсвэл үндсэн дүнгийн эрсдэл гэж нэрлэдэг. Хэдийгээр энэ нь эрсдэл бодит болох нөхцөлийг ялгаж өгсөн тохиромжтой биш нэр томъёо ч Херштатын эрсдэлд хамаатай.	<b>Blue book</b>
<b>форвард хэлцэл (forward contract)</b>	суурь активыг ирээдүйн тодорхой нэгэн цагт, тогтоосон үнээр нэг тал нь худалдан авч, нөгөө нь худалдах тухай үүрэг хүлээсэн гэрээ.	<b>ETDC</b> OTC

<b>форвардын хүүгийн гэрээ (forward rate agreement)</b>	хүүгийн талаарх форвард гэрээ. Гэрээ байгуулах үед тодорхой хугацаанд тусгайлсан үүргийн дагуу төлөгдөх эсвэл хүлээн авах хүү.	<b>OTC</b>
<b>төлбөргүй нийлүүлэлт (free-of-payment delivery)</b>	холбогдох мөнгөн хөрөнгийн төлбөргүйгээр үнэт цаасны нийлүүлэх.	<b>SLT</b>
<b>арилжааны алба (front office)</b>	оролцогч талуудтай харьцах харилцааг удирдах болон хөгжүүлэх үүрэгтэй, байгууллагын үйл ажиллагааны нэгж болон бусад хэсэг. Арын алба-г харна уу.	<b>OTC</b>
<b>ХШС (FTS)</b>	хөрөнгийн шилжүүлгийн систем-г харна уу.	
<b>хөрөнгийн шилжүүлгийн систем (funds transfer system)</b>	гишүүдийн хооронд үүсч байгаа мөнгөн үүргийн төлбөр тооцоог хийх, дамжуулахад зориулалттай, олон тооны гишүүнчлэл, нийтлэг дүрэм болон стандартчилсан зохицуулалт бүхий гэрээ эсвэл хууль тогтоомжид үндэслэгдсэн албан ёсны зохицуулалт. Банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем-г харна уу.	<b>Blue Book</b>
<b>харилцан орлуулах боломж (fungibility)</b>	тусгаарлагдсан, харилцан орлуулах сангуудад байршуулсан биет эсвэл биет бус үнэт цааснуудыг төвлөрсөн хадгаламжийн төв эсвэл санхүүгийн дундын байгууллагад байршуулах аргыг тэмдэглэдэг ойлголт. Ямар ч үнэт цаасны эзэмшигч нь тухайн сан дахь аль нэг үнэт цаасыг биет эсвэл биет бус хэлбэртэй байлгах эрхгүй боловч төвлөрсөн хадгаламжийн төв болон санхүүгийн зуучлагч байгууллага дахь өөрийн дансанд тусгаснаар биет эсвэл биет бус үнэт цаасныхаа дүн мэдэх эрхтэй байдаг.	<b>Blue Book</b>
<b>фьючерс хэлцэл (futures contract)</b>	бирж дээр арилжаалагдаж байгаа стандарт форвард хэлцэл.	<b>ETDC</b>
<b>маржинд хэрэглэх фьючерс арга (futures-style margining)</b>	позициуд нь зах зээл дээр дахин үнэлэгдэж байгаа бөгөөд одоогийн алдагдал нь хэлбэлзлийн маржин гэгдэх бэлэн төлбөрөөр барагдуулагдаж байгаа дериватив хэлцлүүдийн маржин тогтоох арга. Фьючерс болон опшин гэрээнүүд нь иймэрхүү хэлбэрээр маржин тогтоогдож болдог. Опшин хэлцлүүд нь фьючерс-хэлбэрийн системээр маржин тогтоогдсон тохиолдолд оршины нэмэлт төлбөр нь опшины хүчинтэй хугацаанд үе шаттайгаар төлөгддөг ба опшин нь дуусахад үед нэг удаа бүрэн төлөгддөг. Опшин-хэлбэрийн маржин-г харна уу.	<b>ETDC</b>

<b>ерөнхий барьцаа (general collateral)</b>	мөнгөн хөрөнгөө зээлүүлэхэд нь барьцаа болох, зээлдүүлэгчийн ерөнхий шаардлагыг хангасан үнэт цаасууд. Ерөнхий барьцаанд зах зээл дээр онцгой эрэлттэй биш үнэт цаасууд орно; ерөнхий барьцааны төрлүүд ихэвчлэн зах зээлийн хэлэлцээрээр тодорхойлогддог.	<b>SLT</b>
<b>жиро систем (giro system)</b>	кредит шилжүүлгийн систем-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>глобал кастодиан (global custodian)</b>	өөрийн харилцагчдад кастодиан байрлаж байгаа улс оронд төдийгүй дэлхийн бусад олон улс орнуудад үнэт цаас арилжих болох төлбөр тооцоог нь гүйцэтгэхтэй холбоотой кастодийн үйлчилгээг үзүүлдэг кастодиан.	<b>x-border SDF SSS</b>
<b>түгжрэл (gridlock)</b>	зарим төлбөрийн даалгаврын саатал (шаардлагатай мөнгөн хөрөнгө болон үнэт цаасны үлдэгдлийн бэлэн бус байдал)-аас шалтгаалан бусад оролцогчдын их хэмжээний төлбөрийн даалгаварт саад учруулах, мөнгөн хөрөнгийн буюу үнэт цаасны шилжүүлгийн системд үүсч болох тохиолдол. саатсан гүйлгээ, дараалал, болон системийн эрсдэл – г харна уу.	<b>Red Book Blue Book SDF</b>
<b>нийт маржин (gross margining)</b>	өөрийн үйлчлүүлэгчдийн нийт позицийг дааж байхын тулд клирингийн төвийн анхдагч маржинд хүрэлцээтэй депозит байршуулахыг клирингийн гишүүдээс шаарддаг маржингийн систем.	<b>ETDC</b>
<b>нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем (gross settlement system)</b>	мөнгөн хөрөнгийн буюу үнэт цаасны шилжүүлгийн даалгаврын төлбөр тооцоо нь нэг бүрээр хийгдэх (шилжүүлгийн даалгавар нэг бүрээр) шилжүүлгийн систем.	<b>x-border SDF</b>
<b>хэйркат (haircut)</b>	үнэт цаасны зах зээлийн үнэ болон түүний барьцаа хөрөнгийн үнэ хоёрын зөрүү. Үнэт цаасны зах зээлийн үнийн бууралтын улмаас үүссэн алдагдлаас өөрийгөө хамгаалах (зайлшгүй тохиолдолд барьцааг хөрвүүлэх) зорилгоор мөнгөн хөрөнгө зээлдүүлэгч хэйркатыг хэрэглэдэг. Цэвэр маржин-г харна уу.	<b>Red Book Blue Book SDF</b>
<b>эрсдэлээс хамгаалах сан (hedge fund)</b>	ихэнхдээ зээлийн хөрөнгө ашиглан, идэвхтэй арилжааны стратегид (арбитражийг оруулан) оролцдог хувийн хөрөнгө оруулалтын сан. Хөжсөн голдуу хязгаарлагдмал зохицуулалтын хяналтаас хамаардаг.	<b>SLT</b>
<b>Херштатын эрсдэл (Herstatt risk)</b>	үндсэн дүнгийн эрсдэл-г харна уу.	<b>Red Book</b>

<b>банкны зайнаас хандах үйлчилгээ (home banking)</b>	бага дүнтэй гүйлгээ хийдэг харилцагч нь харилцаа холбооны шугамын тусламжтайгаар санхүүгийн байгууллагынхаа компьютерын төвд холбогдож телефон, телевизор, терминал буюу персонал компьютер ашиглан авч чадах банкны үйлчилгээ.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-CPSS</b> <b>Retail</b>
<b>зогсоох жагсаалт (hot list)</b>	картын системд, картаар үйлчлэх байгууллагын терминал буюу бусад төхөөрөмж дээр байгаа сэжигтэй картын дугаар эсвэл сэжигтэй картын дугааруудын серийн жагсаалт. Зогсоох жагсаалтыг сэжигтэй картаар хийсэн ямарваа гүйлгээг саатуулах буюу илрүүлэхэд ашигладаг.	<b>EM-Sec</b>
<b>холимог систем (hybrid system)</b>	БЦНТТСистем (RTGS) болон үр дүнгийн төлбөр тооцооны системийн онцлог шинжүүдийг хослуулсан төлбөрийн систем.	<b>Core Principles</b>
<b>IC карт (IC card)</b>	чип карт-г харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-CPSS</b>
<b>IC карт (нэгдсэн схемт) (IC (integrated circuit) card)</b>	нэг болон түүнээс олон нэгдсэн схемийг шигтгэсэн пластик карт. Мөн чип карт гэж нэрлэдэг.	<b>EM-Sec</b>
<b>ОУТХТ (ICSD)</b>	олон улсын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв-г харна уу.	
<b>БХХШС (IFTS)</b>	банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем-г харна уу.	
<b>эргэлтэд оруулахгүй байх (immobilisation)</b>	үнэт цаасны цахим шилжүүлгийн бүртгэлийг хялбарчлахын тулд биет гэрчилгээтэй үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд байршуулах ажиллагаа.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b>
<b>эргэлтэд оруулахгүй байх (immobilisation)</b>	үнэт цаасны болон санхүүгийн хэрэгслийн биет гэрчилгээг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд байршуулах ажиллагаа. Үүний дүнд хадгалагч дахь эзэмшигчийн дансыг дебитлэх болон кредитлэх замаар дараа дараагийн шилжүүлгүүдийг цахим бүртгэлийн үндсэн дээр хийх боломжтой болно.	<b>SSS</b>
<b>импринтер (imprinter)</b>	карт эзэмшигчийн нэр болон дансны дугаарыг худалдан авалтын квитанци дээр хуулбарлах механик төхөөрөмж. Импринтерийн ваучерыг мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>

<b>импринтерийн ваучер (imprinter voucher)</b>	картын гүйлгээнд ашиглагддаг, импринтерээр харилцагчийн нэр болон картын дугаарыг хэвлэсэн, харилцагчийн гарын үсэг бүхий квитанци.	<b>Red Book Blue Book</b>
<b>алдагдлыг нөхөн төлөх (indemnification)</b>	алдагдал, гарз хохирлыг нөхөн төлөх тохиролцоо. Зарим тохиолдолд, кастодиан нь үүнийг зээлдэгч-харилцагч нартаа янз бүрийн хэлбэрээр санал болгодог.	<b>SLT</b>
<b>шууд бус эзэмшигчийг бүртгэх систем (indirect holding system)</b>	(i) итгэмжлэгдсэн этгээд нь гаргагчийн албан ёсны бүртгэл дээр үнэт цаасны хууль ёсны эзэмшигчээр бичигдсэн, харин ашиг хүртэгч (эсвэл үнэт цаасыг хамгийн сүүлд нь эзэмшиж байсан зуучлагч) нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийн бүртгэл дээр үнэт цаасны эзэмшигчээр бүртгэгдсэн, эсвэл (ii) үнэт цаас мэдүүлэгч нь зуучлагчид өгч, зуучлагч нь тухайн үнэт цаасны ашиг хүртэгчийн эрх болон ашиг сонирхлыг тусгасан дансыг хөтөлдөг үнэт цаасны бүртгэлийн систем. Шууд бус эзэмшигчийг бүртгэх системд үнэт цаасны ашиг хүртэгчийн эрх, ашиг сонирхлыг нь итгэмжлэгдсэн төлөөлөгчийн эсвэл зуучлагчийн дансанд бичилт хийх замаар бүртгэлийн үндсэн дээр шилжүүлдэг.	<b>SSS</b>
<b>арилжаанд шууд бус оролцогч (indirect market participant)</b>	арилжаанд оролцохдоо өөрийгөө төлөөлүүлэн зуучлагчийн үйлчилгээ ашигладаг зах зээлийн оролцогч. Ихэвчлэн харилцагч байгууллага болон хил дамнасан үйлчлүүлэгчид зах зээлийн шууд бус оролцогч болдог. Шууд бус оролцогч/гишүүнг харна уу.	<b>SSS</b>



<p><b>шууд бус оролцогч/ гишүүн (indirect participant/member)</b></p>	<p>шаталсан зохицуулалт бүхий хөрөнгийн буюу үнэт цаасны шилжүүлгийн системд хамаарна. Шууд бус оролцогч нь шууд оролцогчийн гүйцэтгэдэг системийн зарим үйл ажиллагааг (жишээлбэл, шилжүүлгийн даалгаврыг системд оруулах, төлбөр тооцоо хийх) гүйцэтгэх боломжгүй байдгаараа шууд оролцогчоос ялгаатай. Иймээс шууд бус оролцогчид өөрийнх нь өмнөөс эдгээр үйл ажиллагааг гүйцэтгэхэд шууд оролцогчийн үйлчилгээ шаардлагатай болдог. Европын Холбоонд энэ нэр томъёо нь тухайн системд оруулсан төлбөрүүдийн төлбөр тооцоог гүйцэтгүүлэхээр зөвхөн өөрсдийн шууд оролцогчийн өмнө хариуцлага хүлээдэг шилжүүлгийн системийн оролцогчид хамааруулан илүү явцуу утгаар хэрэглэгддэг. Шууд оролцогч/ гишүүн, төлбөр тооцооны оролцогч/ гишүүн, шаталсан зохицуулалт-г харна уу.</p>	<p><b>Red Book</b></p>
<p><b>анхны маржин (initial margin)</b></p>	<p>клирингийн төвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхийн баталгаа болгох зорилгоор клирингийн төвд байршуулсан бэлэн мөнгө эсвэл барьцаа (үүргээ биелүүлэх баталгаа буюу анхдагч маржин гэдгээр нь мэддэг).</p>	<p><b>ETDC</b></p>
<p><b>төлбөрийн нэхэмжлэх (inpayment)</b></p>	<p>төлбөр хүлээн авагчийн бичсэнээр бараа үйлчилгээний тооцооны хуудастай хамт илгээгдэх төлбөрийн даалгавар; төлбөр төлөгч нь заасан банкны дансанд төлөх юмуу эсвэл заасан агент (банк буюу банк бус)-д бэлэн мөнгөөр төлбөрийн төлж болно.</p>	<p><b>Retail</b></p>
<p><b>бүрэн бүтэн байдал (integrity)</b></p>	<p>санамсаргүй буюу зориудын өөрчлөлтөөс хамгаалагдсан байх эсвэл өөрчлөлт хийгдсэн эсэхийг үзүүлэх чанар.</p>	<p><b>EM-Sec</b></p>
<p><b>банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем (interbank funds transfer system)</b></p>	<p>ихэнх (эсвэл бүх) шууд оролцогчид нь санхүүгийн байгууллагууд, ялангуяа бан кууд болон бусад зээлийн байгууллагууд байх, хөрөнгийн шилжүүлгийн систем.</p>	<p><b>Red Book Blue Book</b></p>
<p><b>гаргагчийн шимтгэл (interchange fee)</b></p>	<p>төлбөрийн картын сүлжээний оролцогч нэг санхүүгийн байгууллагын нөгөө байгууллагадаа төлөх шимтгэл. Жишээлбэл, карт эзэмшигчийн карт хүлээн авагч (КҮБ)-д төлөх картаар хийгддэг төлбөртэй холбоотойгоор эквайрэрээс карт гаргагчид төлбөл зохих гүйлгээний шимтгэл.</p>	

<b>харилцан холбогдох механизм (interlinking)</b>	TARGET (TARGET) систем дэх харилцан холбогдох механизм нь нэг улсын дотоодын БЦНБТТ-ны (RTGS) системээс нөгөө улсын дотоодын БЦНБТТ-ны системд төлбөрийн даалгаврыг шилжүүлэх боломжтой дэд бүтэц, ерөнхий горимоор хангадаг. TARGET-г харна уу.	<b>Blue Book</b>
<b>дотоод төлбөр тооцоо (internal settlement)</b>	нэг зуучлагч байгууллагын бүртгэлд үнэт цаасны болон хөрөнгийн шилжүүлгээр хийгдэж байгаа төлбөр тооцоо. Дотоод төлбөр тооцоо нь оролцогч хоёр талын хоёулангаас нь нэг зуучлагч байгууллагад үнэт цаасны болон мөнгөн хөрөнгийн дансаа байршуулахыг шаарддаг.	<b>x-border SDF</b>
<b>олон улсын, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага (international central securities depository)</b>	дотоодын үнэт цаасны хил дамнасан арилжааны эсвэл олон улсын үнэт цаасны клиринг болон төлбөр тооцоог хийдэг үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв. Одоогоор Европын Холбоонд Clearstream and Euroclear гэсэн хоёр ОУҮЦТХТ байна.	<b>Blue Book</b>
<b>олон улсын, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага (international central securities depository)</b>	ихэвчлэн дотоодын ҮЦТХТ-үүдтэй шууд эсвэл шууд бус (дотоодын агентуудаар) холбоогоор дамжуулан олон улсын үнэт цаасны болон дотоодын янз бүрийн үнэт цаасны арилжааны төлбөр тооцоог хийдэг, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв.	<b>SSS</b>
<b>интернет (internet)</b>	компьютеруудын хооронд мэдээлэл солилцох, алсын зайнаас мэдээлэлд хандах боломж олгодог, харилцан холбоотой компьютерын сүлжээ бүхий олон улсын харилцаа холбооны нээлттэй дэд бүтэц.	<b>EM-Sec EM-CPSS EM-ECB</b>
<b>харилцан ажиллах чадвар (interoperability)</b>	өгөгдсөн схемд хамаарал бүхий төлбөрийн хэрэгсэл нь өөр схемд суурилсан систем болон өөр улс оронд ашиглагдах боломжтой байх нөхцөл. Харилцан ажиллах чадвар нь системүүдийн хооронд техникийн зохицлыг шаарддаг ч зөвхөн тухайн схемүүдийн хооронд арилжааны гэрээ байгуулсан нөхцөлд л үйлчилж эхэлдэг.	<b>EM-ECB</b>
<b>өдрийн зээл (intraday credit)</b>	өдрийн зээл-г харна уу.	<b>Red Book</b>
<b>өдөр дундын төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (intraday liquidity)</b>	санхүүгийн байгууллагад бодит цагт төлбөр гүйцэтгэх боломжтойгоор ажлын өдрийн туршид ашиглаж болох хөрөнгө.	<b>Blue Book</b>

<b>эргэлт буцалтгүй болон нөхцөлт бус шилжүүлэг (irrevocable and unconditional transfer)</b>	шилжүүлэгч тал буцаан татах боломжгүй, нөхцөлт бус шилжүүлэг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <i>DVP</i> <i>SDF</i>
<b>эргэлт буцалтгүй шилжүүлэг (irrevocable transfer)</b>	шилжүүлэгч буцаан татах боломжгүй шилжүүлэг.	
<b>ОУСБ (ISO)</b>	Олон Улсын Стандартчиллын Байгууллага: үндэсний стандартчиллын байгууллагуудаас гишүүд нь бүрддэг, олон улсын стандартыг хүлээн зөвшөөрч, хөгжүүлж, хэвлэн гаргах эрх бүхий олон улсын байгууллага.	<b>EM-Sec</b>
<b>гаргагч (issuer)</b>	хадгалагдсан өртгийн буюу ижил төстэй урьдчилсан төлбөрт цахим мөнгөний систем дэх системийн хуваарилсан өртгийг солилцох үед төлбөрийг хүлээн авч, төлбөр хийсэн цахим хэрэгслийн гүйлгээ буюу үлдэгдлийг төлөх эсвэл бэлэн мөнгө болгох үүрэг бүхий байгууллага.	<b>EM-Sec</b> <b>EM-CPSS</b>
<b>гаргагч (issuer)</b>	үнэт цаас буюу бусад санхүүгийн хэрэгслээр үүрэг хүлээсэн байгууллага. Жишээлбэл, корпораци эсвэл засгийн газар үнэт цаас гаргах болон арилжаалах эрхтэй байдаг, эсвэл банк аккредитивын зөвшөөрөл олгодог. Зарим тохиолдолд гаргагч гэдэг нь кредит буюу дебит карт гаргадаг санхүүгийн байгууллагад хамааран хэрэглэгддэг нэр томъёо.	<b>Blue Book</b>
<b>гаргагчийн агент (issuing agent)</b>	гаргагчийн тусын тулд үнэт цаасыг түгээх болон арилжаанаас олсон орлогыг хүлээн авдаг, үнэт цаас гаргагчийг төлөөлдөг байгууллага.	<b>SDF</b>
<b>гаргагч байгууллага (issuing institution)</b>	системд хуваарилагдсан өртгийг солилцох үед хөрөнгийг хүлээн авдаг бөгөөд зарчмын хувьд төлбөр хийлгэхээр өгсөн харилцагчийн гүйлгээний болон төлбөрт өгөөд ашиглагдаагүй үлдсэн хөрөнгийг төлөх буюу буцаан олгох үүрэг бүхий байгууллага. Энэ нь ерөнхийдөө хөвөгч хөрөнгөд хөрөнгө оруулдаг байгууллага.	<b>EM-ECB</b>
<b>түлхүүр (key)</b>	криптографийн алгоритмын хослолын тусламжтайгаар үүссэн үл давтагдах тоон дараалал.	<b>EM-Sec</b>
<b>түлхүүрийн урт (key length)</b>	инкрипшн түлхүүрийг бүрдүүлж буй битийн тоо	<b>EM-Sec</b>

<b>түлхүүрийн удирдлага (key management)</b>	криптографийн зорилгоор компьютерын системд ашиглагдах түлхүүрүүдийн хоорондын харилцан хамаарал болон түлхүүрүүдийн ашиглалтын явцын загварчлал. Өөрөөр хэлбэл, үйлдлийн системд хамааруулан үзвэл, компьютерын системд ашиглагддаг криптографийн түлхүүрүүдийг үүсгэх, хадгалах, шинэчлэх процесс.	<b>EM-Sec</b>
<b>их дүнтэй хөрөнгийн шилжүүлгийн систем (large-value funds transfer system)</b>	харилцагчдыг төлөөлөн буюу өөрийн дансаар системд оролцогчдын хооронд хийгдэж байгаа их дүнтэй, өндөр эрэмбийн хөрөнгийг дамжуулах хөрөнгийн шилжүүлгийн систем. Хэдийгээр төлбөрийн дүнгийн доод хэмжээг дүрмээр тодорхойлоогүй ч, ийм системээр дамжих ихэнх төлбөрүүдийн дундаж нь харьцангуй их дүнтэй байдаг. Зарим тохиолдолд их дүнтэй хөрөнгийн шилжүүлгийн системийг бөөний хөрөнгийн шилжүүлгийн систем гэж нэрлэдэг.	<b>EM-CPSS</b> <i>Blue Book</i>
<b>их дүнтэй төлбөр (large-value payments)</b>	ихэнхдээ яаралтай болон цаг тухайд нь төлбөр тооцоог хийх шаардлагатай, санхүүгийн зах зээлийн оролцогчийн хооронд эсвэл банкуудын хооронд солилцож байдаг маш их дүнтэй төлбөрүүд.	<b>EM-CPSS</b> <i>Blue Book</i>
<b>аккредитив (Л/С) (L/C)</b>	аккредитив-г харна уу.	
<b>хууль ёсны эзэмшил (legal ownership)</b>	хуулийн дагуу үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийн эзэмшигчээр хүлээн зөвшөөрөх явдал. Энэ нь "хууль ёсны эрхийг" төлөөлдөг ба зарим тохиолдолд ашиг хүртэх эзэмшил/сонирхлоос ялгаатай. Ашиг хүртэх эзэмшил/сонирхол, хууль ёсны эрх-г мөн харна уу.	<b>SLT</b> <b>SDF</b>
<b>хууль зүйн эрсдэл (legal risk)</b>	хууль буюу журамд тусгагдаагүй хэрэглээнээс эсвэл гэрээнд заагдаагүй нөхцөл байдлаас шалтгаалан үүсэх алдагдлын эрсдэл.	<b>x-border</b> <i>ETDC</i> <i>OTC</i> <i>SDF</i> <i>SLT</i>
<b>хууль зүйн эрсдэл (legal risk)</b>	үнэт цаасны төлбөр тооцооны системийн дүрэм, холбогдох төлбөр тооцооны зохицуулалтын гүйцэтгэл, эсвэл төлбөр тооцооны системийн баримталж байгаа ашиг сонирхол болон хөрөнгийн эрх зэргийг хууль эсвэл журмаар зохицуулж чадахгүй байгаагаас үүдэн оролцогч тал хохиролд өртөх эрсдэл. Хууль зүйн эрсдэл нь мөн хууль эрх зүйн болон журмын хэрэглээний тодорхой бус байдлаас үүсдэг.	<b>SSS</b>

<b>хууль ёсны эрх (legal title)</b>	хуулийн дагуу хүлээн зөвшөөрөх буюу мөрдөх зүйл буюу ашиг хүртэх сонирхол агуулаагүй байж болох, өмчлөлийн болон эзэмшлийн тодорхой эрхийн хувьд эцсийн, төгс байх зүйл.	<b>SLT</b>
<b>аккредитив (letter of credit)</b>	тодорхой нөхцөлийн дагуу харилцагчийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөрийг хийхээр банк эсвэл бусад гаргагчаас баталсан амлалт. Олон улсын худалдаанд гадаад дахь мөнгөн хөрөнгийн хүрэлцээг хангахын тулд байнга хэрэглэдэг.	<b>Red Book Blue Book</b>
<b>хязгаарлалт (limit)</b>	зээлийн хязгаар-г харна уу.	
<b>хязгаарлагдмал зорилго бүхий урьдчилсан төлбөрт карт (limited-purpose prepaid card)</b>	нарийн тодорхойлсон хязгаарлагдмал тооны зорилгод ашиглаж болох, урьдчилсан төлбөрт карт. Энэхүү картын ашиглалтыг нарийн тодорхойлсон байрлал (жишээлбэл, барилга, корпораци эсвэл их сургууль) дахь сайтар тодорхойлсон цөөн тооны ПОС-аар хязгаарлаж байдаг. Ганц зорилго бүхий урьдчилсан төлбөрт картыг ашиглах тохиолдолд карт гаргагч болон үйлчилгээ үзүүлэгч нь нэг байж (жишээлбэл, нийтийн таксфонд хэрэглэх карт) болно. Урьдчилсан төлбөрт карт-г мөн харна уу.	<b>Blue Book EM-CPSS</b>
<b>төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл (liquidity risk)</b>	төлбөр тооцооны системд оролцогч тал (буюу төлбөр тооцооны системийн оролцогч) төлбөрийн үүргээ тухайн үед бүтэн дүнгээр нь биелүүлэх боломжгүй болсон үед үүсэх эрсдэл. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэл нь оролцогч тал (төлбөрийн системийн оролцогч)-ыг төлбөрийн чадваргүй болсон гэдэг утгыг агуулдаггүй. Учир нь хожим тодорхой бус хугацааны дараа оролцогч тал шаардлагатай өр төлбөрийн үүргээ биелүүлэх боломжтой болж болдог.	<b>Red Book Blue Book</b>
<b>ачаалах (load)</b>	гаргагчаас харилцагчийн төхөөрөмж рүү цахим балансыг дамжуулах үйлдэл.	<b>EM-Sec</b>
<b>ачаалах оператор (loading operator)</b>	ачаалж буй гүйлгээнд зориулан техникийн дэд бүтцээр хангадаг байгууллага.	<b>EM-ECB</b>
<b>орон нутгийн агент (local agent)</b>	арилжааны оролцогч талууд болон төлбөр тооцооны зуучлагч нь өөр улс оронд байрлаж (оршин суугч биш), өөрийн улс оронд арилжаалагдаж, төлбөр тооцоо нь хийгдэж байгаа үнэт цаасуудын хувьд кастодийн үйлчилгээ үзүүлж байгаа кастодиан.	<b>x-border SDF</b>

<b>орон нутгийн кастодиан (local custodian)</b>	өөрийнх нь байрлаж байгаа улс оронд арилжаалагдаж, төлбөр тооцоог нь хийгдэж байгаа үнэт цааснуудын хувьд кастодийн үйлчилгээ үзүүлж буй кастодиан. Глобал кастодиан-г харна уу.	<b>SDF</b>
<b>дэлгэрэнгүй баталгаажуулалт (long-form confirmation)</b>	ерөнхий гэрээнээс хуулийн гол нөхцөлийг нь багтаасан баталгаажуулалт. Оролцогч талуудын хооронд ерөнхий гэрээ байгуулаагүй бол зарим тохиолдолд дэлгэрэнгүй баталгаажуулалтыг эсвэл ерөнхий гэрээний стандарт нөхцөлийн заалтыг агуулсан баталгаажуулалтыг ашигладаг.	<b>OTC</b>
<b>урт позици (long position)</b>	үнэт цаасны худалдан авагч буюу эзэмшигч хэлцлийн дагуу нийлүүлэх ёстойгоосоо илүү үнэт цаасыг эзэмшиж байх нөхцөл. Богино борлуулалт-г харна уу.	<b>SLT</b>
<b>алдагдал хуваах гэрээ (loss-sharing agreement)</b>	системийн оролцогч эсвэл систем өөрийн үүргээ биелүүлээгүйгээс үүсэх ямар нэгэн алдагдлыг хуваах талаар клирингийн буюу төлбөр тооцооны системийн оролцогчдын хооронд байгуулсан тохиролцоо.	<b>SDF</b> <b>DVP</b>
<b>алдагдал хуваах сан (loss-sharing pools)</b>	оролцогчдын урьдчилан нийлүүлсэн, алдагдал хуваах гэрээний дагуу үүссэн үүрэг амлалтыг биелүүлэхийг баталгаажуулан системд байршуулсан бэлэн мөнгө, үнэт цаас болон боломжит бусад актив.	<b>SDF</b>
<b>алдагдал хуваах дүрэм (loss-sharing rule)</b>	нэг буюу түүнээс олон оролцогч өөрийн үүргээ гүйцэтгэх чадваргүй болсны улмаас үүссэн аливаа алдагдлыг хуваарилахтай холбоотой клирингийн төвийн зохицуулалт буюу шилжүүлгийн системийн оролцогчдын хоорондын гэрээ: гэрээ хүчин төгөлдөр болсноор талуудын хооронд алдагдлыг хэрхэн хуваах вэ гэдгийг энэхүү гэрээгээр тодорхойлдог. Мөн алдагдал хуваах гэрээ гэж нэрлэдэг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>МБК (MAC)</b>	мессеж баталгаажуулах код: дамжуулсан мэдээний бүрэн бүтэн байдлыг батлах болон үүний жинхэнэ гэдгийг нотлоход ашиглагддаг, түүнчлэн мессежэд хавсаргагдсан дугаарыг үүсгэхэд зориулагдсан түлхүүрээр параметр хийсэн хэш алгоритм.	<b>EM-Sec</b>

<p><b>соронзон тэмдэгтийг таних</b> (magnetic ink character recognition)</p>	<p>тусгай СТТ уншигч-машинд танигдах тэмдэгтүүдийг ашиглан баримтуудыг (тухайлбал, чек, кредит шилжүүлэг, шууд дебит) цахим боловсруулалтад зориулан унших аргачлал. Оптик аргаар таних-г харна уу.</p>	<p><b>Red Book</b> <b>Blue Book</b></p>
<p><b>нөхөх төлбөр</b> (manufactured payment)</p>	<p>хэрвээ үнэт цаасыг зээлүүлээгүй байсан бол зээлдүүлэгчийн үнэт цааснаасаа олох байсан бусад орлого (төлбөл зохих бүх татварыг суутгасны дараа) буюу ногдол ашгийн оронд үнэт цаас зээлдэгчээс зээлдүүлэгчид хийх эквивалент төлбөр.</p>	<p><b>SLT</b></p>
<p><b>маржин</b> (margin)</p>	<p>хамгийн наад зах нь хоёр утга байна. Фьючерсийн/бараа таваарын зах зээл дээр маржин нь үүргээ биелүүлэхэд фьючерсийн клирингийн системд зайлшгүй шаардлагатай баталгаат депозитыг (мөнгөний, үнэт цаас эсвэл бусад санхүүгийн хэрэгслийн) төлөөлдөг. Хувьцааны зах зээл дээр маржин нь хувьцаа худалдаж авахын тулд брокероос мөнгө зээлэх үед брокерт харилцагчийн байршуулсан мөнгөний нийлбэрийг төлөөлдөг. Брокерт байршуулсан мөнгө гэж хувьцааны худалдан авсан үнэ болон түүний барьцааны үнэ хоёрын зөрүү. Хэйркат-г харна уу.</p>	<p><b>Red Book</b> <b>Blue Book</b> <i>DVP</i></p>
<p><b>маржин</b> (margin)</p>	<p>ерөнхийдөө, бий болсон эсвэл боломжит үүргийг гүйцэлдүүлэх баталгаа болгон ашиглаж буй барьцааг тодорхойлох нэр томьёо. Үнэт цаасны зах зээл дээр харилцагчийн байршуулсан барьцаа нь үнэт цаас худалдан авах үед брокероос олгох зээлийн баталгаа болдог. Үнэт цаасны зуучлагч байгууллагын хувьд үүргээ гүйцэтгэх эсвэл төлбөр тооцоо нь хийгдээгүй арилжаанаас үүсэх бодит зах зээлийн хэлбэлзлийг хариуцахын баталгаа болгон барьцаа байршуулахыг маржин гэж тодорхойлдог.</p>	<p><b>SSS</b></p>
<p><b>маржингийн шаардлага</b> (margin call)</p>	<p>хэрэв суурь барьцааны зах зээлийн үнэ зээлүүлсэн активтай харьцуулахад тодорхой түвшнөөс доош орсон бол үнэт цаас зээлүүлсэн хэлцлийг зах зээлийн үнээр дахин үнэлсний дараа нэмэлт мөнгөн хөрөнгө эсвэл барьцаа тавих шаардлага. Үүний адилаар хэрэв барьцаа болгосон хөрөнгийн үнэ дахин үнэлгээний дараа тохирсон маржингаас давсан бол барьцааг буцааж өгөх шаардлага үүсч болно.</p>	<p><b>SLT</b></p>

<b>зах зээлийн эрсдэл (market risk)</b>	зах зээлийн үнийн өөрчлөлтөөс үүсэх балансын доторх болон балансын гадуурх позицийн алдагдлын эрсдэл.	<b>ETDC</b>
<b>зах зээлийн үнэ (market value)</b>	хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэрээг одоогийн зах зээлийн үнээр сольсноор олж авах орлого эсвэл төлбөл зохих зардал. Мөн орлуулах үнэ гэж нэрлэх нь бий.	<b>OTC</b>
<b>зах зээлийн үнээр дахин үнэлэх (marking to market)</b>	үнэт цаас болон санхүүгийн хэрэгслийг өнөөгийн зах зээлийн үнээр дахин үнэлэх практик. Зарим тохиолдолд төлбөр тооцоо нь хийгдээгүй байгаа үнэт цаасыг худалдах буюу худалдан авах хэлцлийг дахин үнэлдэг ба хэлцлээр хараахан бодит болоогүй байгаа алдагдлыг хүлээж буй оролцогч талаас нөгөө талдаа алдагдалтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгө эсвэл үнэт цаасыг шилжүүлэх ёстой болдог.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SLT</b> <b>SDF</b>
<b>зах зээлийн үнээр дахин үнэлэх (marking to market)</b>	өнөөгийн зах зээлийн үнээр санхүүгийн хэрэгслийн нээлттэй позицийг дахин үнэлэх болон сүүлийн үнэлгээнээс хойш үүссэн олз ба гарзыг тооцоолох явдал. Маржинд хэрэглэх фьючерс арга, маржинд хэрэглэх опшин арга, хэлбэлзлийн маржин-г мөн харна уу.	<b>ETDC</b> <b>OTC</b>
<b>маск (mask)</b>	нэгдмэл схемт (IC) чипийн үйл ажиллагааны болон физик шинж чанарыг тодорхойлсон, тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл (спецификаци).	<b>EM-Sec</b>
<b>ерөнхий гэрээ (master agreement)</b>	нөхөн төлөлтийн үеийн үр дүнгийн тооцооллын нөхцөлийг оруулаад, талууд үе үе оролцох боломжтой хэлцлийн тодорхойлогдсон дэд хэсэгт эсвэл нийтэд нь хэрэглэгдэх стандартын нөхцөлийг тогтоосон гэрээ.	<b>OTC</b>
<b>мастер түлхүүр master key</b>	криптографийн бусад түлхүүрүүдийг үүсгэхэд байнга хэрэглэгддэг криптографийн түлхүүр.	<b>EM-Sec</b>
<b>дээд ерөнхий гэрээ (master master agreement)</b>	ялгаатай ерөнхий гэрээгээр зохицуулагдаж байгаа хэлцлүүдийн нөхөн төлөлтийн үеийн үр дүнгийн тооцоололд тогтоосон "зонтик" гэрээ. Жишээлбэл, талууд биржийн гадуурх дериватив хэлцлийн ялгаатай төрлүүдэд тус тусдаа мастер гэрээ хэрэглэж байгаа үед зээлийн эрсдэлийг их хэмжээгээр бууруулахын тулд талууд дээд ерөнхий гэрээнд ордог.	<b>OTC</b>



<b>балансалсан бүртгэл (matched book)</b>	<p>төлбөрийн хугацаа нь ижил хөрөнгийн багц болон өр төлбөрийн багц. Энэ нэр томъёо нь мөнгөний захын хэрэгсэл болон мөнгөний захын пассивт хамгийн ихээр хамаардаг. Үнэт цаасны зээлдүүлэхтэй холбоотойгоор энэ нь үнэт цаасыг зээлж авах шалтгаан болох ба ингэснээр тогтсон хүүгээр мөнгө зээлүүлэх болон зээлэх зорилгоор ижил хугацаанд ижил үнэт цаасыг дахин зээлүүлэх хэрэг гардаг. Эсрэгээрээ баланслаагүй бүртгэл нь богино эсвэл урт хүүгийн позици авахдаа ялгаатай үргэлжлэх хугацаатайгаар ижил үнэт цаасыг зээлэх болон зээлүүлэхэд хамаардаг.</p>	<b>SLT</b>
<b>тулган шалгах (matching)</b>	<p>гүйлгээний нөхцөлтэй хамаатайгаар оролцогч талуудын зөвшөөрлийг баталгаажуулахын тулд оролцогч талуудын бэлтгэсэн арилжаа буюу төлбөр тооцооны дэлгэрэнгүйг харьцуулах процесс. Үүнийг мөн харьцуулан шалгах гэж нэрлэдэг.</p>	<b>SLT</b>
<b>санах ойн карт (memory card)</b>	<p>зөвхөн мэдээллийг хадгалах боломжтой IC (нэгдмэл схемт) карт.</p>	<b>EM-Sec</b>
<b>СТТ (MICR)</b>	<p>соронзон тэмдэгт таних-г харна уу.</p>	

**Ламфалуссын “хамгийн наад захын” стандарт (Ламфалуссын стандарт (minimum standards of the lamfalussy report (Lamfalussy standards)))**

хил дамнасан болон олон валютын үр дүнгийн тооцооллын (харилцан суутгах) схем буюу системийн загвар болон ажиллагаанд тавигдах зургаан минимум (хамгийн наад захын) стандарт. (i) Үр дүнгийн тооцооллын систем нь холбогдох эрх мэдлийн хүрээнд хууль зүйн маш сайн үндэслэлтэй байх ёстой. (ii) Үр дүнгийн тооцооны схемийн оролцогч нь харилцан суутгах ажиллагаанд хамаатай санхүүгийн эрсдэл бүр дэх тодорхой схемийн нөлөөллийн талаар бүрэн ойлголттой байх ёстой. (iii) Олон талын үр дүнгийн тооцооны системд харилцан суутгах үйлчилгээг гүйцэтгэгч болон оролцогчийн тус бүрийн хариуцлагыг тодорхойлон үзүүлдэг зээлийн эрсдэл болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг удирдахад зориулагдсан журмыг сайн тодорхойлсон байх ёстой. Эдгээр журам нь бүх оролцогчийн хувьд өөрсдийн хариуцах эрсдэл бүрийг хязгаарлах, удирдах хөшүүрэг болон ур чадварын аль алиныг эзэмшснийг, түүнчлэн хязгаарлалт нь оролцогч бүрийн бий болгож болзошгүй зээлийн алдагдлын дээд хэмжээгээр тогтсныг баталгаажуулах ёстой. (iv) Олон талын үр дүнгийн тооцооны систем нь ядаж л их хэмжээтэй ганц цэвэр дебит үлдэгдэл (позици)-тэй оролцогчийн төлбөр тооцоог гүйцэтгэх боломжгүй болох үед өдрийн төлбөр тооцоог тодорхой цагт гүйцэтгэхийг баталж чадах ёстой. (v) Олон талын үр дүнгийн тооцооны систем нь ороход нээлттэй, шударга хандалтыг зөвшөөрсөн, нийтэд ил тод шалгуур болон зорилготой байх ёстой. (vi) Бүх үр дүнгийн тооцооны схем нь техникийн системийн үйл ажиллагааны найдвартай байдал болон нөөц төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж өдөр тутмын боловсруулалтын шаардлагыг гүйцэтгэх чадвартай байх ёстой.

**Blue Book**

**мөнгөний агрегат  
(monetary aggregate)**

үүний тодорхойлолтоос нь хамааран хөрвөх чадвартай активуудын янз бүрийн хүрээг өөртөө агуулсан мөнгөний нийлүүлэлтийг хэмжихэд (болон зарим тохиолдолд мөнгөний бодлогын завсрын зорилгоор эсвэл мөнгө зээлийн хүрээний нөхцөл байдлын индикатор болохын хувьд) ашигладаг мөнгөний бодлогын нийлмэл хувьсагч. Мөнгөний агрегат явцуугаас өргөн хүрээ хүртэл хувирдаг. Явцуу тодорхойлогддог M1 агрегатад мөнгөн хөрөнгө болон хугацаагүй хадгаламж ордог.

**EM-CPSS**

**мөнгө угаах  
(money laundering)**

гэмт хэргийн шинж чанартай ажиллагааны орлогын эзэмшил буюу эх үүсвэрийг нуух, нуун далдлах, түүнчлэн хуулийн дагуу олж авсан хөрөнгөөс ялгагдах боломжгүй байдлаар хууль ёсны санхүүгийн системд тэдгээрийг нийлүүлэх оролдлого. Ерөнхийдөө энэ нь бэлэн мөнгөөр олсон орлогыг бэлэн бус хэлбэртэй болгон хувиргахад хамаардаг.

**EM-CPSS  
EM-ECB**

**мөнгөний хүсэлт  
(money order)**

төлбөр хүлээн авагчид мөнгө гуйвуулахад ашигладаг хэрэгсэл. Ихэвчлэн санхүүгийн байгууллагад чекийн данс байхгүй хүмүүсийн хувьд өөр бусад хувь хүн болон компанид мөнгө шилжүүлэхэд ашиглагддаг. Мөнгөний хүсэлтэнд гурван хэсэг байдаг: гуйвуулагч (төлбөр төлөгч), төлбөр хүлээн авагч, нэхэмжлэгч. Нэхэмжлэгч нь санхүүгийн байгууллага эсвэл шуудангийн алба байдаг. Төлбөр хүлээн авагч нь өөрийн мөнгөний хүсэлтээр бэлэн мөнгө хүлээн авах эсвэл тэдгээрийг өөрийн банкинд инкассаар өгдөг.

**Red Book  
Blue Book  
Retail**

**олон үүрэгтэй карт  
(multifunctional cards)**

мөнгөн хөрөнгийг өөртөө хадгалах үүргээс гадна дебит эсвэл кредит функцтэй карт зэрэг бусад төлбөрийн хэрэгсэл болон/эсвэл төлбөрийн бус хэрэгслийг хамааруулж болох карт.

**EM-ECB**

**олон талын зээлийн  
хязгаар  
(multilateral credit limit)**

зээлийн хязгаар-г харна уу.

**Core  
Principles**

<p><b>олон талын үр дүнгийн тооцооны үлдэгдэл (multilateral net settlement position)</b></p>	<p>цагийн тодорхой үед үр дүнгийн төлбөр тооцооны системд оролцогчийн нийт хүлээн авсан төлбөрийн дүн болон тухайн оролцогчоос системийн нийт бусад оролцогч нарт илгээсэн төлбөрийн дүнгийн ялгавар. Хэрэв ялгавар нь эерэг бол оролцогч нь олон талын үр дүнгийн тооцооны кредит үлдэгдэлтэй гэх ба сөрөг тохиолдолд оролцогч нь олон талын үр дүнгийн тооцооны дебит үлдэгдэлтэй гэнэ.</p>	<p><b>Red Book Blue Book</b></p>
<p><b>олон талын үр дүнгийн төлбөр тооцооны систем (multilateral net settlement system)</b></p>	<p>өөрийн дансны, харилцагчдынхаа эсвэл төлбөр тооцоо хийдэггүй оролцогчийн өмнөөс хийсэн болон хүлээн авсан төлбөрийн олон талын үр дүнгийн тооцооны үлдэгдлээр системийн оролцогч бүр нь төлбөр тооцоо хийдэг (нэг л төлбөр эсвэл хүлээн авалтаар) төлбөр тооцооны систем. БХХШС-ийн шууд оролцогч, олон талын үр дүнгийн төлбөр тооцооны үлдэгдэл, олон талын үр дүнгийн тооцоолол-г харна уу.</p>	<p><b>Red Book Blue Book</b></p>
<p><b>олон талын үр дүнгийн тооцоолол (multilateral netting)</b></p>	<p>гурав буюу түүнээс дээш талуудын хоорондох тэдгээрийн хүлээх үүргийн үр дүнгийн талаарх зохицуулалт. Хүлээх үүрэг гэдэгт санхүүгийн хэлцлүүд, гүйлгээнүүд эсвэл хоёулангаас нь үүсэх зохицуулалт хамаарна. Төлбөрийн үүргийн олон талын үр дүнгийн тооцоолол нь олон талын үр дүнгийн төлбөр тооцооны хүрээнд үүсдэг. Хоёр талын үр дүнгийн тооцоолол, олон талын үр дүнгийн төлбөр тооцооны үлдэгдэл, олон талын үр дүнгийн төлбөр тооцооны систем-г харна уу.</p>	<p><b>Red Book Blue Book</b></p>
<p><b>олон талын үр дүнгийн тооцоолол (multilateral netting)</b></p>	<p>олон тал дээр суурилсан үр дүнгийн тооцоолол нь оролцогч бүрийн олон талын үр дүнгийн позиц дээр бусад талуудтай хийгдэж буй хоёр талын үр дүнгийн позицийг нэмэх арифметикийн үйлдлээр хийгддэг. Иймэрхүү үр дүнгийн тооцоолол нь хуулийн хүрээнд худалдан авагч талыг худалдагч тал бүрт, худалдагч талыг худалдан авагч тал бүрт орлодог клирингийн төв зэрэг зуучлагч байгууллагаар хийгддэг. Олон талын үр дүнгийн позици нь оролцогч бүрийн зуучлагч байгууллагатай хийх хоёр талын үр дүнгийн позицийг төлөөлдөг. Үр дүнгийн тооцооллыг харна уу.</p>	<p><b>OTS</b></p>
<p><b>олон гаргагчийн схем (multiple issuer scheme)</b></p>	<p>нэгээс дээш байгууллага гаргагч нь болж буй схем.</p>	<p><b>EM-ESB</b></p>

<b>олон талт үүрэгтэй урьдчилсан төлбөрт карт (multipurpose prepaid card)</b>	өргөн хүрээг хамрах зорилготойгоор зарим үйлчилгээ үзүүлэгчийн худалдааны цэгүүд дээр ашиглах боломж бүхий, үндэсний эсвэл олон улсын хэмжээнд хэрэглэх бололцоотой ч заримдаа тодорхой бүс нутагт хязгаарлагдаж болох, урьдчилсан төлбөрт карт. Цахим хэтэвч, урьдчилсан төлбөрт карт-г харна уу.	<b>Blue Book</b> <i>EM-ECB</i>
<b>олон талт үүрэгтэй урьдчилсан төлбөрт картын схем (multipurpose prepaid card scheme)</b>	хамгийн наад зах нь карт гаргагч, карт эзэмшигч, картыг хүлээн авагч гэсэн гурван талыг хамрах схем. (нэг хүлээн авагч байгаа тохиолдолд энэ схем нь хуулийн дагуу өөр бусад хүлээн авагчийг схемд нэгдэн орох боломжоор хангасан байх ёстой.)	<b>EM-ECB</b>
<b>харилцан тэнцвэржүүлэх систем (mutual offset system)</b>	нэг биржийн клирингийн төвийн позицийг өөр биржийн клирингийн төв рүү шилжүүлж болох, клирингийн төвүүдийн хоорондын холбоос. Мөн позицийг шилжүүлэхгүй байж болно.	<b>ETDC</b>
<b>цэвэр кредит (буюу дебит) үлдэгдэл (net credit (or debit) position)</b>	үр дүнгийн систем дэх оролцогчийн үр дүнгийн тооцооны кредит болон дебит үлдэгдэл гэдэг нь тухайн цаг хугацаанд оролцогчийн хүлээн авсан бүх төлбөрийн нийлбэрээс оролцогчийн шилжүүлсэн бүх төлбөрийн нийлбэрийг хассан ялгавар. Хэрэв ялгавар нь эерэг бол, оролцогч үр дүнгийн тооцооны кредит үлдэгдэлтэй; хэрэв сөрөг бол, оролцогч нь үр дүнгийн тооцооны дебит үлдэгдэлтэй гэнэ. Үр дүнгийн тооцооны кредит болон дебит үлдэгдэл нь үр дүнгийн төлбөр тооцооны үлдэгдэл гэж нэрлэгддэг. Эдгээр үр дүнгийн тооцооны үлдэгдлүүдийг хоёр болон олон талын үндсэн дээр тооцоолж болдог	<b>DVP</b> Red Book Blue Book SDF
<b>цэвэр дебит хязгаар (net debit cap)</b>	хязгаар, цэвэр кредит (дебит) үлдэгдэл-г харна уу.	<b>Red Book</b> Blue Book
<b>цэвэр маржин (net margining)</b>	харилцагчийнхаа цэвэр позицийг хангаж байхын тулд клирингийн төвд хангалттай анхны маржинтай депозит байршуулахыг клирингийн гишүүнээс шаарддаг маржингийн систем.	<b>ETDC</b>
<b>үр дүнгийн төлбөр тооцоо (net settlement)</b>	оролцогч талуудын хоорондын олон тооны шилжүүлэг буюу үүргүүдийн үр дүнгийн тооцоон дээр суурилсан төлбөр тооцоо. Үр дүнгийн тооцоолол-г харна уу.	<b>DVP</b> Red Book Blue Book SDF

<b>үр дүнгийн төлбөр тооцооны систем (net settlement system)</b>	шилжүүлгийн даалгавруудын төлбөр тооцоог үр дүнгийн тооцооны үндсэн дээр хийдэг систем. Зарим системийн хувьд шилжүүлгийн даалгаврын төрлөөс хамааран хооронд нь ялгадаг ба зарим нь (тухайлбал, төлбөрийн даалгавар) төлбөр тооцоог үр дүнгийн тооцооны үндсэн дээр хийж байхад бусад нь (тухайлбал, үнэт цаасны шилжүүлгийн даалгавар) даалгавар нэг бүрчлэн хийгддэг.	<b>x-border DVP</b>
<b>үр дүнгийн төлбөр тооцооны систем (net settlement system)</b>	төлбөр тооцооны үйл ажиллагаа нь хоёр талын эсвэл олон талын үр дүнгийн тооцооны үндсэн дээр хийгддэг, хөрөнгийн шилжүүлгийн систем.	<b>Blue Book Red Book</b>
<b>үр дүнгийн төлбөр тооцооны систем (net settlement system)</b>	шилжүүлгийн даалгавруудын эцсийн төлбөр тооцоог ажлын өдрийн туршид нэг болон түүнээс олон урьдчилан товлосон, цагийн тодорхой интервалаар хийдэг төлбөр тооцооны систем.	<b>SSS</b>
<b>үр дүнгийн тооцоолол (netting)</b>	төлбөрийн системийн арилжааны түнш буюу оролцогчийн үүрэг эсвэл позицйн тохирсон тооцоо. Үр дүнгийн тооцоогоор олон тооны нэг бүрчилсэн позици буюу үүргийг цөөн тооны позици буюу үүрэг болгон цөөрүүлдэг. Нэг оролцогч үүргээ гүйцэтгэж чадахгүй болоход хуулийн албадан гүйцэтгэх янз бүрийн түвшин байдгаас үр дүнгийн тооцооны хэд хэдэн хэлбэр байна. Хоёр талын үр дүнгийн тооцоолол, олон талын үр дүнгийн тооцоолол, өрийн шилжүүлэг, позицйн үр дүнгийн тооцоо, орлуулалт-г харна уу.	<b>DVP Red Book Blue Book SDF</b>
<b>үр дүнгийн тооцоолол (netting)</b>	арилжааны үүргүүдийн үр дүнгийн тооцоог (жишээлбэл, үнэт цаасны зуучлагчаар дамжуулсан) оруулаад системийн оролцогч эсвэл арилжааны түншүүдийн хоёр талын үүргүүдийн тохирсон тооцоо болон үнэт цаасны эсвэл хөрөнгийн шилжүүлгийн даалгаврын төлбөр тооцоог үр дүнгийн тооцооны үндсэн дээр хийх тухай гэрээ.	<b>SSS</b>
<b>өрийн шилжүүлгийн үр дүнгийн тооцоо (netting by novation)</b>	оролцогчийн баталгаа гаргахад төлөгдсөн байхаар шинэ үүргийг гэрээний хэсэг байдлаар оруулах нэг бүрчилсэн форвард үнийн гэрээний биелэлтийг хангаж байгаа, өрийн шилжүүлгийн гэрээгээр хийгддэг үр дүнгийн тооцоолол. Гэрээгээр төлөгдөх дүн нь ирээдүйн үнэ цэнийн өдөр валют бүрээр талуудын хоорондох одоогийн баланс дээр нэмэгдэж тооцогддог	<b>Blue Book</b>

<b>сүлжээний мөнгө (network money)</b>	интернет гэх мэтийн зайнаас хандах харилцаа холбооны сүлжээгээр шилжүүлэгдэж байгаа цахим мөнгө.	<b>EM-ECB</b>
<b>итгэмжлэгдсэн этгээд (nominee)</b>	жинхэнэ эзэмшигчийн өмнөөс үйл ажиллагаа явуулахаар томилогдсон хувь хүн эсвэл байгууллага. Итгэмжлэгдсэн этгээд гэдгийг гол төлөв үнэт цаасны хууль ёсны эзэмшил болон бүртгэлийг батлах үүднээс үнэт цаасны арилжаанд хэрэглэдэг.	<b>DVP</b> <i>Red Book</i> <i>Blue Book</i> <b>SDF</b>
<b>банк бус санхүүгийн байгууллага (non-bank financial institution)</b>	"банк" гэсэн тодорхойлолтод ордоггүй санхүүгийн байгууллага (тухайлбал, Европод зээлийн байгууллагаас, АНУ-д хадгаламжийн байгууллагууд бусад санхүүгийн байгууллага).	<b>EM-CPSS</b>
<b>бэлэн бус мөнгөний клиринг (non-cash clearing)</b>	позицийг нь үе үе зах зээлийн үнээр дахин үнэлж, үр дүнд нь үүргүүдийг барьцаатай болгодог, фьючерс арилжааны клирингэд зориулагдсан арга. Бэлэн мөнгөний клиринг-г харна уу.	<b>ETDC</b>
<b>цуцлахгүй байх боломж (non-repudiability)</b>	төлбөрийн мэдээг илгээгч эсвэл хүлээн авагчийн зүгээс хүчингүй болгох буюу цуцлахаас сэргийлэх чадвар.	<b>Core Principles</b>
<b>цахим мөнгөний "дэвсгэргийн" систем (note-based system)</b>	сериал тоогоор нэг утгатайгаар тодорхойлогдсон үл өөрчлөгдөх, тогтмол нэрлэсэн үнэтэй холбоотой бичлэг (цахим тэмдэглэл)-ээр цахим мөнгөн хөрөнгийг төлөөлүүлдэг цахим мөнгөний систем	<b>EM-Sec</b>
<b>гэрээгээр хүлээсэн өмнөх үүргээ шинэ үүргээр солих (novation)</b>	гэрээгээр хүлээсэн одоо байгаа үүргийг шинэ үүрэг (жишээлбэл, нэг бүрчлэнгийн үүргийг үр дүнгийн тооцооллын төлбөрийн үүргээр орлуулсны дүнд үүсэх)-ээр орлуулах замаар гүйцэтгүүлэх болон хангуулах. Шинээр үүрэг гүйцэтгэх талууд хуучинтайгаа ижил байж болох ба зарим клирингийн төвийн зохицуулалтаар талуудын орлогчийг нэмж болдог. Орлуулалт-г харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>хүлээх үүрэг (obligation)</b>	гэрээ эсвэл хуулийн дагуу хүлээсэн үүрэг. Энэ нь бонд, энгийн вексель зэрэг гаргагч нь эзэмшигчид төлбөр төлөх үүрэг бүхий үнэт цаас болон санхүүгийн бусад хэрэгслийг тодорхойлоход ашиглагддаг.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b> <i>Retail</i>
<b>OAT (OCR)</b>	оптик аргаар таних-г харна уу.	

<b>тэнцлийн гадуурх гүйлгээ (off-balance sheet transactions)</b>	гүйцэтгэсэн санхүүгийн байгууллагынхаа балансад тусгагддаггүй санхүүгийн гүйлгээнүүд. Жишээ нь фьючерс зах зээл дээрх санхүүгийн хөрөнгийг худалдах эсвэл худалдан авах үйл ажиллагаа үүнд хамаарч болно.	<b>EM-CPSS</b>
<b>офлайн (offline)</b>	төлбөрийн болон төлбөр тооцооны системд энэ нэр томъёо нь дуу хоолойгоор, бичгээр эсвэл факсаар явуулах зэрэг сүүлд нь гүйлгээ боловсруулах системд оруулах ёстой арга хэрэгслээр дамжуулан хийж байгаа хэрэглэгчийн шилжүүлгийн даалгаврыг дамжуулах үйл ажиллагаанд хамаардаг. Түүнээс гадна энэ нэр томъёо нь хэрэглэгч өгөгдлийн мэдээлэлд шууд хандах боломжгүй соронзон тууз эсвэл диск зэрэг зөөврийн хэрэгсэл дээр гүйлгээ боловсруулах системийн мэдээллийг хадгалах ажиллагаанд хамаарч болох юм.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>тооцоолол (offsetting)</b>	үр дүнгийн тооцоолол-г харна уу.	<b>Core Principles</b>
<b>олон этгээдийн данс (omnibus account)</b>	олон тооны түншүүдийн нэгдмэл мөнгөн хөрөнгө болон позицид зориулагдсан цорын ганц данс. Клирингийн гишүүн нь клирингийн гишүүдийн харилцагчдад зориулж клирингийн төвд олон этгээдийн дансыг нээж болдог. Энэ тохиолдолд, клирингийн гишүүн нь байршуулсан харилцагч бүрийн дансанд бичилт хийх үүрэг хүлээнэ.	<b>ETDC</b>
<b>олон тооны харилцагчийн данс (omnibus customer account)</b>	өөрийн бүх (эсвэл хамгийн багадаа хэд хэдэн) харилцагчийг төлөөлөн үнэт цаасыг хадгалж байгаа оролцогчийн эзэмшиж буй данс. өмчийн данс, тусгаарлалт-г харна уу.	<b>SDF</b>
<b>нэг чигийн хаш-функц (one-way hash function)</b>	дамжиж буй өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг нягтлах зорилгоор мэдээнд хавсаргагдах кодыг үүсгэх математикийн алгоритм. Хаш функцээр үүсгэгдэх кодын утгыг хаш утга гэж нэрлэдэг.	<b>EM-Sec</b>
<b>дамжуулан зээлдүүлэх (onlend)</b>	нэг этгээдээс ямар нэгэн үнэт цаас зээлэн авч тэрхүү үнэт цаасаа өөр нэг этгээдэд зээлдүүлэх үйлдэл.	<b>SLT</b>
<b>онлайн (online)</b>	цахим мөнгөний системд энэ нь гүйлгээг гүйцэтгэхээс өмнө баталгаажуулан зөвшөөрөл олгохын тулд төвлөрсөн компьютерын системд шууд холбогдох боломжийг илэрхийлдэг.	<b>EM-Sec</b>



<b>онлайн (online)</b>	<p>төлбөр тооцооны системийн хувьд, энэ нэр томьёо нь шилжүүлэг боловсруулах системд автоматаар оруулдаг компьютер хоорондын интерфейс болон цахим терминал зэрэг цахим хэрэгслүүдийн тусламжтайгаар харилцагчдын шилжүүлгийн даалгаврыг дамжуулахад ажиллагаанд хамаарч болно. Түүнчлэн энэ нэр томьёо нь терминал гэх мэт оруулах/гаргах төхөөрөмж ашиглан хэрэглэгч нь тухайн өгөгдөлд шууд (бодит цагаар давтамжтайгаар) хандах боломжтойгоор компьютерын өгөгдлийн сангийн гүйлгээ боловсруулах системийн өгөгдлийг хадгалах ажиллагаанд мөн хамаарч болно.</p>	<p><b>Red Book</b> Blue Book EM-CPSS EM-ECB <i>Retail</i></p>
<b>нээлтийн алхам (opening (or front) leg)</b>	<p>тухайн нэг үнэт цаасны гүйлгээний хослолын эхний алхам. Өөрөөр хэлбэл, үнэт цаас зээлдүүлэх гүйлгээ. Эхнийх нь хэлцлийн өдрийн ойролцоо хийгдэж байхад нөгөө нь ирээдүйд хийгдэх хэлцлийн өдрийнхөөр хийгдэнэ.</p>	<p><b>SLT</b></p>
<b>нээлттэй зах зээлийн арилжаа (open market sales)</b>	<p>банкуудын нөөц (төлбөр түргэн гүйцэтгэх чадварт шаардагдах хөрөнгө)-ийн хэмжээг бууруулах зорилгоор төв банкнаас санхүүгийн хоёрдогч зах зээл дээр гаргаж байгаа зах зээлд борлогдохуйц үнэт цаасны арилжаа.</p>	<p><b>EM-CPSS</b></p>
<b>нээлттэй сүлжээ (open network)</b>	<p>хандалтуудад хязгаарлалт тавигдаагүй харилцаа холбооны сүлжээ.</p>	<p><b>EM-Sec</b> EM-ECB <i>Retail</i></p>
<b>нээлттэй саналын үр дүнгийн тооцоолол (open offer netting)</b>	<p>бие даасан хоёр байгууллага хүлээн зөвшөөрсөн нөхцөлд хэлцлийн оролцогч тал болж байгаа клирингийн төв гэх мэт гуравдагч этгээдийг оролцох тухай гэрээний аргыг тодорхойлдог. Хэрэв талууд гуравдагч этгээдийг автоматаар нэн даруй тухайн гүйлгээнд оролцох тухай урьдчилан тохиролцсон нөхцөлийг хангах гүйлгээний нөхцөлийг харилцан зөвшөөрсөн үед “нээлттэй санал”-ыг эдгээр байгууллагуудад гуравдагч этгээд нь гаргаж өгдөг. Тус тусдаа, ижил бөгөөд харилцан эсрэг үүрэг нь клирингийн төв болон нэг талын оролцогч ба клирингийн төв болон нөгөө талын оролцогч талуудын хооронд үүсдэг. Хэрэв урьдчилан зөвшөөрсөн бүх нөхцөл биелэгдвэл, тухайн хоёр байгууллагын хоорондын гэрээний шууд үүрэгт ямар нэгэн шат дамжлага үүсэхгүй.</p>	<p><b>x-border</b> Blue Book</p>

<b>нээлттэй, үнэ хаялцах арилжаа (open outcry trading)</b>	ямар нэгэн цахим зуучлалгүйгээр биржийн арилжааны танхимд явагдаж буй арилжаа. Дэлгэцэнд суурилсан арилжаа-г харна уу.	<b>ETDC</b>
<b>нээлттэй хэлцэл (open transactions)</b>	төлбөр хийгдэх тогтоосон хатуу хугацаагүй, хэлцлийг дуусгавар болгох эсвэл түүний нөхцөлд засвар оруулах буюу өдөр тутам барьцааг солих боломжтой хэлцэл.	<b>SLT</b>
<b>үйлдлийн систем (operating system)</b>	компьютерын систем (чипүүдийг оролцуулан)-ийн үндсэн оруулах/гаргах үйлдлүүд, тооцоолол, санах ойн удирдлага зэрэг үйл ажиллагааг гүйцэтгэж, ажиллуулж байдаг техник хангамжтай нягт холбогдсон програм хангамжийн хэсэг.	<b>EM-Sec</b>
<b>үйл ажиллагааны эрсдэл (operational risk)</b>	мэдээллийн систем эсвэл дотоод хяналтын хангалтгүй байдлаас урьдчилан таамаглагдаагүй алдагдалд хүргэх эрсдэл.	<b>Red Book</b>
<b>үйл ажиллагааны эрсдэл (operational risk)</b>	төлбөр тооцоонд чухал нөлөө бүхий техник хангамж, програм хангамж буюу мэдээлэл, харилцаа холбооны системүүдийн зарим бүрэлдэхүүн хэсгийн гэмтэл эсвэл хүний үйл ажиллагааны алдаанаас үүдэн гарах эрсдэл.	<b>ETDC SLT</b>
<b>найдвартай кастодийн үйл ажиллагааны данс (operational safe custody accounts)</b>	Зээлийн байгууллага нь төв банкны үйл ажиллагааны баталгааг хангахуйц үнэт цаасыг байршуулснаар төв банкны хөтөлж буй үнэт цаасны данс. Дээрх дансанд байршуулсан үнэт цааснууд нь төв банкны нэрээр төвлөрсөн хадгаламжийн төв дээр эцсийн байдлаар хадгалагддаг. Иймд найдвартай кастоди дансанд хийгдэх шилжүүлэг нь банк болон төв банкны төвлөрсөн хадгаламжийн төв дээрх дансны хоорондын шилжүүлгээр хийгддэг. Төв банкны нэр дээрх үнэт цааснууд нь ерөнхийдөө Төв банкны овернайт (хүү бүхий) болон өдрийн зээл (хүүгүй)-ийн барьцаа байдлаар хадгалагддаг. Эдгээрийг мөн үнэт цаасыг эргүүлэн авах тухай төв банкны баталгаатайгаар нээлттэй захын гүйлгээнд (репо)-д ашигладаг.	<b>x-border Blue Book</b>
<b>тэмдэгтийг оптик аргаар таних (optical character recognition)</b>	цахим боловсруулалт хийгдсэн баримтуудыг (жишээ нь, чек, кредит шилжүүлэг, шууд дебит) ОАТ төхөөрөмжийн тусламжтайгаар уншиж таних аргачлал. Соронзон тэмдэгтийг таних-г харна уу.	<b>Red Book x-border Blue Book</b>

<b>оновчтой байдлын хэвшсэн журам (optimisation routine)</b>	төлбөр тооцоонд хүлээн авч байгаа төлбөрүүдийн дарааллыг тодорхойлоход зориулагдсан, төлбөрийн систем дэх хэвшсэн дэг журмын процесс.	<b>Core Principles</b>
<b>опшин хэлцэл (option contract)</b>	тодорхой өдөр, тогтоосон үнээр холбогдох хөрөнгийг худалдах буюу худалдан авах эрхийг худалдан авагчид олгодог боловч үүрэг хүлээхгүй байх хэлцэл. Энэ эрхийн төлөө худалдан авагч урамшуулал (premium) төлдөг.	<b>OTC</b> <b>ETDC</b>
<b>опшин-хэлбэрийн хязгаарлалт (options-style margining)</b>	позицийг зах зээлийн үнээр дахин үнэлж байгаа болон одоогийн дүн нь барьцаатай байгаа үед деривативын гэрээг хязгаарлах арга. Опшины гэрээ нь иймэрхүү системээр хязгаарлагдсан үед опшины худалдан авагч нь худалдан авах үедээ урамшууллыг бүрэн төлдөг. Опшины худалдагч нь урамшуулал болон одоогийн дүнгийн барьцааг хүлээн авдаг. Фьючерс-хэлбэрийн хязгаарлалт-г харна уу.	<b>ETDC</b>
<b>мөнгөгүй опшин (out-of-the-money)</b>	энэ нэр томъёог хэрвээ хэлцэл яг одоо биелэгдвэл эзэмшигчийн хувьд хасах мөнгөний урсгалыг бий болгох опшин хэлцлийг тодорхойлоход хэрэглэдэг.	<b>OTC</b>
<b>овернайт зээл (overnight money)</b>	ажлын нэг өдрийн хугацаанд төлөгдөх зээл. Үүнийг өөрөөр өдөр тутмын (day-to-day) зээл гэж нэрлэдэг.	<b>Red Book</b> <b>x-border</b> <b>Blue Book</b>
<b>хяналт (oversight)</b>	төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны системийн найдвартай болон үр ашигтай байдлыг дэмжих, ялангуяа системийн эрсдэлийг бууруулахад голчлон чиглэсэн төрийн бодлогын үйл ажиллагаа.	<b>SSS</b>
<b>төлбөрийн системийн хяналт (oversight of payment systems)</b>	төлбөрийн системийн тасралтгүй ажиллагааг хангах, төлбөрийн системийн нэг буюу түүнээс олон оролцогчид зээлийн эсвэл төлбөр түргэн гүйцэтгэх чадварын асуудал тулгарахад тохиолдож болзошгүй "домино нөлөө"-өөс санхүүгийн системийг хамгаалахад чиглэгдсэн төв банкны үүрэг. Төлбөрийн системийн хяналт нь оролцогч бүрээс илүүтэй тухайн системд чиглэдэг.	<b>x-border</b> <b>Blue Book</b>
<b>биржээс гадуурх зах зээл (over the counter)</b>	биржийн оролцоогүй арилжааны арга. Биржээс гадуурх зах зээл дээр оролцогчид ихэвчлэн телефон эсвэл интернэтийн шугам ашиглан арилжааг хоорондоо шууд хийдэг.	<b>ETDC</b> <b>OTC</b> <b>SLT</b>

<b>цаасан бус кредит шилжүүлэг (paperless credit transfers)</b>	банк хоорондын цаасан баримт солилцдоггүй кредит шилжүүлгүүд. Бусад кредит шилжүүлэг нь цаасан баримттай хамаатай байдаг.	<b>Red Book</b> x-border Blue Book Retail
<b>оролцогч/гишүүн (participant/member)</b>	шилжүүлгийн системд оролцогч тал. Энэ ерөнхий нэр томъёо нь шилжүүлгийн системд (жишээ нь, банкны таних дугаараар) танигдаж, төлбөрийн даалгаврыг систем руу шууд дамжуулах эрхтэй буюу шилжүүлгийн системийн зохицуулалтын дүрэмд захирагддаг байгууллагад хамаарна. шууд оролцогч/гишүүн, шууд бус оролцогч/гишүүн-г мөн харна уу.	<b>Red Book</b> x-border Blue Book SDF
<b>төлбөрийг дамжуулагч агент (paying agent)</b>	үнэт цаас гаргагчийг төлөөлөн үнэт цаасны эзэмшигчид төлбөр (үндсэн болон хүүгийн төлбөр) төлж байгаа байгууллага.	<b>SDF</b>
<b>төлбөр (payment)</b>	төлбөр хүлээн авагч тал хүлээн зөвшөөрснөөр төлөгчөөс хийх мөнгөний нэхэмжлэлийн шилжүүлэг. Мөнгөний нэхэмжлэл нь ихэвчлэн санхүүгийн байгууллага буюу төв банкинд байршуулсан татан төвлөрүүлсэн хөрөнгө эсвэл мөнгөн тэмдэгт хэлбэрээр байж болно.	<b>Red Book</b> Blue Book EM-CPSS EM-ECB
<b>төлбөрийн картын компани (payment card company)</b>	төлбөрийн картан (кредит, дебит буюу урьдчилсан төлбөрт карт) худалдааны тэмдэг эзэмшиж, карт гаргагч байгууллагадаа маркетингийн, боловсруулалтын зэрэг бусад үйлчилгээ үзүүлдэг компани.	<b>EM-ECB</b>
<b>төлбөрийн хэрэгсэл (payment instrument)</b>	эзэмшигч болон хэрэглэгчид хөрөнгийн шилжүүлэг хийх боломж олгож буй хэрэгсэл.	<b>EM-ECB</b>
<b>төлбөрийн мөчлөг (payment lag)</b>	төлбөрийн даалгаврыг эхлүүлснээс эхлэн эцсийн төлбөр тооцоо хийгдэх үе хоорондын цагийн завсар.	<b>Red Book</b> x-border Blue Book
<b>төлбөрийн мэдээ/даалгавар (payment message/instruction)</b>	төлбөр хүлээн авагчид (аль нэг талын мөнгөний нэхэмжлэлийн хэлбэрээр) хөрөнгө шилжүүлэх хүсэлт эсвэл мэдээ. Төлбөрийн хүсэлт нь кредит эсвэл дебит шилжүүлэгтэй холбогдож болно. Кредит шилжүүлэг, дебит шилжүүлгийн систем, төлбөр-г харна уу.	<b>Core Principles</b>
<b>төлбөрийн үр дүнгийн тооцоо (payment netting)</b>	үр дүнгийн тооцоонд тулгуурлан ижил мөнгөний нэгжээр, нэг өдөрт төлбөр тооцоог хийх.	<b>OTC</b>

<b>төлбөрийн даалгавар (payment order)</b>	төлбөр хүлээн авагчид мөнгөн хөрөнгө (аль нэг талын мөнгөний нэхэмжлэлийн хэлбэрээр) шилжүүлэхийг хүссэн мэдээ буюу даалгавар. Даалгавар нь кредит эсвэл дебит шилжүүлэгтэй холбоотой байж болно. Үүнийг мөн төлбөрийн хүсэлт гэж нэрлэдэг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>Retail</b>
<b>төлбөрийн систем (payment system)</b>	төлбөрийн систем гэдэг нь гүйлгээнд байгаа мөнгөний эргэлтийг баталгаажуулж буй банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем, төлбөрийн хэрэгсэл, банкны дүрэм журмын иж бүрэн цогцыг агуулдаг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-CPSS</b> <b>EM-ECB</b> <b>Retail</b>
<b>төлбөрийн эсрэг төлбөр (payment versus payment)</b>	зөвхөн бусад гадаад валютын буюу валютуудын эцсийн шилжүүлэг хийгдсэн тохиолдолд л нөгөө валютын эцсийн шилжүүлэг хийгдэхийг баталгаажуулдаг валют арилжааны төлбөр тооцооны систем дэх зохицуулалт.	<b>Blue Book</b>
<b>ПСМСИА карт (PCMCIA card)</b>	персонал компьютерын медиа контрол интерфэйс адаптер: Санах ойн агуулах болон модемийн харилцаа холбоонд зэрэг төрөл бүрийн функцыг гүйцэтгэж чадах, компьютерт холбогдох төхөөрөмж. ПСМСИА картууд нь хөндлөнгийн оролцоог эсэргүүцэх тодорхой түвшинг хангах боломжтойгоор хийгддэг.	<b>EM-Sec</b>
<b>хувийн ялгах дугаар (personal identification number)</b>	жинхэнэ гэдгээ нотлохын тулд карт эзэмшигчийн оруулах шаардлагатай тоон код. Цахим гүйлгээний хувьд энэ нь гарын үсэг болдог.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>Retail</b>
<b>ялгалт (personalisation)</b>	картанд харилцагчийн мэдээллийг татан оруулж (ачаалж) байгаа IC картын боловсруулалтын үе шат.	<b>EM-Sec</b>
<b>ПИН (PIN)</b>	хувийн ялгах дугаар-г харна уу.	
<b>энгийн текст (мэдээлэл) (plaintext)</b>	инкрипшн хийгдээгүй, уншигдахуйц хэлбэртэй өгөгдөл.	<b>EM-Sec</b>
<b>"плейн ванилла" гүйлгээнүүд (plain vanilla transactions)</b>	дервативын гүйлгээний хамгийн энгийн бөгөөд хамгийн хялбар хэлбэр. "Плейн ванилла" нь харьцангуй ойлголт бөгөөд "плейн ванилла" гүйлгээний тусгайлсан жагсаалт байдаггүй. Ердийн бус, ховор шинж чанартай эдгээр гүйлгээг "хачирхалтай" буюу "зохицуулалтын" гэж нэрлэдэг.	<b>OTS</b>

<b>батламжлал (pledge)</b>	нэг тал (өртэй этгээд/барьцаалуулагч)-аас нөгөө тал (барьцаалагч)-д өр төлбөрийн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилготой хөрөнгийн шилжүүлэг. Хөрөнгийг барьцаа болгон шилжүүлэх үед барьцааг хадгалах эрх (хураагдсан хөрөнгийн эрх) үүснэ. Үнэт цаасны хүү-г мөн харна уу.	<b>OTC</b> <b>SLT</b>
<b>худалдан авалтын цэг (point of sale)</b>	энэ нэр томъёо нь худалдаа, үйлчилгээний цэг (КҮБ)-т төлбөрийн карт хэрэглэхтэй холбогддог. Төлбөрийн мэдээлэл нь цаасан талон эсвэл зарим тохиолдолд мэдээлэл дамжуулахад ашиглагдахаар зориулагдсан цахим терминалаар боловсруулагддаг. Иймээс үүний зохицуулалт нь "худалдаа үйлчилгээний цэг дээрх цахим хөрөнгийн шилжүүлэг" (EFTPOS)-т хамаарч болно.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>Retail</b>
<b>ПОС (POS)</b>	худалдан авалтын цэг-г харна уу.	
<b>позицийн хязгаар (position limit)</b>	нэг байгууллагад байж болох хэлцлийн тоо буюу хэлцлийн нээлттэй позицийн хувь хэмжээний хязгаар.	<b>ETDC</b>
<b>позицийн үр дүнгийн тооцоо (position netting)</b>	өөрсдийн хүлээх үүрэг болон нөхцөлийг тооцохгүйгээр хоёр болон түүнээс дээш тооны оролцогч хоорондын хүлээх үүргийн дагуу төлбөрийн даалгаврыг цэвэршүүлэх. Төлбөрийн цэвэршүүлэлт гэж мөн нэрлэгддэг.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b>
<b>болзошгүй алдагдал (potential future exposure)</b>	гэрээ эсвэл гэрээний бүрдлийн дагуу өнөөгийн орлуулалтын зардлаас гадна гэрээ хүчинтэй хугацааны туршид оролцогч тал нь хүлээж болзошгүй гэж тааварлаж байгаа нэмэлт алдагдал. Өнөөгийн алдагдал -ийг лавлана уу.	<b>OTC</b>
<b>урьдчилсан санхүүжилт (prefunding)</b>	байгууллага өөрсийн төлбөр тооцооны үүргээ гүйцэтгэхийн тулд эдгээр дансан дахь мөнгийг ашиглах хүртэл төлбөр тооцооны байгууллагын дансанд хөрөнгийг бэлэн байлгах шаардлага.	<b>Core Principles</b>
<b>урьдчилан тулгах ажиллагаа (pre-matching process)</b>	бусад тулган шалгах эсвэл харьцуулах дамжлагаас өмнө тохиолдож болох оролцогч талуудын хооронд арилжааны буюу төлбөр тооцооны мэдээлэл биелэгдэх эсэхийг тодорхойлох процесс.	<b>SDF</b>
<b>урьдчилсан төлбөрт карт (prepaid card)</b>	карт эзэмшигчээс карт гаргагчид урьдчилан төлсөн мөнгөн дүнг байршуулсан (хадгалсан) карт. Цахим хэтэвч, хязгаарлагдмал зориулалттай урьдчилсан төлбөрт карт, хуримтлалын карт-г харна уу.	<b>EM-CPSS</b>

<p><b>урьдчилсан төлбөрт картыг төлбөрт хүлээн авагч</b> (prepaid card acceptor)</p>	<p>урьдчилсан төлбөрт картаар төлбөрийг нь авч бараа буюу үйлчилгээ нийлүүлэхийг зөвшөөрсөн этгээд.</p>	<p><b>EM-ECB</b></p>
<p><b>урьдчилсан төлбөрт карт эзэмшигч</b> (prepaid cardholder)</p>	<p>карт дээр бичигдсэнээр урьдчилсан төлбөрт карт эзэмшигчийг таних баримт бүхий харилцагч эсвэл ямар нэгэн данстай холбоогүй, нэр бичигдээгүй картыг эзэмшиж байгаа харилцагч.</p>	<p><b>EM-ECB</b></p>
<p><b>урьдчилсан хийсэн төлбөр тооцооны эрсдэл (орлуулалтын зардлын эрсдэл)</b> (pre-settlement risk (replacement cost risk))</p>	<p>ирээдүйд биелэгдэхээр гүйлгээг урьдчилан хийсэн оролцогч талын тухайн гүйлгээ хийгдэх хугацааны туршид гэрээ эсвэл хэлцлийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болох эрсдэл. Үүсэх алдагдал нь орлуулалтын зардлын эрсдэл гэж нэрлэдэг эх гүйлгээг тухайн цаг үеийн зах зээлийн үнээр хийх зардал болдог. Зээлийн эрсдэл/алдагдал-г харна уу.</p>	<p><b>OTC</b> <b>SSS</b></p>
<p><b>үндсэн брокерын үйлчилгээ</b> (prime brokerage)</p>	<p>зээлийн, клирингийн, үнэт цаасны зээллэгийн болон бусад үйлчилгээ (ихэвчлэн хеджингийн сан)-г харилцагчид үзүүлж буй фирм (жишээ нь, үнэт цаасны томоохон компаниуд)-ийн үйлчилгээний нөхцөл.</p>	<p><b>SLT</b></p>
<p><b>принципал/ үндсэн тал</b> (principal)</p>	<p>өөрийн нэрийн өмнөөс гүйлгээнд оролцож байгаа, хэлцлийн нэг тал. Принципалын үүрэг гүйцэтгэдэг компани ашиг олохын тулд эрсдэлээ өөрөө хүлээж, өөрийн дансан дахь хөрөнгөөрөө худалдан авалт/худалдаа (эсвэл зээл олголт/зээллэг) хийж байдаг. Харилцагчдын үнэт цаасны санал болгож байгаа зээлдэгч байгууллага нь нийтэд мэдээлэлгүйгээр принципалын үүрэг гүйцэтгэж болдог.</p>	<p><b>SLT</b></p>
<p><b>үндсэн дүнгийн алдагдлын эрсдэл</b> (principal risk)</p>	<p>үнэт цаас арилжаалагч нь үнэт цаасаа шилжүүлсэн боловч төлбөрөө хүлээж аваагүй эсвэл үнэт цаас худалдан авагч төлбөрөө хийсэн боловч үнэт цаасаа хүлээн аваагүй үед үүсэх эрсдэл. Энэ тохиолдолд үнэт цаасны эсвэл мөнгөн шилжүүлгийн үндсэн дүн эрсдэлд учирна.</p>	<p><b>DVP</b> <b>SLT</b> <b>x-border</b> <b>ETDC</b> <b>SDF</b></p>

<b>үндсэн дүнгийн алдагдлын эрсдэл (principal risk)</b>	оролцогч тал хэлцэлтэй холбоотой бүх мөнгөө алдаж болох зээлийн эрсдэл. Төлбөр тооцооны процесст энэ нэр томъёо нь ихэвчлэн гүйлгээнд оролцогч талуудын эцсийн төлбөр тооцооны хооронд хоцролт байгаа үед (өөрөөр хэлбэл, төлбөрийн эсрэг нийлүүлэлт үйлчлэхгүй байгаа үед) гүйлгээний дүнгээр солилцох (exchange-for-value)-той холбоотой гарч ирдэг. Үндсэн дүнгийн алдагдлын эрсдэл нь зарим үед кросс-валютын төлбөр тооцооны эрсдэл буюу Херстатын эрсдэл гэгдэх валютын арилжааны гүйлгээний төлбөр тооцооноос үүсч болно. credit risk/exposure-ийг мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>принципал (үндсэн тал)-уудын хоорондын харилцаа (principal-to-principal relationship)</b>	хоёр тал хоёул өөрсдийн нэрийн өмнөөс болон гэрээгээр хүлээсэн аливаа үүргийг гүйцэтгэх хариуцлага хүлээсэн гэрээгээр зохицуулах харилцаа.	<b>ETDC</b>
<b>нууцлал (privacy)</b>	төлбөрийн системийн хувьд энэ нь хувь хүний зөвшөөрөлгүйгээр олж авсан түүнд холбоотой мэдээллийг задруулахгүй байх нөхцөл байдал.	<b>EM-Sec</b> <b>EM-ECB</b>
<b>хөрөнгийн эрх ашиг (property interest)</b>	энэхүү ерөнхий нэр томъёо нь тодорхой хөрөнгийг эзэмших, ашиглах, дамжуулах онцгой эрх эсвэл сонирхолтой хамаатай байдаг.	<b>SLT</b>
<b>өөрийн данс (proprietary account)</b>	оролцогчийн зөвхөн өөрийн нэрийн өмнөөс (харилцагчдынхаа нэрийн өмнөөс байршуулж буй үнэт цаасны данснаас ялгаатай) үнэт цаас байршуулж буй данс. Олон тооны харилцагчийн данс, тусгаарлалт-г харна уу.	<b>SDF</b>
<b>өөрийн позици (proprietary positions)</b>	өөрийн нэрийн өмнөөс (харилцагчид зориулан байршуулсан позициос ялгаатай) байршуулж буй оролцогчийн позици.	<b>ETDC</b>
<b>өөрийн хөрөнгөө ашиглах (арилжаа хийх) (proprietary (trading))</b>	түншийн бус, компанийн өөрийн дансаар хийх үнэт цаасны буюу деривативын арилжаа.	
<b>протокол (protocol)</b>	харилцаа холбооны төхөөрөмжийн хооронд электрон мэдээг харилцан солилцох аргачлал.	<b>EM-Sec</b>
<b>провайдер (provider)</b>	цахим мөнгөний гүйлгээг дамжуулахад зориулагдсан техник болон програм хангамжийг бий болгосон, тухайн цахим мөнгөний нэгжийн гаргагч биш байж болох оператор.	<b>EM-ECB</b>



<b>нөхцөлт шилжүүлэг (provisional transfer)</b>	хууль эсвэл гэрээний дагуу шилжүүлгийг цуцлах эрхийг нэг буюу түүнээс дээш тал эзэмшиж байгаа үед хийгдэх нөхцөлт шилжүүлэг.	<b>DVP</b> Red Book x-border Blue Book SDF
<b>нийтэд мэдээлэх (public disclosure)</b>	мэдээллийг олны өмнө ил тод болгох. Жишээлбэл, интернэтийн вебсайт эсвэл нийтэд чөлөөтэйгээр хуулбарлан тараах.	<b>Core Principles</b>
<b>нээлттэй түлхүүрийн криптограф (public key cryptography)</b>	асимметрик криптограф –г харна уу.	<b>EM-Sec</b>
<b>Тэт (PVP)</b>	төлбөрийн эсрэг төлбөр-г харна уу.	
<b>дараалал хөтлөлт (queuing)</b>	шилжүүлгийн даалгавар илгээгч талд эсвэл систем дээр тухайн илгээгчийн клирингийн дансанд төлбөр тооцоог хийх хангалттай үлдэгдэлтэй болох хүртэл эсвэл төлөгчид тогтоосон хязгаарт зохицуулан илгээсэн шилжүүлгийг нь саатуулан хүлээлтэнд оруулах эрсдэлийн удирдлагын зохицуулалт. Зарим тохиолдолд, төлбөр тооцоог нь хийхийн тулд ашиглагдаагүй зээлийн шугам эсвэл бэлэн барьцааг ашигладаг. Хязгаар-г мөн харна уу.	<b>Red Book</b> Blue Book
<b>Шуурхай Санах Ой (RAM)</b>	шуурхай санах ой: Зөвхөн цахилгаан хүчдэл өгсөн үед л өгөгдлийг хадгалж чадах, тооцоололд ашиглагддаг чипийн хувьсах санах ойн хэсэг	<b>EM-Sec</b>
<b>бодит цаг (real time)</b>	төлбөрийн даалгаврыг хүлээн авсан тухайн цагт нь хойшлуулалгүй, нэг бүрээр нь гүйцэтгэх боловсруулалт.	<b>DVP</b> SDF
<b>бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцоо (real-time gross settlement)</b>	төлбөрийн даалгавар тус бүрийн дагуу нэг бүрчлэн (үр дүнгийн тооцоо хийлгүйгээр) шилжүүлэх хөрөнгө болон үнэт цаасны шилжүүлгийн үл тасалдах (бодит цагийн) төлбөр тооцоо.	<b>ETDC</b> SLT
<b>бодит цагийн эрсдэлийн удирдлага (real-time risk management)</b>	төлбөрийн системийн оролцогч хооронд төлбөрийг шууд, тасралтгүй гүйцэтгэхтэй холбоотойгоор үүсэх эрсдэлийг удирдах үйл явц.	<b>Red Book</b> Blue Book

<b>бодит цагийн дамжуулалт, боловсруулалт буюу төлбөр тооцоо (real-time transmission, processing or settlement)</b>	үүсгэгдсэн тухайн агшинд нэг бүрээр нь хийх хөрөнгийн буюу үнэт цаасны даалгаврын дамжуулалт, боловсруулалт, төлбөр тооцоо.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>хямдруулалт (rebate)</b>	бэлэн мөнгийг барьцаалан үнэт цаас зээлдүүлэгч нь зээлдэгчид төлөх хүүгийн хувь. Үүний хэмжээ нь зээлийн шимтгэлийг харуулах зах зээлийн хүүгийн хэмжээнээс доогуур байдаг.	<b>SLT</b>
<b>буцаан дуудах шаардлага (recall)</b>	үнэт цаас зээлдүүлэгч нь нээлттэй хэлцлээр зээлдүүлсэн үнэт цаасаа зээлдэгчээс буцаан авах хүсэлт.	<b>SLT</b>
<b>хүлээн авагчийн эцэслэлт (receiver finality)</b>	үйл ажиллагаа эсвэл эрх зүйн ойлголтоос илүүтэйгээр судалгаа шинжилгээний ойлголт нь тухайн гүйлгээний өдөрт хүлээн авагч-харилцагчийнхаа дансанд мөнгөн хөрөнгийг бэлэн байхаар эцэслэлт хийх нөхцөлт бус үүрэг шилжүүлгийн системийн төлбөр хүлээн авагч талд нэмэгдэж байгааг тайлбарлахад ашиглагддаг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>бүртгэл (registration)</b>	үнэт цаас гаргагч буюу түүний шилжүүлгийн агент/бүртгэгчийн бүртгэл дэх үнэт цаасны эзэмшигчийн жагсаалт.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>ҮЦТХТ-д зайнаас хандах (remote access to a CSD)</b>	хүлээн авагч орны ҮЦТХТ-д өөрийн нэрийн өмнөөс үнэт цаасны данс нээн ашиглах зорилгоор нэг орны ("дотоодын") үнэт цаасны төлбөр тооцооны системд зориулагдсан байгууллага өөр оронд ("хүлээн авагч") байгуулагдсан ҮЦТХТ-ийн шууд оролцогч болох нөхцөл.	<b>Blue Book</b>
<b>хөрөнгийн шилжүүлгийн системд зайнаас хандах (remote access to an IFTS)</b>	нэг улсад байгуулагдсан зээлийн байгууллага нь өөр улс дахь банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн системийн шууд оролцогч болох механизм ба энэ зорилгын хүрээнд шаардлагатай тохиолдолд оролцогч улсад өөрийн салбар байгуулахгүйгээр тухайн улсынхаа төв банкинд өөрийн нэр дээр төлбөр тооцооны дансыг нээдэг.	<b>Blue Book</b>
<b>зайнаас оролцогч (remote participant)</b>	шилжүүлгийн системийн оршин байгаа улсад төв байгууллага нь ч, аль нэг салбар нь ч байрладаггүй, шилжүүлгийн системд оролцогч.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>зайнаас хийх төлбөр (remote payment)</b>	төлбөрийн даалгавар буюу төлбөрийн хэрэгслээр (жишээ нь, шуудангаар) гүйцэтгэж байгаа төлбөр. Нүүр нүүрээ харан хийх төлбөрийн эсрэг нь.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-ECB</b> <b>Retail</b>

<b>орлуулалтын зардлын эрсдэл (replacement cost risk)</b>	ирээдүйд баталгаажихаар урьдчилан гүйлгээгээ хийсэн талын гүйлгээ нь төлбөр тооцоо хийгдэх өдөртөө хийгдэхгүй болох эрсдэл. Ийм саатал нь төлбөр илгээгч талыг баталгаагүй эсвэл зах зээлийн нээлттэй үлдэгдэлтэй үлдээх эсвэл илгээгч талын үлдэгдлийг бодит бус ашигтай байхаар болгодог. Үүсэх алдагдал нь одоогийн зах зээлийн үнээр эх гүйлгээг орлуулах зардал болдог. Зах зээлийн эрсдэл, үнийн эрсдэл гэж мөн нэрлэгддэг. Зээлийн эрсдэл/алдагдал -г харна уу.	<b>DVP</b> <b>Red Book</b> <b>x-border</b> <b>Blue Book</b> <b>SDF</b> <b>ETDC</b>
<b>репо (repo)</b>	буцаан худалдаж авах тохиролцоо-г харна уу.	
<b>репогийн хувь хэмжээ (repo rate)</b>	хэлцлийн мөнгөн хөрөнгө талын хүүгийн хувь хэмжээгээр илэрхийлэгдэж буй репо хэлцлээс олох ашиг орлого.	<b>SLT</b>
<b>дахин үнэлгээ (repricing/revaluation)</b>	зах зээлийн өртгөөр дахин үнэлэх үйлдэл.	<b>SLT</b>
<b>гүйцэтгэхээс татгалзах (repudiation)</b>	арилжаанд оролцогч нэг тал нь тухайн арилжаанд оролцохоос бүхэлд нь буюу хэсэгчлэн эсвэл мэдээлэл солилцохоос татгалзах байдал.	<b>EM-Sec</b>
<b>буцаан худалдан авах тохиролцоо (repurchase agreement)</b>	заасан хугацаанд, тохиролцсон үнээр үнэт цаасыг хожим буцаан худалдан авах болон худалдах тухай хэлэлцээр. "RP" эсвэл эргүүлэн худалдан авах гэрээ гэж нэрлэдэг.	<b>x-border</b> <b>SLT</b>
<b>нөөцийн депозит (reservable deposits)</b>	нөөцийн шаардлага тавигдсан банкны татан төвлөрүүлсэн хөрөнгө.	<b>EM-CPSS</b>
<b>зайлшгүй байх нөөц (reserve requirement)</b>	өр төлбөрийн тодорхой хэлбэрээр (зарим тохиолдолд касс дахь бэлэн мөнгийг энэ нөөцийн тооцоонд орж тооцоологддог) төв банкин дахь дансандаа хөрөнгө (банкны нөөцийг) байршуулах банкны үүрэг.	<b>EM-CPSS</b>
<b>респондент (respondent)</b>	корреспондент банк-г харна уу.	<b>Red Book</b>
<b>жижиглэнгийн худалдааны карт (retailer card)</b>	тусгайлсан дэлгүүрт ашиглахаар банк бус байгууллагаас гаргасан карт. Ийм карт эзэмшигчид ихэвчлэн зээлийн шугам олгодог.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>бага дүнтэй хөрөнгийн шилжүүлгийн систем (retail funds transfer system)</b>	чек, кредит шилжүүлэг, шууд дебит, АТМ болон ПОС-ын гүйлгээ зэрэг хэлбэртэй, харьцангуй бага дүнтэй их хэмжээний төлбөрүүдийг боловсруулах хөрөнгийн шилжүүлгийн систем.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>EM-CPSS</b> <b>Retail</b>

<b>бага дүнтэй төлбөр (retail payments)</b>	энэхүү нэр томьёо нь их дүнтэй төлбөрийн тодорхойлолтод багтаагүй бүх төлбөрт хамаарна. Бага дүнтэй төлбөр нь ихэвчлэн харилцагчийн харьцангуй бага дүнтэй, яаралтай бус төлбөр байдаг.	<b>Blue Book</b> EM-CPSS EM-ECB
<b>бага дүнтэй гүйлгээ (retail transactions)</b>	бага дүнтэй төлбөр-г харна уу.	<b>EM-CPSS</b>
<b>барьцаа хөрөнгийг дахин ашиглах (дахин барьцаалах) (reuse of collateral (rehypothecation))</b>	барьцаалсан буюу шилжүүлсэн барьцааг нөгөө талдаа шилжүүлэх болон барьцаалах. ”Дахин барьцаалах” гэсэн нэр томьёо нь ерөнхийдөө өмнө барьцааны зүйл болсон барьцаа хөрөнгийг барьцаа болгоход хамаардаг.	<b>OTC</b>
<b>урвуу инженерчлэл (reverse engineering)</b>	програм хангамжийн ажиллагааг тодорхойлох зорилготой эх кодийг шинжлэх процесс.	<b>EM-Sec</b>
<b>урвуу репо (reverse repo)</b>	тодорхой өдөр, тусгайлсан үнээр үнэт цаасыг худалдан авах болон дараа нь буцаан худалдах талаар оролцогч талтай байгуулсан хэлцэл. Энэ нь репо хэлцлийн толин тусгал байдаг.	<b>SLT</b>
<b>буцаагдах гүйлгээ (revocable transfer)</b>	системийн оператор эсвэл системийн оролцогч цуцалж болох шилжүүлэг.	<b>SSS</b>
<b>эрсдэлийн хүчин зүйл (risk factor)</b>	санхүүгийн хэрэгслийн эсвэл бүх багцын үнэд нөлөөлөх хувьсах хэмжигдэхүүн. Хамгийн түгээмэл зах зээлийн эрсдэлийн хүчин зүйлүүд нь хүүгийн хувь, валютын ханш, хувьцааны үнэ, барааны үнэ.	<b>OTC</b>
<b>эрсдэлийн удирдлагын сорил (risk management test)</b>	системийн дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн хэмжээнээс их эрсдэлийг систем болон түүний оролцогч нарт үүсгэж болзошгүй тухайлсан онцлог төлбөрийг боловсруулах зорилгоор төлбөрийн системд төлбөр илгээх байдлаар хийгдэх сорил.	<b>Core Principles</b>
<b>шилжин хийгдэх төлбөр тооцоо (rolling settlement)</b>	үнэт цаасны гүйлгээний төлбөр тооцоо нь өдөр бүр хийгддэг боловч нэг бүрчилсэн гүйлгээний төлбөр тооцоо нь тухайн тохиролцоо хийгдсэнээс хойш тодорхой хэдэн өдрийн дараагаар хийгдэх үеийн нөхцөл байдал. Энэ нь холбогдох төлбөр тооцоо тухайлсан нэг өдөр-жишээлбэл, долоо хоногт эсвэл сард нэг удаа-хийгдэх ба нэг бүрчилсэн гүйлгээний төлбөр тооцоо нь дараагийн өдөр хийгддэг байх үеийн нөхцөл байдлыг ялган зааглахад ашиглагддаг.	<b>SLT</b> <b>SDF</b>

<b>шилжин хийгдэх төлбөр тооцоо (rolling settlement)</b>	арилжааны өдрөөс хойш тодорхой ажлын өдрийн дараагаар төлбөр тооцоо нь хийгдэх арга хэмжээ. Энэ арга хэмжээ нь зөвхөн тухайн заагдсан өдөрт л арилжааны төлбөр тооцоо хийгдэх бүртгэлийн хугацааны арга хэмжээг ялган заагладаг. Жишээлбэл, тухайн долоо хоног эсвэл сарын тодорхой өдөр гэсэн бүртгэлийн хугацаанд хийгдэж байгаа бүх л арилжаанд хамаардаг.	<b>SSS</b>
<b>TCO (ROM)</b>	Тогтмол Санах Ой: үйлдлийн систем болон програмын боломжит хэсгийг хадгалж байгаа чипийн талбар.	<b>EM-Sec</b>
<b>Эр-Эс-Эй (RSA)</b>	Ривест, Шамир, Адельман: тэгш хэмт бус криптографийн алгоритмд өргөнөөр ашиглагддаг.	<b>EM-Sec</b>
<b>Эр-Ти-Жи-Эс RTGS</b>	бодит цагийн нэг бүрчилсэн төлбөр тооцоо-г харна уу.	<b>EM-Sec</b>
<b>Эс-Эй-Эм (SAM)</b>	аюулгүйн модуль: ихэвчлэн терминалд холбогдсон байдаг компьютерын хөндлөнгийн оролцоонд тэсвэртэй бүрэлдэхүүн.	<b>EM-Sec</b>
<b>нэг өдрийн хөрөнгө (same day funds)</b>	хүлээн авагч нь хүлээн авсан тухайн өдөртөө шилжүүлэг хийх буюу данснаас гаргаж авах эрхтэй мөнгөн хөрөнгө.	<b>DVP</b> Red Book x-border Blue Book SDF
<b>тараах (scattering)</b>	IC чипийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тараах, ингэснээр хялбар шинжлэгдэж чадахгүй болох процесс.	<b>EM-Sec</b>
<b>хуваарь гаргах (scheduling)</b>	төлбөр тооцоонд хүлээн зөвшөөрөгдсөн төлбөрийн дарааллыг тодорхойлсноор төлбөрийн дэс дарааллыг удирдах аргачлал. оновчтой байдлын хэвшсэн журам, дараалал хөтлөлт-г харна уу.	<b>Core Principles</b>
<b>дэлгэцэд суурилсан арилжаа (screen-based trading)</b>	цахим терминалын сүлжээгээр дамжуулах арилжаа. Нээлттэй, үнэ хаялцах арилжаа-г харна уу.	<b>ETDC</b>
<b>нууцлалын түлхүүрийн криптограф (secret key cryptography)</b>	тэгш хэмт криптограф-г харна уу.	<b>EM-Sec</b>
<b>баталгаат түнш (secured party)</b>	төлбөр төлөгч талаас нэхэмжлэгдэх барьцаа хөрөнгийг хадгалж байгаа этгээд.	<b>OTC</b>

<b>үнэт цаасыг зээлэх болон зээлдүүлэх хөтөлбөр (securities borrowing and lending programme)</b>	төлбөр тооцооны үүргийг цаг тухайд нь гүйцэтгэх зорилгоор үнэт цаастай холбоотой хийгдэж байгаа зээлийн хэрэгсэл.	<b>SDF</b>
<b>Үнэт цаасны хадгаламжийн байгууллага (Securities depository)</b>	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв-г харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b>
<b>үнэт цаасанд суурилсан үнэт цаасны зээллэгийн гүйлгээ (securities-driven securities lending transactions)</b>	үнэт цаасны зээллэг эсвэл репо хэлцлээр дамжуулан тодорхой үнэт цаасыг зээлдүүлэх/зээлэхтэй холбоотой хийгдэх гүйлгээ.	<b>SLT</b>
<b>үнэт цаасны зээл (securities loan)</b>	төлбөр тооцооны үүргийг цаг тухайд нь гүйцэтгэх зорилготой, барьцаатай буюу барьцаагүй, үнэт цаасны зээл.	<b>x-border</b>
<b>үнэт цаасны төлбөр тооцооны систем (securities settlement system)</b>	нэг бол жишээ нь, барьцаатай нөхцөлд төлбөргүйгээр (үнэгүй нийлүүлэлт), эсвэл төлбөрийн эсрэг үнэт цаасыг шилжүүлэхийг зөвшөөрдөг систем. Үнэт цаасны төлбөр тооцоо нь төвлөрсөн хадгаламжийн төв (ТХТ)-д байгаа (хувийн ТХТ буюу ТХТ-ийн үүрэг гүйцэтгэж буй төв банкны хоёуланд) данс эсвэл төв банкинд байгаа данс (найдвартай кастодиан үйл ажиллагааны данс)-аар хийгдэнэ. Сүүлийн үед төв банк үнэт цаасны дундын кастодианы үүргийг гүйцэтгэж байна. Эцсийн кастодиан нь ТХТ. Мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоо нь төлбөр тооцооны түншээр дамжуулан банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн системд хийгдэнэ.	<b>Blue Book</b>
<b>үнэт цаасны төлбөр тооцооны систем (securities settlement system)</b>	үнэт цаасны арилжааны төлбөр тооцоо, клиринг, баталгаажуулалт болон үнэт цаасны хадгалалтад зориулагдсан эрх зүйн зохицуулалтын цогц.	<b>SSS</b>
<b>үнэт цаасны хүү (security interest)</b>	үнэт цаасны хүүгийн төлбөрийн үүргийг гүйцэтгэх зорилготой ба үүргээ гүйцэтгээгүй үед худалдагдах боломжтой өмч хөрөнгөд хамаарах хүүгийн хэлбэр.	<b>OTC</b> <b>SLT</b>
<b>тусгаарлалт (segregation)</b>	харилцагчийн эзэмшлийн актив болон позицийг тэдгээрийн хариуцаж буй пүүс, брокерийн компанийн өөрийн актив, позициос тусгаарлан хамгаалах арга.	<b>ETDC</b>

<b>эмиссийн орлого (seigniorage)</b>	түүхээс нь үзвэл, энэ нэр томъёог мөнгөн тэмдэгт үйлдвэрлэгчийн ашигт ноогдох хувь, шимтгэл эсвэл татвар гэсэн ойлголтод хамааруулж хэрэглэдэг. Цаасан мөнгөн тэмдэгтийг нэвтрүүлсэнээр, тухайн мөнгөн тэмдэгтийн зардал нь өөрийн үнээс илэрхий бага тул ихээхэн хэмжээний ашиг бий болдог. Төв банк нь мөнгөн тэмдэгтийн нийлүүлэгчээр монополь байдлаар ажиллаж байгаа тохиолдолд, эмиссийн орлого нь засгийн газрын бодлогын дагуу явагддаг. Эмиссийн орлогыг мөнгөн тэмдэгт болон зоосны дүнг засгийн газрын урт хугацааны үнэт цаасны хүүгээр үржүүлсэнээр үнэлдэг.	<b>EM-CPSS</b> <i>EM-ECB</i>
<b>өөрөө барьцаа болох (self-collateralising)</b>	шилжүүлэх үйл ажиллагааны эрсдэлээс сэргийлэх зорилгоор шилжүүлж буй үнэт цаасыг барьцаа байдлаар ашиглахыг зохицуулсан зохицуулалт.	<b>SDF</b>
<b>зарах-худалдан авах буцаалт (эсвэл худалдан авах-зарах буцаалт) (sell-buybacks (or buy-sellbacks))</b>	нэг нь шууд төлбөр тооцоог хийхэд, нөгөө нь дамжуулагдах төлбөр тооцоог хийхэд зориулагдсан гүйлгээний өөр өөр огноо бүхий нэгэн зэрэг худалдан авах болон худалдах гэсэн хоёр ялгаатай гүйлгээнээс бүрдсэн, буцаан худалдан авахад чиглэсэн, эдийн засгийн ижилхэн үр дүн болон зорилго бүхий гүйлгээ. Ерөнхийдөө, зарах-худалдан авах буцаалт нь зах зээлийн дахин үнэлэх болон маржингийн шаардлагыг зөвшөөрдөггүй.	<b>SLT</b>
<b>илгээгчийн эцэслэлт (sender finality)</b>	үйл ажиллагаа эсвэл эрх зүйн ойлголтоос илүүтэйгээр судалгаа шинжилгээний ойлголт нь тухайн гүйлгээний өдөрт хүлээн авагч-оролцогчийн дансанд мөнгөн хөрөнгийг бэлэн байхаар эцэслэлт хийх нөхцөлт бус үүрэг хөрөнгийн шилжүүлгийн системийн шилжүүлэг эхлүүлэгч-оролцогч талд нэмэгдэж байгааг тайлбарлахад ашиглагддаг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>дэс дугаар (sequence number)</b>	мэдээлэл алдагдах болон хуулбарлагдахаас сэргийлэх зорилгоор мэдээнд хавсаргагддаг дэс дараалсан шинж чанартай дугаар.	<b>EM-Sec</b>
<b>сервер (server)</b>	сүлжээгээр дамжуулан бусад компьютерт үйлчилгээ үзүүлдэг компьютер.	<b>EM-Sec</b>
<b>нэг холболтын түлхүүр (session key)</b>	нэг холболтын үе буюу гүйлгээний хугацаа зэрэг хязгаарлагдмал хугацаанд ашиглагдаад хүчингүй болдог криптографийн түлхүүр.	<b>EM-Sec</b>

<b>тооцоололт (set off)</b>	хоёр талын харилцан хүлээх үүрэг болон нэхэмжлэлийн аль алиныг тооцоолох буюу хүчингүй болгох (эсвэл харилцан хүлээх үүргийн дүнг багасгах) арга. Энэ тооцооллыг хуулийн үндсэн дээр эсвэл гэрээний дагуу хийж болдог.	<b>OTC</b>
<b>төлбөр тооцоо (settlement)</b>	хоёр болон түүнээс дээш талуудын хооронд хөрөнгө эсвэл үнэт цаас шилжүүлэх үүргийг гүйцэтгэхтэй холбоотой үйлдэл. Эцсийн төлбөр тооцоо, нэг бүрчилсэн төлбөр тооцооны систем, үр дүнгийн төлбөр тооцоо, үр дүнгийн төлбөр тооцооны систем-г мөн харна уу.	<b>OTC</b>
<b>төлбөр тооцоо (settlement)</b>	худалдагч талаас худалдан авагч талд үнэт цаас буюу санхүүгийн хэрэгслийг шилжүүлэх болон худалдан авагч тал худалдагч талд мөнгөн хөрөнгө шилжүүлэх үед хийгдэх гүйлгээний дуусгавар. Төлбөр тооцоо нь эцсийн эсвэл болзолт байж болно.	<b>DVP</b> <i>x-border</i> <b>SDF</b>
<b>төлбөр тооцооны агент (settlement agent)</b>	шилжүүлгийн системийн төлбөр тооцооны процесс (жишээ нь, төлбөр тооцооны позицийг тодорхойлох, төлбөрийн солилцоонд мониторинг хийх зэрэг) болон төлбөр тооцоонд шаардлагатай бусад зохицуулалтыг удирдах байгууллага.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>төлбөр тооцооны хөрөнгө (settlement asset)</b>	төлбөрийн системийн дүрэм, журам эсвэл нийтлэг практикаар тодорхойлогдсон төлбөр тооцооны үүргийг гүйцэтгэхэд ашиглагдах хөрөнгө.	<b>Core</b> <b>Principles</b>
<b>төлбөр тооцооны банк (settlement bank)</b>	мөнгөн төлбөр тооцоог гүйцэтгэж байгаа төв банк эсвэл хувийн банк.	<b>ETDC</b>
<b>төлбөр тооцооны банк (settlement bank)</b>	өөрийн болон зах зээлийн бусад оролцогчийн нэрийн өмнөөс үнэт цаасны шилжүүлгийн үр дүнгээр үүссэн төлбөрийн үүргийг гүйцэтгэхийн тулд төлбөр тооцооны агентуудын дансыг өөр дээрээ байршуулдаг байгууллага.	<b>SSS</b>
<b>төлбөр тооцоо хийх огноо (settlement date)</b>	үнэт цаасны гүйлгээнд оролцогч талуудын төлбөр тооцоо хийхийг тохирсон огноо. Зарим тохиолдолд төлөвлөсөн огноог хэлцлээр хүлээсэн төлбөр тооцооны огноо гэж тооцдог.	<b>x-border</b> <b>SDF</b>
<b>төлбөр тооцоо эцсийн байх (settlement finality)</b>	эцсийн төлбөр тооцоо-г харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>



<b>төлбөр тооцооны байгууллага (settlement institution)</b>	төлбөр тооцооны систем дотроо төлбөр тооцоог хийж гүйцэтгэх зорилгоор оролцогчдын хооронд хийгдэж буй шилжүүлгийг бүртгэлдээ тусгаж байгаа байгууллага. Хоёр талын үр дүнгийн төлбөр тооцооны систем, олон талын үр дүнгийн төлбөр тооцооны систем, агент, төлбөр тооцоонд оролцогч/гишүүн-г мөн харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>төлбөр тооцооны интервал (settlement interval)</b>	арилжаа хийгдэх өдөр (T) болон төлбөр тооцоо хийгдэх өдөр (S)-ийн хоорондын урсан өнгөрөх цаг хугацааны хэмжээ. Арилжаа хийгдсэн өдрөөр хэмжигддэг. Жишээ нь хэрэв 3 өдөр өнгөрөхөөр байвал, төлбөр тооцоо хийх интервал нь T+3 байна.	<b>x-border</b> <b>SLT</b> <b>SDF</b>
<b>төлбөр тооцооны мөчлөг (settlement lag)</b>	хөрөнгийн дүнгээр солилцох (exchange-for-value) явц дахь арилжаанд орох болон төлбөрийн зориулалтаар санхүүгийн хөрөнгийн эцсийн солилцоог хийх замаар төлбөр гүйцэтгэх ажиллагааны хоорондох хугацааны зөрүү. Төлбөрийн мөчлөг-г харна уу.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>
<b>төлбөр тооцооны үүрэг (settlement obligation)</b>	төлбөрийн клиринг хийсний үр дүнд санхүүгийн аль нэг байгууллага бусад байгууллагад төлбөл зохих дүн. Цэвэр кредит (эсвэл дебит) позици-г харна уу.	<b>Core</b> <b>Principles</b>
<b>төлбөр тооцооны эрсдэл (settlement risk)</b>	шилжүүлгийн системд төлбөр тооцоо хүлээгдэж байснаараа хийгдэхгүй болох үед үүсэх эрсдэлийг тодорхойлдог ерөнхий нэр томъёо. Энэхүү эрсдэл нь зээлийн болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдлийг хоёуланг нь агуулдаг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <b>SDF</b> <b>Retail</b>
<b>төлбөр тооцооны эрсдэл (settlement risk)</b>	оролцогч тал гэрээний нөгөө тал эсвэл төлбөр тооцооны агентын өмнө төлбөр тооцооны нэг буюу түүнээс дээш үүргээ гүйцэтгэж чадахгүй болох үед үүсэх эрсдэл.	<b>DVP</b>
<b>төлбөр тооцооны систем (settlement system)</b>	мөнгөн хөрөнгийн эсвэл санхүүгийн хэрэгслийн шилжүүлгийн төлбөр тооцоог хийхэд ашиглагдаж буй систем.	<b>Blue Book</b> <b>EM-CPSS</b> <b>EM-ECB</b>

<b>төлбөр тооцоонд оролцогч/гишүүн (settling participant/member)</b>	зарим нэг улс оронд мөнгөн хөрөнгийн эсвэл үнэт цаасны шилжүүлгийн системийн төлбөр тооцоо гүйцэтгэгч-оролцогч нь систем дэх мөнгөн хөрөнгийн төлбөр тооцоог хийх эсвэл үнэт цаасыг шилжүүлэх зорилгоор төлбөр тооцооны байгууллага дээр байршуулсан нэг болон түүнээс олон дансаараа дамжуулан бусад төлбөр тооцоо гүйцэтгэгч-оролцогч талд/талаас хөрөнгө болон үнэт цаасыг дамжуулж, хүлээн авч байдаг. Бусад оролцогч нарын хувьд өөрсдийн позицийн төлбөр тооцоог хийхийн тулд төлбөр тооцоо гүйцэтгэгч-оролцогчийн үйлчилгээг авдаг. Одоогийн байдлаар Европын холбоонд шууд оролцогчийг төлбөр тооцоо гүйцэтгэгч-оролцогч гэж тодорхойлдог. Шууд оролцогч/гишүүн болон давхар зохицуулалт-г харна уу.	<b>Red Book</b>
<b>хувьцааны цахим бүртгэлийн систем (share book-entry system)</b>	биет бус хэлбэртэй хувьцааны үнэт цаасыг гаргах болон бүртгэх зориулалт бүхий компьютержсэн систем. цахим бүртгэлийн систем, дебит цахим бүртгэлийн систем-г мөн харна уу.	<b>Blue Book</b>
<b>богино борлуулалт (short sale)</b>	худалдагч тал нь эзэмшдэггүйн улмаас шилжүүлэх хугацааг зайлшгүй тооцдог үнэт цаасны борлуулалт. Энэ аргачлалыг (1) үнийн хувьд урьдчилан таамагласан бууралтыг тооцох эсвэл (2) урт позицийн үеийн ашгийг хамгаалах зорилгоор хэрэглэдэг. Богино позици гэж мөн нэрлэдэг.	<b>SLT</b>
<b>нэг зорилготой урьдчилсан төлбөрт карт (single-purpose prepaid card)</b>	карт гаргагч болон үйлчлэгч (карт хүлээн авагч) байгууллага нь нэгэн ижил байгууллага байх ба ингэснээрээ карт гаргагчийн зах зээлд нийлүүлсэн тодорхой бараа, үйлчилгээний урьдчилсан төлбөрийг төлөөлж буй үнэ цэнийг агуулсан карт. Урьдчилсан төлбөрт карт-г харна уу.	<b>EM-ECB</b>
<b>смарт-карт (smartcard)</b>	тооцоолол гүйцэтгэх чадвартай микропроцессор бүхий интеграл схемт карт	<b>EM-Sec</b> <b>EM-CPSS</b> <b>EM-ECB</b>
<b>програм хангамжид суурилсан бүтээгдэхүүн (software-based products)</b>	интернет гэх мэтийн харилцаа холбооны сүлжээгээр дамжуулан цахим үнэ цэнийг шилжүүлэхэд голчлон ашиглагдах, компьютерын тусгай програм хангамжийн тусламжтай ажилладаг цахим мөнгөний бүтээгдэхүүн.	<b>EM-ECB</b>

<b>тусгай барьцаа (special collateral)</b>	ямар ч үед зах зээл дээр зээлдэгч нарт ихэд эрэлттэй байдаг үнэт цааснууд. Ерөнхий барьцааны зонхилох репо хүүтэй харьцуулахад ийм тусгай үнэт цаасны репо хүү нь нилээд дээгүүр байх хандлагатай байдаг. Мөн “тусгай” гэж нэрлэгддэг. Ерөнхий барьцаа-г мөн харна уу.	<b>SLT</b>
<b>ҮЦТТС (SSS)</b>	Үнэт цаасны төлбөр тооцооны ситем (ҮЦТТС)–г харна уу.	
<b>холбогдох этгээд (stakeholder)</b>	төлбөрийн системийн хувьд холбогдох этгээдийг системийн ажиллагаа ашиг сонирхолд нь нөлөөлдөг талууд гэж тодорхойлдог.	<b>Core Principles</b>
<b>тэмдэгтийн хураамж (stamp duty)</b>	сертификат, төлбөрийн баримт зэрэг эрх зүйн баримт бичигт тамга дарахад гарах зардлын хэлбэрээр оноогдох татвар.	<b>SLT</b>
<b>тогтмол шилжүүлгийн даалгавар (standing order)</b>	тухайлан заасан зээлдүүлэгч талд тогтмол дүнгээр байнга хийх төлбөрийг гүйцэтгэх тухай харилцагчаас өөрийн банкинд ирүүлсэн даалгавар.	<b>Red Book Blue Book Retail</b>
<b>саармагжуулалт (sterilisation)</b>	гадаад валют худалдан авах гэх зэрэг бусад санхүүгийн гүйлгээгээр бий болсон банкны нөөц (төлбөр түргэн гүйцэтгэх чадварт шаардагдах хөрөнгө)-ийг бууруулахад чиглэдэг, төв банкны ажиллагаа (нээлттэй захын худалдаа гэх мэт).	<b>EM-CPSS</b>
<b>хуримтлалын карт (stored value card)</b>	мөнгөн хөрөнгийн бүртгэл дээр нэмэгдэж болон хорогдож бичигдэж болдог урьдчилсан төлбөрт карт. Цахим хэтэвч гэж мөн нэрлэгддэг.	<b>EM-Sec EM-CPSS</b>
<b>нэвт боловсруулалт (straight through processing)</b>	анхны шатны арилжааны системээс арилжааны дэлгэрэнгүйг шууд хүлээн авдаг, өгөгдлийг дахин оруулах буюу дахин өөрчилдөггүй төлбөр тооцооны даалгавар болон баталгаажуулалтын бүрэн автоматжуулагдсан ажиллагаа.	<b>OTC</b>
<b>нэвт боловсруулалт (straight through processing)</b>	автоматжуулагдсан системд зөвхөн ганц удаа гар аргаар оруулсан арилжааны мэдээлэлд үндэслэсэн төлбөр тооцооны ажиллагаа буюу урьдчилсан төлбөр тооцооны гүйцэтгэл.	<b>SSS</b>
<b>стресс тест (stress testing)</b>	хэт үнэ болон нөлөөт хувирлын сценарийн бодит байдлаас үүсэн бий болох зээл болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын алдагдлын үнэлгээ.	<b>ETDC</b>
<b>дэд кастодиан (subcustodian)</b>	нэг кастодиан (глобал кастодиан) нь өөрийн үнэт цаасыг өөр кастодиан (дотоодын кастодиан)-аар дамжуулан эзэмшиж буй үед хоёр дахь кастодианыг дэд кастодиан гэж үздэг.	<b>SDF</b>

<b>орлуулалт (substitution)</b>	хүлээсэн үүрэгтэй холбогдуулан нэг оролцогч талыг өөр оролцогч талаар орлуулах. Үр дүнгийн болон төлбөр тооцооны хувьд энэ нэр томъёо нь хоёр талын хооронд байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах процесст хамаарна. Ингэснээр гуравдагч этгээд хоёр талын аль алины хувьд гэрээний нөгөө тал болж, хоёр талын хоорондын эх гэрээг хангаж, үүргээ гүйцэтгэх юм. Гэрээгээр хүлээсэн өмнөх үүргийг өөр үүргээр солих-г мөн харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>орлуулалт (substitution)</b>	хүлээсэн үүргийн хувьд нэг талыг нөгөөгөөр солих ажиллагаа. Фьючерс эсвэл опшингийн клирингийн төвийн хувьд энэ нэр томъёо нь гэрээний худалдагчийн хувьд худалдан авагч, худалдан авагчийн хувьд худалдагч болж байгаа клирингийн төвийн оролцоонд хамаардаг.	<b>ETDC</b>
<b>орлуулалт (substitution)</b>	зээлдэгдсэн үнэт цаасыг зээлдэгчээс эргүүлэн татах ба түүнийг зээллэгийн туршид зах зээлийн ижил үнэ цэнэ бүхий бусад үнэт цаасаар солих.	<b>SLT</b>
<b>санхүүгийн байгууллагуудын хяналт шалгалт (supervision of financial institutions)</b>	санхүүгийн байгууллага нь бизнесийн үйлдэлтэй холбоотой үүсэх эрсдэлийг хангах зохистой нөөц болон хөрөнгийг эзэмшиж байгаа эсэх, найдвартай болон тогтвортой байдалтайгаар үйл ажиллагаа нь явагдаж байгааг баталгаажуулахад чиглэсэн хууль, дүрэм болон бусад шаардлагыг хангаж буй эсэхийг үнэлэх үнэлгээ.	<b>Core Principles</b>
<b>нэмэгдэл шимтгэл (surcharge fee)</b>	АТМ эзэмшигчийн тогтоосноор АТМ-ийг суурилуулах болон засвар үйлчилгээний зардалтай холбоотойгоор карт эзэмшигчээс АТМ эзэмшигчид төлж буй гүйлгээний шимтгэл.	<b>Retail</b>
<b>үлдэгсдийн төлбөр (survivors pay)</b>	аль нэг оролцогч төлбөр тооцоо хийх чадваргүй болсон тохиолдолд, урьдчилан тодорхойлсон дүрмийн дагуу тэсвэрлэж үлдэж чадсан оролцогч талд алдагдлыг үүрүүлэх тухай алдагдал хуваах тохиролцоо.	<b>Core Principles</b>
<b>своп (swap)</b>	тусгай дүрмийн дагуу ирээдүйн тодорхой нэгэн хугацаанд хэлцэлд оролцогч хоёр талын хооронд төлбөр солилцох тухай тохиролцоо.	<b>OTC</b>

**СВИФТ  
(SWIFT)**

Дэлхий дахины банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг: Дэлхий даяар санхүүгийн байгууллага (брокер-дилерийн болон үнэт цаасны компанийг оролцуулан)-уудын хооронд төлбөрийн болон бусад санхүүгийн мэдээг солилцох сүлжээг хариуцан ажлуулж буй банкуудын үүсгэн байгуулж, хувь эзэмшдэг хамтарсан байгууллага. СВИФТ төлбөрийн мэдээ нь хөрөнгийн шилжүүлгийн даалгавар болдог: хөрөнгө (төлбөр тооцоо)-ийн солилцоо нь төлбөрийн систем эсвэл корреспондент банкны харилцаа холбоогоор дамжин хийгддэг.

**Red Book  
Blue Book**

**свитчийн шимтгэл  
(switch fee)**

сүлжээний байгууллагын тогтоосноор карт гаргагч байгууллагаас гүйлгээний мэдээлэл дамжуулах зардалтай холбоотойгоор сүлжээний байгууллагад төлж буй гүйлгээний шимтгэл.

**Retail**

**тэгш хэмт криптограф  
(symmetric cryptography)**

алгоримтын хослолын дагуу нэг ижил нууцлалын түлхүүрийг төхөөрөмжүүд нь харилцан солилцдог криптографын аргачлалын бүрдэл. Инкриптийн хувьд, нэг ижил түлхүүр нь инкрипт болон дикриптэд хэрэглэгдэх ба дикриптын алгоримт нь инкриптын алгоримтын урвуу ажиллагаа байдаг.

**EM-Sec**

**системийн хувьд нэн чухал төлбөрийн систем  
(systemically important payment system)**

хэрэв систем нь дотооддоо эрсдэл, саатлаас хангалттай бус хамгаалагдсан бол энэ байдал цаашлаад оролцогчдын дундын саатал эсвэл санхүүгийн илүү өргөн хүрээнд системийн саатлыг үүсгэх буюу дамжуулах боломжтой төлбөрийн системийг системийн хувьд нэн чухал төлбөрийн систем гэнэ.

**Core  
Principles**

**системийн саатал  
(systemic disruption)**

төлбөрийн системээр дамжин өнгөрч байгааг оролцуулан санхүүгийн нэг байгууллагаас нөгөөд дамжуулснаар санхүүгийн системийн тогтвортой байдалд аюул учруулж болзошгүй нөлөөлөл. Системийн эрсдэл-г мөн харна уу.

**Core  
Principles**

<b>системийн эрсдэл (systemic risk)</b>	шилжүүлгийн системийн эсвэл санхүүгийн зах зээлийн нэг оролцогч хүлээсэн үүргээ биелүүлэх чадваргүй болсноос шалтгаалж тухайн үед бусад оролцогчийг эсвэл санхүүгийн байгууллагыг үүргээ (шилжүүлгийн системийн төлбөр тооцооны үүргийг оролцуулан) гүйцэтгэх боломжгүй болгох эрсдэл. Нэг оролцогчийн дампуурал нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар эсвэл зээлийн томоохон асуудлыг үүсгэж, цаашлаад энэ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх боломжтой байдаг.	<b>Red Book</b> <b>Blue Book</b> <i>EM-CPSS</i> <b>ETDC</b> <b>OTC</b>
<b>хөндлөнгийн оролцоо-эд мөрийн баримт (tamper-evident)</b>	биет халдлагын эд мөрийн баримтыг харуулах төхөөрөмжийн чадвар.	<b>EM-Sec</b>
<b>хөндлөнгийн оролцоо-нотолгоо (tamper-proof)</b>	бүхий л халдлагыг эсэргүүцэх чадвар бүхий төхөөрөмжийн баталгаажсан чадвар.	<b>EM-Sec</b>
<b>хөндлөнгийн оролцоо-эсэргүүцэл (tamper-resistant)</b>	тодорхой төвшинд биет халдлагыг эсэргүүцэх төхөөрөмжийн чадвар.	<b>EM-Sec</b> <i>EM-CPSS</i> <b>EM-ECB</b>
<b>TARGET (TARGET)</b>	Транс-Европын Автоматжуулагдсан Бодит цагийн Нэг бүрчилсэн төлбөр тооцооны Шуурхай шилжүүлэг: TARGET систем нь Европын валютын холбооны гурав дахь үе шат болон Европын төв банкны төлбөрийн бүтцэд оролцдог улс бүрийн бодит цагийн системүүдээс бүрдсэн төлбөрийн систем гэж тодорхойлогддог. Бусад шууд бус оролцогч нарын бодит цагийн систем ч холбогдож болдог. Эдгээрийн хувьд еврогоос гадна өөрсдийн мөнгөн тэмдэгтээр төлбөр тооцоо хийх боломжийг гарган өгсөн байдаг. Орон нутгийн бодит цагийн системүүд болон Европын төв банкны төлбөрийн бүтэц нь Евро бүс даяар хил дамнасан шилжүүлгийг нэгээс нөгөө системд шилжүүлэхийг зөвшөөрсөн (харилцан холболт) ерөнхий аргачлалын дагуу харилцан холбогдсон байдаг. Харилцан холболт-г мөн харна уу.	<b>Blue Book</b>
<b>Ти-Си-Пи/Ай Пи TCP/IP</b>	дамжуулалтын хяналтын протокол/Интернэт протокол: харилцаа холбоо болон хаягжуулалтын протоколд өргөн хэрэглэгддэг бүрдэл; TCP/IP нь интернэтийн харилцаа холбооны стандарт бүрдэл гэж тооцогддог.	<b>EM-Sec</b>
<b>телематик (telematics)</b>	өгөгдөл боловсруулах болон өгөгдөл дамжуулах аргачлалын хосолсон ашиглалт.	<b>Red Book</b> <b>Blue Book</b>

<b>банкны бэлэн мөнгөний чек (teller's cheque)</b>	банкны вексель-г харна уу.	<b>Red Book</b> Blue Book
<b>хугацаатай хэлцэл (term transactions)</b>	джжсах өдөр буюу биелэгдэх хугацаатай хэлцэл.	<b>SLT</b>
<b>давхар зохицуулалт (tiering arrangement)</b>	гүйлгээгээ солилцох болон/эсвэл төлбөр тооцоогоо гүйцэтгэхэд өөр категорийн оролцогчийн үйлчилгээ шаардлага болдог нэг категорийн оролцогчийн мөнгөн хөрөнгийн буюу үнэт цаасны шилжүүлгийн систем дэх зохицуулалт.	<b>Red Book</b> Blue Book
<b>цагийн дардас (time stamp)</b>	мэдээг үүсгэсэн цагийг үзүүлэх зорилгоор мэдээнд оруулсан тоон утга.	<b>EM-Sec</b>
<b>эзэмшлийн шилжүүлэг (title transfer)</b>	өмч хөрөнгийн эзэмших эрхийг нэгээс нөгөөд шилжүүлэх ажиллагаа. Өмчлөх эрхийн шилжүүлэг нь барьцаалах ажиллагааны нэг арга хэлбэр болон хэрэглэгддэг. Шилжүүлэх хэлбэр нь барьцаагаар ашиглагдаж буй өмчийн эзэмших эрхийг бүхэлд нь шилжүүлэх хэлбэрээр хийгддэг. Өөрөөр хэлбэл барьцаалагч нь тохиролцооны нөхцөлийн дагуу ижил үнэ цэнэтэй хөрөнгийн хүлээн авах тохиролцоо хийж, барьцаа нийлүүлэгч тал нь барьцаа хэлбэрээр тавигдсан хөрөнгийн эзэмших эрхийг шилжүүлдэг.	<b>OTC</b> SLT
<b>бүрэн өгөөжтэй своп (total return swap)</b>	тогтсон хугацаа бүхий OTC (биржийн гадуурх зах зээл) своп. Дилер нь свопын эсрэг тал болж байгаа бэлэн мөнгөний хөрөнгө оруулагч талд зарагдсан хувьцааны нийт өгөөжийг авахыг хүлээн зөвшөөрч, тогтсон хугацаа хүртэл хөвөгч хүүг төлдөг. Бэлэн мөнгөний хөрөнгө оруулагч талын своп дуусгавар болох үед хийгдэх төлбөр нь хөвөгч хүүн дээр нь хувьцааны үнийн уналтыг нэмэх эсвэл үнийн өсөлтийг хассанаар тогтоогддог. Нөгөө талаас, бэлэн мөнгөний хөрөнгө оруулагч нь өөрийн хөрөнгө оруулалтыг нөхөх зорилгоор зах зээл дээр хувьцааг борлуулдаг. Энэхүү зохицуулалтын эцсийн үр дүнд дилер нь тухайн цаг хугацаанд өөрийн хувьцааг барьцаалан хөвөгч хүүтэйгээр бэлэн мөнгийг зээлдэг. Дилер нь үнэт цаасыг зээлдүүлэхтэй эдийн засгийн хувьд ижилхэн үйлчилгээ болон санхүүжүүлэлтийг эрж хайх замаар хувьцааны шууд арилжааг бүрэн өгөөжтэй своптой хослуулан хийдэг.	<b>SLT</b>

<b>ул мөрийн чадавх (traceability)</b>	цахим мөнгөний системд шилжүүлэгч эсвэл хүлээн авагч хүртэлх өртөг шилжүүлэх гүйлгээний ул мөр үлдээж чадах боломжийн зэрэг.	
<b>арилжааны огноо (trade date)</b>	арилжаа биелэгдэх огноо.	<b>DVP</b> x-border <i>SDF</i>
<b>арилжаа бүрийн төлбөр тооцоо (trade-for-trade settlement)</b>	оролцогч тал хоорондын гүйлгээ нэг бүрийн төлбөр тооцоо.	<b>DVP</b> Red Book Blue Book <i>SDF</i>
<b>арилжаа бүрийн төлбөр тооцооны систем (trade-for-trade settlement system)</b>	шилжүүлгийн даалгавар бүрийн төлбөр тооцоо нь тус тусдаа хийгддэг систем.	<b>DVP</b>
<b>арилжаа тулгах (trade matching)</b>	арилжааны оролцогч талуудаас ирүүлсэн арилжааны мэдээлэл (хэлцлийн тоо ширхэг, гэрээний хугацаа болон үнэ гэх мэт)-ийг нягталж тохируулах ажиллагаа. Клирингийн төв нь арилжаа тулгалт амжилттай болсон үед л арилжааг баталгаажуулдаг.	<b>ETDC</b>
<b>арилжааны үр дүнгийн тооцоолол (trade netting)</b>	арилжааны түнш эсвэл клирингийн системийн гишүүдийн хооронд үнэт цаас болон хөрөнгийн цэвэршүүлсэн дүнгээр арилжааны үр дүнгийн тооцооллыг хийх. Албадлагын бус арилжааны үр дүнгийн тооцооллыг позицийн үр дүнгийн тооцоолол гэнэ.	<b>DVP</b> <i>SDF</i> Red Book Blue Book
<b>арилжааны бүртгэл (trade registration)</b>	тулган тохируулсан арилжааны бүртгэлийн бичилтийг албан ёсоор клирингийн төвд хийх үеийн ажиллагаа. Үнэт цаасны зуучлагчийг төлөөлж байгаа клирингийн төвийн хувьд, бүртгэл нь клирингийн гишүүний нөгөө талыг орлож байгаа гэдэг утгаараа клирингийн төв дээрх цагт хийгдэж болно.	<b>ETDC</b>
<b>гүйлгээний журнал (transaction log)</b>	төхөөрөмжид хадгалж байгаа гүйлгээний дараалсан тэмдэглэл.	<b>EM-Sec</b>



<b>шилжүүлэг (transfer)</b>	ажиллагааны хувьд, хөрөнгө буюу үнэт цаас эсвэл хөрөнгө буюу үнэт цаастай холбоотой эрхийг нэг оролцогчоос нөгөөд дараах байдлаар илгээх (шилжүүлэх) ажиллагаа гэж үздэг. Үүнд: (i) бодит даалгавар/мөнгөний шилжилт; (ii) санхүүгийн зуучлагчийн бүртгэлд дансны бичилт хийгдэх; эсвэл (iii) хөрөнгө болон үнэт цаасны гүйлгээний системээр боловсруулагдан дансны бичилт хийгдэх. Шилжүүлэх үйлдэл нь шилжүүлэгдэж буй мөнгөний үлдэгдэл, үнэт цаас буюу санхүүгийн бусад хэрэгсэлд хамаарал бүхий шилжүүлэгч, хүлээн авагч болон гуравдагч этгээдийн хууль ёсны эрхэд нөлөөлдөг.	<b>Red Book</b> Retail
<b>шилжүүлэх чадвар (transferability)</b>	цахим мөнгөний системд төв байгууллагын харилцан нөлөөлөлгүйгээр төхөөрөмжүүдийн хооронд цахим балансыг шилжүүлж чадах чадварын түвшин.	<b>EM-ECB</b> <i>EM-Sec</i>
<b>шилжүүлгийн систем (transfer system)</b>	ерөнхий нэр томъёо нь банк хоорондын хөрөнгийн шилжүүлгийн систем болон хөрөнгийн дүнгээр солилцох системийг хамардаг.	<b>Red Book</b> Blue Book
<b>аялал жуулчлал, энтертайнментийн карт (travel and entertainment card)</b>	эзэмшигч нь зээлийн эрхтэй болохыг илэрхийлдэг, банк бус байгууллагын гаргасан карт. Энэ нь эзэмшигчийн худалдан авалтад зориулагдсан боловч бусад зээлийн хэлбэрээр ашиглагддаггүй ба нийт өр төлбөр нь тодорхой хугацааны эцэст хийгддэг. Эзэмшигч нь ихэвчлэн жилийн шимтгэл төлдөг. Мөн хураамжтай карт гэж нэрлэгддэг.	<b>Red Book</b> Blue Book Retail
<b>гурван талын репо (tri-party repo)</b>	арилжаа хийгдэж буй хугацааны туршид барьцаа хөрөнгийн хангалттай үнэ цэнийг баталгаажуулж байх үүрэгтэй бие даасан кастодиан банк, клирингийн төв эсвэл үнэт цаасны хадгаламжийн төвд арилжааны оролцогч талаас шилжүүлж байгаа бонд болон бэлэн мөнгөний репо хэлцэл.	<b>SLT</b>
<b>таналт (truncation)</b>	банк доторх, банк хооронд эсвэл банк-харилцагчийн хооронд цаасан төлбөрийн хэрэгслийн биет шилжүүлгийг хэсэгчилсэн эсвэл бүрэн халж эсвэл орлуулах байдлаар тэдгээрийн агуулгыг цахим бичлэг болгон дараагийн боловсруулалт болон дамжуулалтанд хувиргах арга хэмжээ.	<b>Red Book</b> Blue Book
<b>эцсийн төлбөр тооцоо (ultimate settlement)</b>	зарим тохиолдолд төв банкин дахь мөнгөн хөрөнгийн эцсийн төлбөр тооцоо гэсэн утгыг илэрхийлэхэд ашигладаг .	<b>Red Book</b> Blue Book

---

**үлдэгдлийг хаах  
(unwind)**

үнэт цаас болон хөрөнгийн шилжүүлэг нь үр дүнгийн тооцоогоор хийгддэг клирингийн болон төлбөр тооцооны системд өдрийн эцэст нийт оролцогч нар өөрсдийн төлбөр тооцоог барагдуулах хүртэл нийт шилжүүлгийн зохицуулалтыг дагалдан гарах арга хэмжээ. Хэрэв аль нэг оролцогч нь төлбөр тооцоо барагдуулж чадахгүй тохиолдолд, тухайн оролцогчийн хэсэг эсвэл нийт шилжүүлэг системээс хасагдах ба үр дүнгийн төлбөр тооцооллыг дахин гүйцэтгэдэг. Иймэрхүү арга хэмжээ нь төлбөр тооцоо хийгдэхгүйгээс учрах төлбөр түргэн гүйцэтгэх чадвар шаардагдах хөрөнгийн дарамт болон боломжит алдагдлыг бусад оролцогч нарт шилжүүлэх, зарим онцгой тохиолдолд ноцтой болон таамаглаадаагүй системийн эрсдэлээс сэргийлдэг.

**SDF**  
*DVP*  
*Red Book*

---

**үлдэгдлийн хаалт  
(unwinding)**

үнэт цаас болон хөрөнгийн шилжүүлэг нь үр дүнгийн тооцоогоор хийгддэг клирингийн болон төлбөр тооцооны системд өдрийн эцэст нийт оролцогч нар өөрсдийн төлбөр тооцоог барагдуулах хүртэл нийт шилжүүлгийн зохицуулалтыг дагалдан гарах арга хэмжээ. Хэрэв аль нэг оролцогч нь төлбөр тооцоо барагдуулж чадахгүй тохиолдолд, тухайн оролцогчийн хэсэг эсвэл нийт шилжүүлэг системээс хасагдах ба үр дүнгийн төлбөр тооцооллыг дахин гүйцэтгэдэг. Иймэрхүү арга хэмжээ нь төлбөр тооцоо хийгдэхгүйгээс учрах төлбөр түргэн гүйцэтгэх чадвар шаардагдах хөрөнгийн дарамт болон боломжит алдагдлыг бусад оролцогч нарт шилжүүлэх, зарим онцгой тохиолдолд ноцтой болон таамаглаадаагүй системийн эрсдэлээс сэргийлдэг.

**Blue Book**  
ETDC

---

**хэрэглэгч  
(user)**

төлбөрийн системийн хэрэглэгч гэдэгт төлбөрийн үйлчилгээнд оролцогч болон тэдгээрийн харилцагчдыг хамааруулдаг. Харилцагч, шууд оролцогч, шууд оролцогч/гишүүн, шууд бус оролцогч/гишүүн, оролцогч/гишүүн-г мөн харна уу.

**Core**  
**Principles**

---

<b>хэрэглэгчийн төлбөр (user fee)</b>	карт гаргагч байгууллагын тогтоосны дагуу картаар хийсэн төлбөр эсвэл АТМ-ээс мөнгө авахад карт эзэмшигчээс карт гаргагч байгууллагад төлж буй гүйлгээний шимтгэл. Зарим тохиолдолд гадаад шимтгэл гэж нэрлэгддэг хэрэглэгчийн төлөх бусад төлбөр нь карт гаргагч байгууллагын эзэмшлийн биш АТМ-ыг ашигласны төлөө карт гаргагч байгууллагад карт эзэмшигчийн төлөх шимтгэл юм.	<b>Retail</b>
<b>эрсдэлийн өртөг (value-at-risk)</b>	тодорхой итгэлцлийн түвшин (95% гэх мэт)-д тухайн мөчлөг (тухайн ажлын өдөр)-т хүлээж болох байгууллагын алдагдлын дээд хэмжээний үнэлгээ.	<b>ETDC</b>
<b>хэлбэлзлийн маржин (variation margin)</b>	нээлттэй позицийг зах зээлийн үнээр дахин үнэлснээс шалтгаалсан аливаа алдагдал (ашиг)-ыг хаахаар нөгөө хэлцлийн талд төлөх (авах) хөрөнгө.	<b>ETDC</b>
<b>эргэлтийн хурд (velocity)</b>	хугацааны тодорхой мөчлөг дотор эргэх мөнгөний хэмжээний (тухайлбал, мөнгөний агрегатаар бүртгэсэн) давтамжийн дундаж тоо хэмжээ. Мөнгөний хэмжээний эргэлтийн хурдыг нэрлэсэн ДНБ-ийг мөнгөний агрегатад харьцуулсан харьцаагаар тооцдог.	<b>EM-CPSS</b>
<b>цагаан жагсаалт (white list)</b>	картад суурилсан систем дэх бүхий л баталгаажсан картын дугаарын жагсаалтыг агуулсан өгөгдлийн сан.	<b>EM-Sec</b>
<b>хөрөнгийн бөөний шилжүүлгийн систем (wholesale funds transfer system)</b>	их дүнтэй хөрөнгийн шилжүүлгийн систем-г харна уу.	<b>Red Book Blue Book</b>
<b>хүн амын орлогын албан татвар (withholding tax)</b>	хуулийн дагуу өөрийн хадгаламж, үнэт цаас буюу ийм төрлийн санхүүгийн хэрэгслийн хүүгийн төлбөрөөс суутгахаар үүрэг хүлээсэн төлөгч агентын эх үүсвэрээс суутгаж буй орлогын татвар.	<b>SLT</b>
<b>тэг цагийн дүрэм (zero hour rule)</b>	төлбөрийн чадваргүй болсон байгууллагын гүйлгээ нь төлбөрийн чадваргүй болсон нь зарлагдсан өдрийн шөнө дундаас хойш эргэн буцаагдах боломжгүй болох тохиолдлыг авч үзсэн зарим улс орны дампуурлын тухай хуулин дахь зохицуулалт.	<b>ETDC</b>